



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ

МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН ЭМХЭТГЭЛ

(2025 ОН, ДУГААР №1)

УЛААНБААТАР ХОТ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

ЕРӨНХИЙ РЕДАКТОР

Н.Мөнгөнцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга

ДУГААР ЭРХЭЛСЭН РЕДАКТОР

Н.Баасанжав Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.Энхзаяа Сургалт, судалгааны төвийн дарга

Б.Баатар Сургалт, судалгааны төвийн судлаач багш

Сургалт, судалгааны төв
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Тасганы овоо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр,
77104949

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. НЭГ СЭДЭВТ СУДАЛГАА

| | |
|--|----|
| ИРГЭДИЙН ОРОЛЦОО БА ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ ИЛ ТОД БАЙДАЛ (Тоон болон чанарын судалгааны хүрээнд) <i>Д.Өнөржаргал Нийслэл дэх Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын дарга</i> | 6 |
| ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ ДЭХ ХУУЛЬ ЁСНЫ ИТГЭЛИЙГ ХАМГААЛАХ ЗАРЧМЫН ОНОЛЫН ОЙЛГОЛТ, ЗАХИРГААНЫ ШҮҮХИЙН ХЭРЭГЛЭЭ <i>Л.Батбаатар Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч</i> | 27 |

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

| | |
|--|-----|
| Нийгмийн сүлжээ ба Шүүгчийн ёс зүй: ТУРК Б.Сугар, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүн | 50 |
| ХӨДӨЛМӨРИЙН МАРГААНЫ ШҮҮХИЙН ХАРЬАЛЛЫН ЗААГ ЯЛГАА Ч.Хандулам Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга Ж.Баянжаргал Хэргийн хөдөлгөөн хариуцсан референт Б.Оч Хэргийн хөдөлгөөний бүртгэл, дүн шинжилгээ хариуцсан ахлах шинжээч | 58 |
| ГЭР БҮЛИЙН БОЛОН СЭТГЭЛ САНААНЫ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА БА АНХААРАХ ЗАРИМ АСУУДЛУУД Т.Энхгэрэл Шүүхийн захиргааны сургалт судалгааны төв Сэтгэл зүйч-судлаач | 65 |
| ШҮҮХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ Б.Нямаа ШЕЗ-ийн Шүүхийн сургалт судалгааны төвийн Сэтгэл зүйч-судлаач /ССШУ-ны магистр/ | 72 |
| ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД СЭТГЭЛ ЗҮЙЧИЙН ОРОЛЦОО БА ТУХАЙН ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ТООГ БУУРУУЛАХ НЬ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах байр Сэтгэл зүйч, ахлах дэслэгч Б.Бямбажаргал | 86 |
| КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЦАХИМ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ Б.Сайжидмаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах байр Архив, бичиг хэргийн ажилтны албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. | 91 |
| АНУ-ЫН ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА С.Золзаяа | 107 |

ГУРАВДУГААР ХЭСЭГ. ИЛТГЭЛ

| | |
|--|-----|
| “ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛ БА ОЛОН НИЙТИЙН ШҮҮХЭД ИТГЭХ ИТГЭЛ” Д.Зүмбэрэлхам Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Хүндэт Доктор, Профессор | 124 |
|--|-----|

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



*Н.МӨНГӨНЦЭЦЭГ
Ерөнхий эрхлэгч
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга*

Шүүхийн ерөнхий зөвлөл “Шүүх эрх мэдэл” эмхэтгэлийг 2014 оноос хойш улирал тутам эрхлэн гаргаж уншигч танаа шинэ оны эхний дугаараа хүргэж байна.

Монгол Улсын шүүхийн үйл ажиллагаа нээлттэй ил тод байх, иргэдийн оролцоо, тулгамдаж буй асуудал, шүүхийн шинэтгэл зэрэг чухал сэдвийн хүрээнд эрдэмтэн судлаачид ур ухаанаа шигтгэлээ.

Цахим зууны технологийн эрчимтэй хөгжил, хурдацтай өөрчлөлтийн үр дүнд дэлхий даяар хүн бүр албан болон албан бус харилцаа холбоог цахим орчинд үүсгэж буй мэдээллийн хязгааргүй орон зайд бид ажиллаж, амьдарч байна.

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийг дагаад шүүхийн үйл ажиллагаанд шинэ технологийг нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 332 дугаар тогтоолоор баталсан “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого”-ын хүрээнд Шүүхийн цахимжуулалтыг хөгжүүлэх “Цахим шүүх-2.0” төслийн эхний үе шатыг 2024 онд амжилттай хэрэгжүүлж, системийн хөгжүүлэлт нэвтрүүлэлтийн ажлыг эхлүүлээд байна.

Шүүхийн цахимжуулалтыг хэрэгжүүлснээр иргэд шүүхийн үйлчилгээг хурдан шуурхай авах, цаг хугацаа хэмнэх зэрэг олон давуу талтай юм.

Иймд шүүхийн цахимжилттай холбоотой судалгаа, мэдээлэл олон улсын туршлага зэргийг шингээсэн бүтээлүүдийг “Шүүх эрх мэдэл” эмхэтгэлдээ хүлээн авахдаа бид бүхэн баяртай байх болно.

“Шүүх эрх мэдэл” эмхэтгэлийг уншдаг уншигчдадаа чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн ялдамд амжилт бүтээлээр дүүрэн, эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Н.МӨНГӨНЦЭЦЭГ
Ерөнхий эрхлэгч
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга



НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

НЭГ СЭДЭВТ |
СУДАЛГАА



ИРГЭДИЙН ОРОЛЦОО БА ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ ИЛ ТОД БАЙДАЛ

(Тоон болон чанарын судалгааны хүрээнд)



*Д.Өнөржаргал Нийслэл
дэх Захиргааны хэргийн
давж заалдах шатны
шүүхийн Тамгын газрын
дарга*

Хураангуй: Шүүхэд тавих олон нийтийн хяналтын үр нөлөөг нэмэгдүүлж, шүүхийн үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангахад иргэдийн оролцоо чухал юм. Манай улсын шүүх ч мөн энэ арга замыг хөгжлийнхөө зорилго болгож “Алсын хараа” 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогодоо тодорхойлсон. Шүүх нь “Монгол Улсын Шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжлийн бодлого”-ын баримт бичгийг батлахдаа шүүхийн захиргааны үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх арга хэлбэрийг боловсронгуй болгох...” ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Шүүх хуралдаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчийг оролцуулснаар иргэдийн гаргасан саналыг тусгах, нийгмийн хууль зүйн боловсролыг дэмжих, шударга бус байдлыг зогсоох, шударга ёс, тэгш эрх, шүүхийн, бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж улмаар иргэдийн итгэлийг хүлээсэн шүүх төлөвшинө.

Энэхүү судалгаагаар шүүхийн үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлын чанар, үр дүнд нөлөөлж буй хүчин зүйл, цаашид хэрэгжүүлэх болон арга замыг тодорхойлохыг зорьсон.



Abstract: Citizens' participation is important to increase the effectiveness of public control over the courts and to ensure the open transparency of the court's activities. The court of our country also defined this way as the goal of development in the long-term development policy of Mongolia "Vision 2050". In approving the document of "Mongolian Judiciary Organization Development Policy", the court provided for the implementation of "improvement of methods of increasing the participation of judicial representatives..." within the framework of the goal of increasing the quality and availability of court administrative services.

By involving the representatives of the citizens in court hearings, the citizens' opinions will be reflected, legal education of the society will be supported, injustice will be stopped, justice, equal rights, independent independence of the courts will be ensured, and thus a court will be established that has gained the trust of the citizens.

This study aims to determine the factors affecting the quality and results of open transparency in court activities and ways to implement it in the future.

Түлхүүр үгс: Шүүхийн нээлттэй ил тод байдал, иргэдийн оролцоо, эрх зүйн боловсрол.

Key words: Judicial openness, citizen participation and legal education.



Удиртгал

Нийтийн эрх зүйд “Open court” буюу “нээлттэй шүүх” гэдэг ойлголтыг шүүх хуралдааныг нээлттэй явуулах, түүнд оролцох олон нийтийн эрхийг холбон тайлбарладаг. Тодруулбал, шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлын шинж нь түүнийг ажиглагчид нээлттэй, чөлөөтэй боломж олгосон байдлаар илэрхийлэгддэг.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд “Үндсэн хууль, бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”; 10 дугаар зүйлд “тэгш эрхийн үндсэн дээр, ил тод байдлаар, шударга ёсны бүх шаардлагын дагуу бусдын нөлөөнд автагдаагүй, гагцхүү хуульд захирагдах, шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй¹ гэж заасан байдаг нь олон улсын хэмжээнд тавигдах шаардлага, түүний баталгааг илэрхийлж байгаа юм. Доктор, профессор Б.Чимид “Хууль дээдлэх ёсыг хангахад шударга шүүхийн үүрэг” илтгэлдээ “Шударга шүүх байхын эрх зүйн үндэс нь шүүх эрх мэдлийн үндсэн зарчмууд бөгөөд “анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулах нь шүүх эрх мэдлийн үндсэн зарчим” хэмээн үздэг байна².

Доктор Б.Өлзийсайхан “Хүний эрхийн баталгааг хангах олон улсын эрх зүйн суурь хэм хэмжээнд бэхжүүлсэн нь шүүх бие даасан байдлаар ажиллах, шүүгч хараат бусаар хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, гагцхүү хуульд захирагдах харилцан хамаарал бүхий зарчим, шүүх эрх мэдлийн хамгийн гол шинжийг илэрхийлсэн байна” гэжээ.³

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эрхлэн гаргадаг Шүүх эрх мэдэл 2015/№2 сэтгүүлд “2008 онд Нээлттэй нийгэм форумаас АНУ-ын профессор Брент Уайтаар хөндлөнгийн судалгаа хийлгэхэд шүүхэд итгэх итгэлийн түвшин 23.0 хувьтай байсан бол “Trend Lines In Public Perception of Judicial Administration in Mongolia (Comparative Study Based on Nationwide Surveys 2001, 2003, 2005, 2007)” (Sant Maral 2007) 2010 оны нийтлэлд “Сант марал” судалгааны төвийн хийсэн судалгаагаар энэ үзүүлэлт 15 хувьтай болж буурсан байна.⁴

Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Монголын эрх зүйн түүхийн судлаач Б.Баярсайхан “Монгол Улс иргэдэд шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүхийн үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналт тавих, иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлж, шударга шүүхээр шүүлгэх зарчмыг хэрэгжүүлэх туршлага зөвхөн ардчилал хөгжсөн өнөө үед яригдаж буй цоо шинэ сэдэв биш юм. Өмнө нь БНМАУ-ын аливаа шүүх таслах газруудыг

1 НҮБ, Хууль зүйн үндэсний төв. //Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл. -Уб.,1993. 3-4 дэх тал.

2 Чимид,Б. Үндсэн хууль ёс ба үндэсний эрх зүйн тогтолцоо олон улсын симпозиум. //Хууль дээдлэх ёсыг хангахад шударга шүүхийн үүрэг илтгэл. -Уб., 2009. 28 дахь тал.

3 Б.Өлзийсайхан, “Шүүхийн эрх зүй бие даасан салбар эрх зүй болох нь”, //Монголын төр, эрх зүй” сэтгүүл. Уб., 2021-№1(97). 50-67 дахь тал.

4 <http://pdf.usaid.gov>



байгуулах дүрэм /1926.04.16/-ийн 1.1-т “Хошуудын жинхэнэ ардын шүүх таслах газруудад аливаа хэргийг нэг түшмэл ба ард олноор сонгосон хоёр төлөөлөгчөөр шийтгүүлбэл зохино”⁵ гэх мэтээр хуульчлан мөрдөж байсан түүхтэй гэсэн байна.

Баруун Австралийн 25-аас доош насны залуучуудад хууль зүйн үйлчилгээ үнэгүй үзүүлдэг төвөөс “Иргэд шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг зөв тусгаж ойлгох, шүүхийн үйл ажиллагаанд ямар нэгэн хэлбэрээр үр нөлөөтэй оролцох нь иргэдийн эрх зүйн боловсролтой нягт холбоотой гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг. Хууль өөрт нь хэрхэн нөлөөлж байгааг ойлгосноор тухайн хүн нөхцөл байдлынхаа талаар ашигтай шийдвэр гаргах, хуулиар олгосон эрх, үүргээ биелүүлэх нь ямар үр ашигтайг ухамсарлахад шаардагдах мэдлэгтэй болоход олон нийтийн эрх зүйн боловсрол зайлшгүй хэрэгтэй бөгөөд “Бүх нийтийн эрх зүйн боловсрол нь хууль зүйн зөвлөгөөтэй адил биш гэдгийг санах нь чухал” гэжээ⁶. Америкийн нэгдсэн улсын Сентфордын хуулийн их сургуулийн зочин профессор Майкл Ж.Бройд /Bedzow, By Michael J. Brojde/ нь “Математик, шинжлэх ухаан, англи хэл, түүхийн нэгэн адил хууль нь бага, дунд, ахлах ангид заадаг хичээл байх ёстой бөгөөд ингэснээр сурагчид илүү хариуцлагатай насанд хүрэгчид болж чадна. Илүү өргөн хүрээнд авч үзвэл, бага насны хүүхдүүдэд шүүхийн талаар, хууль тогтоох байгууллагын талаар ойлголт өгөх нь тэдэнд амьдралынх нь олон салбарт өрсөлдөх, нийгмийн харилцаанд ороход чухал ач холбогдолтой сэтгэн бодох чадварыг эзэмшүүлнэ” гэж үздэг байна.⁷ George, Anitha Rinu, “Why Teaching Basic Law and Legal Education in Schools is Crucial”, 2023 оны нийтлэлдээ “Бат бөх суурь нь өндөр байгууламжийг дэмждэгийн адилаар сургуулиудад эрх зүйн анхан шатны мэдлэг олгох нь шударга ёсонд суурилсан нийгмийн үндэс суурийг бүрдүүлдэг” юм.⁸ “Every other” нь хүний эрхийг хангах зорилготой Их Британы дижитал сэтгүүл зүйн буяны байгууллагын төвийн 2018 оны тайланд “Сургуулиудад олон нийтийн эрх зүйн боловсрол дутмаг гэж олон хүн үзэж, олон залуус эрхийнхээ цар хүрээг мэддэггүй байна. Эрх зүйн мэдлэг, ур чадвартай, идэвхтэй оролцоотой, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэхийн тулд тэдэнд зориулсан цуврал видео бэлтгэх шаардлагатай байна”.⁹ гэх мэтээр эрх зүйн боловсролыг бага наснаас эхлэн олгохын ач холбогдлыг судлан, ач холбогдлыг дурдсан нь цөөнгүй байна. Түүнчлэн “Every other” нь хүний эрхийг хангах зорилготой Их Британы дижитал сэтгүүл зүйн буяны байгууллагын төвөөс хийсэн судалгаанд хамрагдагсдын 76 хувь нь хүүхэд, залуучуудад хуулийн талаар суралцах боломж хангалтгүй гэж үзсэн бол ердөө 7% нь энэ хууль тэдний амьдралд огт нөлөөлсөнгүй гэж

5 (Баярсайхан, Баянбилэг 2010) (Баярсайхан, Баянбилэг 1990)

6 Youth legal Services, YLS. (2023) “The importance of community legal education.

7 Bedzow, By Michael J. Brojde & Ira. (2019) “Education week.

8 George, Anitha Rinu. (2023) “Why Teaching Basic Law and Legal Education in Schools is Crucial.

9 Centre, Bingham. (2022) “Each Other.



үзсэн байна.¹⁰ Эдгээрээс үзэхэд эрх зүйн боловсролыг хүүхэд наснаас нь олгох хандлага дэлхийн улс орнуудад нийтлэг байна.

Судлаач С.Номингэрэл, Т.Гангэрэл нарын “ Шүүх эрх мэдэл сэтгүүл”-д 2020 онд нийтлүүлсэн “Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх арга зам, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо” сэдэвт өгүүлэлдээ шүүхийн захиргааны ажилтнуудаас авсан асуумжаар “Шүүх хуралдаанд нэг иргэдийн төлөөлөгч оролцуулахын тулд 25-40 хүнтэй холбогдох шаардлага үүсдэг” гэж. Шүүхэд иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэдийн эрх зүйн боловсролын талаарх асуумжид “шүүхэд ирэхдээ шүүхийн иргэдийн төлөөлөгч гэж хэн болох, шүүх хуралдаанд оролцуулж буй зорилго нь ямар ач холбогдолтой талаар ямар ч ойлголтгүй, төвөгшөөсөн хандлагатай байдаг”. Тухайн жилд сонгогдон шалгарсан иргэдийн төлөөлөгчдөд зориулсан нэгдсэн сургалтыг шүүхийн тамгын газраас зохион байгуулах ёстой ч энэ сургалтад иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтад орсон бүх иргэд хамрагддаггүй. Нөгөө талаар иргэдийн эрх зүйн боловсрол дутмаг хэвээр байна¹¹ гэжээ. “Нээлттэй нийгэм форум” ТББ менежер П.Бадамрагчаа нь “Шүүхэд хэрэг маргааныг хянан хэлэлцэх ажиллагаа дахь иргэдийн оролцоо” судалгааны явцад Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хийсэн “Шүүх хуралдааны ажиглалтын тайлан”-даа “Иргэдийн төлөөлөгчдийн санал шүүхийн шийдвэрт төдийлөн нөлөөлдөггүй, эрх зүйн мэдлэг муутайн улмаас нотлох баримт шинжлэхэд оролцохгүй, асуулт асуухгүй, шүүгч нарын аяыг харсан, цаг нөхцөөсөн байдалтай байна¹² гэж дүгнэж байжээ. Судлаач Ж.Содномдаржаа, Г.Давааням нар “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан”-даа “Шүүгч шүүхийн шийдвэр гаргах, шүүхийн шийдвэрийг бичихдээ иргэдийн төлөөлөгчийн санал, дүгнэлтэд бараг ач холбогдол өгдөггүй. Хамгийн өндөр хувьтай тусгаж буй захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт гэхэд л ердөө 40 хувьд нь, 1-2 өгүүлбэрт багтаан товч байдлаар тусгасан байна. Шүүхийн шийдвэрт иргэдийн төлөөлөгчийн санал дүгнэлтэд анализ хийж, үндэслэл болгосон нэг ч тохиолдол байхгүй байна¹³ гэжээ. “Нээлттэй нийгэм форум” ТББ менежер П.Бадамрагчаа “Шүүхэд хэрэг маргааныг хянан хэлэлцэх ажиллагаа дахь иргэдийн оролцоо” судалгааны тайландаа “Манай улсын чиг хандлагыг судлаачид “hybrid” гэж тодорхойлсон. Энэ загвар нь иргэдийн оролцооны уламжлал багатай, иргэдийн эрх зүйн мэдлэг ухамсар ерөнхийдөө доогуур, эрх зүйн хувьд чадавхжуулах нь нэн тэргүүний асуудал болсон, шилжилтийн шатандаа байгаа улс орнуудын хувьд эрсдэл багатай загвар байж чадна гэх мэтээр иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдал, үр

10 Centre, Bingham. (2022) “Each Other.

11 Асуумж. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн захиргааны ажилтнуудаас авсан асуумж., 2020

12 Бадамрагчаа, П. ННФ ТББ менежер, Шүүхэд хэрэг маргааныг хянан хэлэлцэх ажиллагаан дахь иргэдийн оролцоо. Бодлогын асуудал. СХДШүүхийн Шүүх хуралдааны ажиглалтын тайлан. 2010.

13 (Содномдаржаа, Давааням, 2019)



нөлөөний талаар ойролцоо агуулга бүхий дүгнэлт хийсэн байна.¹⁴


Иймээс иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, шүүхийн талаарх мэдээллийг олж авдаг арга хэрэгслийг оновчтой болгох, шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудлуудын шалтгаан нөхцөлийг судалж, дүгнэлт хийх зорилгоор хэрэгжүүлж болох сайн туршлага, арга замыг эрэлхийлэн энэхүү сэдвийг сонгож, судалгааг явууллаа.

СУДАЛГААНЫ АРГА:

Судалгааг Ф. Гальтоны (1874) анкетын аргаар судалгааны зорилго, зорилттой уялдуулан, шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын зарчмыг олон нийтэд хүртээмжтэй, тэгш эрхийг ханган хэрэгжүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлс, шүүхийн захиргааны байгууллагын зохион байгуулж буй ажлын үр дүн, өнөөгийн байдлыг олон нийтийн зүгээс үнэлсэн үнэлэмж, түүний шалтгааныг тодорхойлох зорилтын хүрээнд судалгааны мэдээллийг санал асуулга, тоон болон чанарын аргаар авч, статистикийн SPSS 26.0 программаар судалгааны ажлын үнэмшлийг тогтоов. Судалгаанд Монгол Улсын Нийслэлийн 9 дүүргийн хөдөлмөрийн насны хүн амын төлөөлөл хамрагдсан. Судалгаа санамсаргүй түүврийн аргаар хийсэн шүүхээр үйлчлүүлж байсан болон шүүхээр үйлчлүүлж байгаагүй нийт 228 хүнийг хамруулав.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

График-3. Та шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод гэж боддог уу?



¹⁴ Бадамрагчаа, П. ННФ ТББ менежер, Шүүхэд хэрэг маргааныг хянан хэлэлцэх ажиллагаан дахь иргэдийн оролцоо. Бодлогын асуудал. СХДШүүхийн Шүүх хуралдааны ажиглалтын тайлан. 2010.



Бидний хийсэн судалгаанаас харахад шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байдаг гэж 25.9 хувь нь үзсэн бол, шүүхийн үйл ажиллагааны талаар огт мэдэхгүй гэж 30.7 хувь нь, үгүй гэж 43.4 хувь нь хариулжээ. Үүнээс үзэхэд судалгаанд оролцогчдын 74.1 хувь нь шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод биш гэж бодож байгаа нь шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал хангалтгүй гэж үзэхээр байна.

Судалгаанд хамрагдсан 228 хүнээс 18-24 насныхан хамгийн идэвхтэй буюу 33.6 хувь нь, хүйсийн хувьд 61.7 хувь нь эмэгтэйчүүд, боловсролын хувьд 67.1 хувь нь дээд боловсролтой иргэд, ажил эрхлэлтийн хувьд 59.9 хувь нь төрийн албан хаагчид байгаа нь судалгааны үр дүнг бодитой гаргахад хувь нэмэр оруулсан.

Эдгээрээс шүүхийн ил тод байдлын талаар өгсөн хариултыг нь мэргэжлийн байдлаар нь ангилж үзвэл багш нарын олонх нь энэ асуудлыг сонирхдоггүй, эрүүл мэндийн чиглэлийн мэргэжилтэй хүмүүс болон онцгой байдлын алба хаагчид шүүхэд итгэхгүй байх нь давамгай, санхүү болон нягтлан бодогч мэргэжилтэй хүмүүсийн 50 орчим хувь нь шүүхийн үйл ажиллагаа ил тод бус гэж, 43.7 хувь нь энэ асуудлыг сонирхдоггүй гэж хариулсан. Харин төрийн захиргаанд ажилладаг хүмүүс бүгд шүүхийн ил тод байдалд огт сэтгэл ханамжгүй гэж хариулсан нь анхаарал татаж байна.


Хуулийн сургуулийн оюутнуудын 60 хувь нь шүүхийн үйл ажиллагаа ил тод байдаг гэж, 30 хувь нь ил тод биш гэж үзсэн бол эрх зүйч мэргэжилтэй боловч хуульч биш хүмүүсийн 36.4 хувь нь шүүх ил тод гэж, 42.4 хувь нь шүүхийн үйл ажиллагаа ил тод биш гэж, үлдсэн 21.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Харин хуульч нарын 33.3 хувь нь шүүхийн ил тод байдалд итгэж, 33.3 хувь нь шүүх ил тод биш гэж хариулсан бол үлдсэн 33.3 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Үүнээс үзвэл хуульч, эрх зүйч мэргэжилтэй, эрх зүйчээр сурч байгаа хүмүүсийн 41.3 хувь нь шүүхийн ил тод байдалд итгэдэг, 39.1 хувь нь итгэдэггүй, 17.4 хувь нь шүүхийн ил тод байдлын талаар сонирхдоггүй гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Судалгаанд оролцогчдыг насны байдлаар нь ангилж шүүхийн ил тод байдлын талаарх хариултыг нь харьцуулж үзвэл 18-45 насны иргэдийн 40 буюу түүнээс дээш хувь нь шүүхийн үйл ажиллагааг ил тод биш гэж үздэг, ялангуяа 31-35 насны иргэдийн 55.2 хувь нь шүүхийн үйл ажиллагаа ил тод биш гэж хариулсан байгаа нь ажиглагдлаа. Харин 46-50 насны иргэдийн 44.4 хувь нь шүүхийн ил тод байдалд итгэдэг бол 33.3 хувь нь шүүхийн үйл ажиллагаа ил тод биш гэж хариулсан нь насны бүлгүүдийн дотор хамгийн эерэг хариулт өгсөн хэсэг байлаа. Харин 50 болон түүнээс дээш насны иргэд шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг мэддэггүй буюу энэ асуудлыг сонирхдоггүй байна.



Оролцогчдыг боловсролоор нь ангилж үзвэл дунд болон тусгай дунд боловсролтой иргэдийн 56.7 хувь нь шүүхийн үйл ажиллагаа ил тод биш гэж, үүнээс тусгай дунд боловсролтой иргэдийн 70.6 хувь нь шүүхийн үйл ажиллагаа ил тод биш гэж хариулсан байгаа нь хамгийн өндөр хувьтай сөрөг хариулт байлаа. Харин бакалаврын түвшний боловсролтой иргэдийн 23 хувь нь шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод гэж, 42 хувь нь ил тод биш гэж, үлдсэн 34 хувь нь мэдэхгүй гэж хариулсан. Магистр болон докторын зэрэгтэй хүмүүсийн олонх нь буюу 52.6 хувь нь энэ асуудлыг сонирхдоггүй гэж хариулсан бол шүүхийн үйл ажиллагааг ил тод байдаг, ил тод биш гэж үздэг бүлгийн эзлэх хувь харьцангуй ойролцоо (ил тод гэж 36.8, ил тод биш гэж 38.2) байна. Үүнээс боловсролын зэрэг илүү өндөр байх тусам шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг хүлээн зөвшөөрөх хандлагатай байгаа нь ажиглагдаж байна.

График-1. Та шүүхийн талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг вэ?



Энэхүү судалгаагаар мэдээллийн цахим хуудас буюу олон нийтийн цахим сүлжээнээс 57 хувь шүүхийн талаарх ойлголт, мэдээллийг авдаг бол хамгийн бага буюу 37.3 хувь нь шүүхийн албан ёсны цахим хуудаснаас мэдээллийг олж авдаг гэж хариулсан байна. Албан ёсны мэдээллийн эрх сурвалжаас шүүхийн талаарх мэдээлэл авч буй иргэдийн эзлэх хувь нь бусдын ам дамжсан ярианаас шүүхийн талаарх мэдээлэл авдаг гэх 39 хувийн үзүүлэлтээс ч бага байгааг анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Шүүхээр үйлчлүүлж байсан болон үйлчлүүлж байгаагүй иргэдийн шүүхийн талаарх мэдээлэл авч байгаа эх сурвалжийг харьцуулан судалж үзэхэд бусдын ам дамжсан яриагаар болон Twitter ашиглан мэдээлэл авах хувь хэмжээ онцгой ялгаагүй буюу бараг ижил хэмжээтэй байлаа. Харин шүүхийн байгууллагаар үйлчлүүлж байсан иргэд Мэдээллийн цахим хуудсаар мэдээлэл авах нь их (24.1 хувь), шүүхээр үйлчлүүлж байгаагүй



иргэдийн хувьд энэ үзүүлэлт 6.55 хувиар бага (17.5 хувь), шүүхийн цахим хуудаст хандаж мэдээлэл авах байдал шүүхээр үйлчлүүлж байсан хүмүүсийн хувьд илүү өндөр (20.5 хувь), энэ үзүүлэлт шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн хувьд 11.63 хувиар бага (8.9) байгаа нь анхаарал татаж байна. Үүнийг шүүхийн ил тод байдалд итгэх үзүүлэлттэй харьцуулж үзвэл шүүхээр үйлчлүүлж байсан иргэд шүүхийн ил тод нээлттэй байдалд илүү итгэж байгаа нь харагдсан. Харин шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн хувьд шүүхийн ил тод байдлын талаар харьцангуй сөрөг бодолтой бөгөөд телевиз, радио болон Facebook-ээр дамжуулан шүүхийн талаар мэдээлэл авах нь илүү байгаа хандлага ажиглагдаж байна.


Судалгаанаас харахад шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ мэдээллийн сувгийг зөв сонгох нь вертуал төхөөрөмж болон цахим орчинд хэвлэл мэдээллийн нэгдсэн нэг төвөөс шүүхүүдэд болж буй үйл явдлын мэдээллийг нэг эх сурвалжаас өгдөг байх нь олон нийтийн тодорхой нэг сайтыг дагах, мэдээлэл авах, эрх зүйн боловсролыг хүртээмжтэй хүргэх тайлтай.

Судалгаанд шүүхийн байгууллагын ил тод байдлын талаар бодитой дүгнэлт гаргах зорилгоор шүүхийн байгууллагаар үйлчлүүлж байсан болон үйлчлүүлж байгаагүй иргэдийн аль алиныг нь хамруулж өгсөн хариултыг нь харьцуулан судаллаа.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 66.7 хувь нь шүүхээр үйлчлүүлж байсан, 33.3 хувь нь шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэд байна. Шүүхээр үйлчлүүлж байсан иргэдийн хувьд шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байдаг гэж 38.2 хувь нь, ил тод биш гэж мөн ижил 38.2 хувь нь хариулсан бол 22.4 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна. Харин шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн 34.9 хувь нь шүүхийн нээлттэй, ил тод байдлын талаар мэдэхгүй гэж хариулсан бол 19.1 хувь нь нээлттэй ил тод гэж, 46.2 хувь нь нээлттэй, ил тод биш гэж хариулсан байна. Үүнээс шүүхээр үйлчлүүлж байсан иргэд шүүхийн үйл ажиллагааг илүү ойлгосон, нээлттэй бөгөөд ил тод байдлыг нь харьцангуй сайн хүлээн зөвшөөрдөг бол шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэд шүүхийн үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлын талаар мэдэхгүй эсвэл ил тод биш гэж хариулсан нь нийтлэг байна.



График-2. Шүүх хуралдаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцож, шүүхийн шийдвэрт өөрийн санал дүгнэлтээ тусгуулж, шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх, үүргээ мэдэх үү?




Судалгаанд хамрагдсан иргэдийн 65.8 хувь нь шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцож, шүүхийн шийдвэрт өөрийн санал дүгнэлтээ тусгуулах эрхтэй гэдгээ мэднэ гэсэн нь шүүхийн шинэтгэл тодорхой үр дүнтэй явагдаж байгааг харуулж байна. Хөгжлийн эрэлд ТББ-ын 2015 онд хийсэн судалгаагаар Шүүхийн шинэтгэл эрчимтэй эхэлснээс буюу Шүүхийн тухай багц хууль хэрэгжиж эхэлснээс хойш 1,5 жилийн хугацаанд шүүхээр үйлчлүүлсэн, шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн 60.6 хувь нь өнөөдөр шүүх хэрэг, маргааныг хуульд нийцүүлэн шударгаар шийдвэрлэж байна гэдэгт итгэдэг гэж хариулсан бол энэ үзүүлэлт шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн хувьд бүр өндөр буюу 81.4 хувь нь шүүхийн үйл ажиллагаа шударга гэдэгт итгэдэг гэжээ. Бидний хийсэн судалгаагаар иргэдийн 66.1% нь шүүх хуралдаанд иргэн нь шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцож, шүүхийн шийдвэрт өөрийн санал дүгнэлтээ тусгуулж, шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй гэдгээ мэднэ гэсэн үр дүн гарч байгаа нь дээрх судалгааны үр дүнтэй үндсэндээ ойролцоо байна.

Гэсэн хэдий ч нөгөө талаас авч үзвэл 34.2% нь шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцож, шүүхийн шийдвэрт өөрийн санал дүгнэлтээ тусгуулах эрх, үүргээ мэдэхгүй гэж хариулсан байна. Энэ судалгаанд хамрагдсан иргэдийн 33.3 хувь нь шүүхээр үйлчлүүлээгүй иргэд байгаа нь дээрх асуултад мэдэхгүй гэж хариулах шалтгаан болсон гэж үзэж болохоор байна. Судалгаанаас харахад Монгол Улсын иргэн бүр шүүхийн үйл ажиллагаатай танилцах, иргэдэд хүртээмжтэй байдлаар мэдээллийг хүргэх ажиллагаа хангалтгүй, шүүхэд хөндлөнгийн хяналтаа хэрэгжүүлэх эрх, үүргээ мэдэхгүй, эрх зүйн боловсрол орхигдсон, иргэдийн эрх зүйн мэдлэг сул байгааг харуулж байна.




График-4. Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр дуудвал шүүхэд очих байдал, насаар



Харин шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох эсэх талаарх хариултыг хүйсээр ялгаж үзвэл эмэгтэйчүүдийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох сонирхол (76.1 хувь) нь эрэгтэйчүүдийнхээс 10 орчим хувиар илүү, эрэгтэйчүүдийн завгүй ажилтай учраас очихгүй гэсэн хандлага (18.6 хувь) нь эмэгтэйчүүдийнхээс 10 орчим хувиар илүү байгаа нь доорх графикаас харагдаж байна.

График 5. Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр дуудвал шүүхэд очих эсэх, хүйсээр





Хүйсийн байдлаар авч үзвэл шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байдаг гэж өмнөх судалгаанд дүгнэсэн бөгөөд энэхүү судалгаанд ч эмэгтэйчүүдийн шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох сонирхол илүү өндөр байгаа нь харагдаж байна. Иймд эрэгтэйчүүдэд чиглэсэн шүүхийн иргэдийн төлөөлөгчийн ажил, үүргийн талаарх мэдээллийг хүргэж иргэдийн төлөөлөгчдийн хүйсийн харьцааг илүү ойртуулах боломжтой юм.

Энэхүү судалгааны шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох эсэх талаарх олон хариулттай асуултад хариулсан байдлыг оролцогчдын ажил эрхлэлттэй харьцуулж үзвэл одоогоор эрхэлсэн ажилгүй байгаа хүмүүс шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох сонирхол 96.2 хувь байгаа нь хамгийн өндөр бол төрийн албаныхан хамгийн бага (62.6 хувь), хувийн хэвшилд ажилладаг хүмүүсийн сонирхол 72.4 хувь, хувиараа бизнес эрхлэгчдийн шүүхээс дуудсан тохиолдолд шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцох үүрэгтэй гэж үзэх байдал 87.5 хувь байна. Харин завгүй ажилтайн улмаас шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцохгүй гэсэн хариулт төрийн албан хаагчдын дунд хамгийн өндөр (18.0 хувь), шүүхэд итгэхгүй тул очихгүй гэсэн хандлага ч мөн л төрийн албан хаагчдын дунд харьцангуй өндөр (12.2 хувь) байгаа нь ажиглагдлаа. Цаашид төрийн албан хаагчдад болон хувиараа бизнес эрхлэгчдэд чиглэсэн шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэх арга хэмжээ авч тэдний шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлэх нь зүйтэй болохыг судалгааны үр дүн харуулж байна.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр дуудвал шүүхэд очих эсэхийг асуухад 18-24 насныхны 95 хувь нь өөрсдийгөө очих үүрэгтэй гэж үзэж байгаа нь хамгийн эерэг үзүүлэлт байлаа. Харин 25-30 насныхан болон 56 болон түүнээс дээш насныхан дунд очно, очихгүй гэсэн хариулт үндсэндээ ойролцоо 50 хувь орчим байгаа бол 25-30 насныхан завгүй (21.4 хувь), шүүхэд очихоос айж байна (10.7 хувь) гэсэн үндсэн хоёр шалтгаанаар шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр ажиллахаас татгалзах хандлагатай байна.

Харин 46-50 насныхны хувьд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох сонирхол 18-24 насныхны хэмжээнд хүрэхгүй боловч бусад насны бүлгийнхнээс харьцангуй өндөр (66.7 хувь) боловч энэ насны бүлгийн дотор шүүхэд итгэдэггүй тул иргэдийн төлөөлөгчөөр оролцохгүй гэсэн хариулт хамгийн өндөр (17.6 хувь) байгаа нь доорх графикаас харагдаж байна.

Мөн энэхүү судалгаанд оролцогчдын 36-55 хүртэлх насны бүлэгт хамаарах хүмүүсийн хувьд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр очих магадлал дунджаар 63.6 хувьтай, маш ойролцоо үзүүлэлттэй байгаа бол очихгүй байх магадлал нь эдгээр насны бүлгүүдийн хувьд ихэвчлэн завгүй учраас




очихгүй, мөн шүүхэд итгэдэггүй гэсэн хоёр үндэслэл байгаа нь ажиглагдаж байна.

Судалгаанд оролцсон 31-35 настай хүмүүсийн дунд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр очихгүй байх үндэслэл нь мөн л шүүхэд итгэдэггүй (13.8 хувь) гэх үндэслэл байгаа нь анхаарал татсан үзүүлэлт байв.

Судалгааны хариултуудаас танил хүнтэйгээ шүүх дээр таарч буруу ойлголт өгөхөөс эмээж шүүхэд очихгүй гэсэн хариулт бараг байхгүй, иргэдийн дунджаар 64.7 хувь нь шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр очих сонирхолтой байгаа нь эерэг үзүүлэлтүүд боловч цаашид шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлэх, шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг нэмэгдүүлж иргэдийн шүүхэд очихоос айх айдсыг багасгах хэрэгцээ шаардлага байгааг энэхүү судалгаа харуулж байна.

График-6. Монгол Улсын хэмжээнд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн идэвх оролцоог насны байдлаар болон оноор харьцуулсан байдал¹⁵



Дээрх графикаас харахад 56 болон түүнээс дээш насны иргэдийн шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох оролцоо хамгийн бага, 36-45 насны хүмүүсээс 25-35 насны хүний идэвх оролцоо бага бол 46-55 насныхан 36-45 насны хүмүүстэй идэвх, оролцоо ойролцоо байна.


Нийт шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгчийн 909 буюу 46.1 хувь нь эрэгтэй, 1062 буюу 53.9 хувь нь эмэгтэй байгаа нь хүйсийн байдлаар шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо эмэгтэйчүүдийн хувь илүү, боловсролын түвшингээр нь авч үзвэл, дээд боловсролтой иргэдийн төлөөлөгч 892 буюу 46.3 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн төлөөлөгч 974 буюу 50.6 хувь, боловсролгүй иргэдийн төлөөлөгч 177 буюу 9.2 хувь байна¹⁶.

15 Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо», Монгол Улсын шүүхийн 2022 оны тайлан, Уб., 2023, 297 дахь тал

16 Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо», Монгол Улсын шүүхийн 2022 оны тайлан, Уб., 2023, 297 дахь тал




График-7. Иргэдийн төлөөлөгч оролцсон шүүх хуралдаан¹⁷



Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эрхлэн гаргасан тайланд бүрэн дунд боловсролтой болон боловсролгүй иргэд Монгол Улсын хэмжээнд нийт шүүх хуралдаанд оролцсон иргэдийн 59.8 %-ийг эзэлж байгаа гэж дурдсан байна. Энэ үзүүлэлтээс харахад боловсролын ямар түвшинд эрх зүйн суурь боловсрол олгох хэрэгцээ шаардлага манай улсад байгааг харуулж байна.

Монгол Улсын хэмжээнд шүүх хуралдаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог 2023 оны тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгч 207 хүнээр буюу 21 хувиар буурсан, иргэний хэрэгт 7.7 хувиар өссөн, захиргааны хэрэгт 20.1 хувиар буурсан байна.¹⁸ Жил ирэх тутам хэрэг маргааны тоо өсөж байхад шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо буурсан нь Үндсэн хуулиар олгосон эрх, үүрэг, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцооны зорилго, ач холбогдлын талаарх талаарх мэдлэг дутуу, шүүхийн талаарх уламжлалт ойлголтоосоо салаагүй байгааг харуулж байна.

График-8. Шүүх нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэхэд шүүхээс хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ




17 “Иргэдийн төлөөлөгч”, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021-2023 оны тайлан, УБ., 2023, 154 дэх тал,

18 Монгол улсын шүүхийн 2022 оны тайлан, Иргэдийн төлөөлөгчийн оролцоо., 2023, 154 дэх тал



Судалгаанд оролцогчдын хариултыг давхардсан тоогоор авч үзэхэд 70.9% нь иргэний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, 51.6 хувь нь иргэдэд хууль сурталчлах ажлыг зохион байгуулах, 41.3 хувь нь шүүх хуралдааныг олон нийтийн хэрэгслээр шууд дамжуулах, 40.8 хувь нь цэцэрлэг, сургуулийн боловсролын хөтөлбөрт тусгуулах, 38.1 хувь нь шүүхээс гарсан шийдвэр бүрд хураангуй, тойм хийх шаардлагатай гэж хариулжээ.

График-9. Хүүхдийг шүүхийн байранд болон шүүх хуралдааны танхимд ирүүлж бодитоор эрх зүйн суурь мэдлэг олгох, танин мэдэхүйн аялал зохион байгуулахыг дэмжих эсэх



Дээрх асуултад судалгаанд оролцогчдын 92.8% нь дэмжинэ гэж хариулжээ. Шүүхийн байранд болон шүүх хуралдааны танхимд хүүхдүүдийг ирүүлж бодитоор эрх зүйн суурь мэдлэг олгох Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд, залуучууд эрх зүйн суурь боловсрол сайтай болж төлөвшсөнөөр хууль, дүрэм журмаа сахин биелүүлдэг, хүний эрхийг дээдэлсэн, иргэн бүр эрх, үүргээ ухамсарласан, хараат бус бие даасан, шударга шүүхийн тогтолцоог бэхжүүлэх, төрдөө, шүүхдээ итгэдэг шударга нийгмийг цогцлоох хувь хүнийг хөгжүүлэх зэрэг олон эерэг нөлөөтэй гэж үзэхээр байна.

Түүнчлэн гадаадын зарим улс орнуудад шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг олон нийтэд хүргэхдээ хэвлэл мэдээллийн байгууллага нь шүүхийн эх сурвалжаас авсан мэдээллээ аливаа засваргүйгээр олон нийтэд хүргэх хэм хэмжээг байдгийг анхаарч үндэсний хэмжээнд ижил байдлаар зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна. Жишээлбэл Канад Улсын шүүх нь сэтгүүлчид зориулсан өрөөтэй байх бөгөөд шүүх танхимд шийдвэрээ сонсохоос өмнө тухайн өрөөнд сэтгүүлчдэд хандан шийдвэрийн үндэслэлээ шүүгч, шүүх бүрэлдэхүүн танилцуулдаг байна. Хэргийн материал нээлттэй, шүүх хуралдаан нээлттэй, шүүхийн шийдвэр нээлттэй, шийдвэрлэсэн



хэргээ өдөрт нь хураангуйлаад мэдээлэл бэлтгэн гаргадаг зэрэг нь эргэлзэх, таамаглах зүйлгүйгээр олон нийтэд түгээх боломжийг бүрдүүлдэг байна.

Иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн арга хэлбэрээр эрх зүйн боловсролыг дэмжих нь дан ганц шүүхийн салбарт тулгамдаж буй асуудал гэж үзэх боломжгүй нь дээрх судалгаанаас харагдаж байна. Шүүхийн байгууллагаас иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажилд дэмжлэг үзүүлснээр иргэд шүүхийн талаар илүү мэдээлэлтэй болж, шүүхийн үйл ажиллагаа ил тод байх үндэс суурийг бэхжүүлэх боломжтой байна. Иймд шүүхээс үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг сайжруулах зорилгоор иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эрх зүйн боловсрол олгох цахим платформ болон мэдээллийн сувгийг оновчтой тодорхойлох, цаашид эрх зүйн боловсролыг дэмжих ажлын хүрээнд шүүхийн талаар ямар мэдээллийг өгөх нь зүйтэй талаар нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийх, шүүхийн салбарын цахим хөгжлийг үр дүнтэй, хүртээмжтэй хүргэх чиглэлээр боловсролын байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах нь үр дүнтэй гэж үзэж байна.

Сургуулийн өмнөх боловсролоос эхлэн бүх шатны боловсролын хөтөлбөрт эрх зүйн суурь мэдлэгийг олгох, шүүхийн үйл ажиллагааг таниулах практик танин мэдэхүйн сургалт зохион байгуулах нь үр дүнтэй эсэхийг асуусан асуултад судалгаанд хамрагдсан хүмүүсийн 93,3 хувь нь “тийм” гэж хариулсан байна. Энэ нь суурь хүмүүжил төлөвших бага наснаас нь эрх зүйн боловсрол олгох, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо, эрх, үүргийн талаарх ойлголтыг хүүхдүүдэд өгөхийг иргэд дэмжиж байгааг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Шүүхийн нээлттэй, ил тод байдлын зарчим, түүний хэрэгжилт нь шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх, олон нийтийн хяналт тавих эрхийг хангах, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, иргэн төвтэй шүүхийн үйлчилгээг төлөвшүүлэх явдал юм.

“Алсын хараа” 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-доо ардчилал, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх эрхэм зорилгын хүрээнд 2021-2030 он хүртэлх хугацаанд “Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө” гэж, 2031-2040 оныг хүртэлх хугацаанд “Иргэдийн итгэлийн бүрэн хүлээсэн шүүхтэй болно” гэж, 2041-2050 он хүрэхэд “Хариуцлагатай, иргэн төвтэй шүүх төлөвшсөн” байх шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг баталсан байна. Шүүх эрх мэдлийн байгууллага нь 2024-2034 онд хэрэгжих дунд хугацааны зорилт, хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бодлогын үр дүнгийн суурь нөхцөлийг бүрдүүлсэн “Монгол Улсын Шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжлийн бодлого”-ын баримт бичгийг Улсын Их Хурлын 2024 оны 33 дугаар



тогтоолоор батлуулсан. Уг бодлогын баримт бичгийн шүүхийн захиргааны үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх арга хэлбэрийг боловсронгуй болгох...” арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Шүүхэд иргэдийн төлөөлөгчдийг дуудан ирүүлэх, тэдний дүгнэлтийг харгалзан шүүхийн шийдвэрт тусгах, шүүхийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих иргэдийн төлөөлөгчдийн суурь мэдлэг сул байгаа зэрэг асуудлууд нь практикт тулгамдсан асуудал болоод байгааг цөөнгүй судлаачид онцолсон байна. Зарим судлаачид шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо холимог бөгөөд хэлбэрийн төдий гэж дүгнэсэн бол судлаач С.Номингэрэл, Т.Гангэрэл нар “Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийн бэхжүүлэх арга зам” өгүүллэгтээ “Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэн шүүхэд ирэхдээ шүүхийн иргэдийн төлөөлөгч гэж хэн болох, шүүх хуралдаанд оролцуулж буй зорилго нь ямар ач холбогдолтой талаар ямар ч ойлголтгүй, төвөгшөөсөн хандлагатай байдаг”¹⁹, нөгөө талаар иргэдийн эрх зүйн боловсрол дутмаг хэвээр байгаа²⁰ гэж дүгнэсэн нь энэ судалгааны үр дүнтэй нийцэж байна. Энэ нь шүүхээс иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр 2020 оноос хойш хэрэгжүүлсэн ажлын үр дүн төдийлөн хангалтгүй байсныг харуулж байна. Мөн иргэд шүүхийн талаарх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагын цахим хуудас /олон нийтийн цахим сүлжээ/-аар авч байгаа нь энэхүү судалгаанаас харагдаж болохоос гадна шүүхээр үйлчлүүлээгүй иргэд шүүхийн цахим хуудсанд хандах байдал маш бага байгаа зэргээс үзвэл цаашид дан ганц шүүхийн цахим хуудсаар олон нийтэд мэдээллийг өгснөөр нээлттэй, ил тод байдлыг хангагдана гэж үзэх нь учир дутагдалтай.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны тайланд өмнөх онтой харьцуулсан үзүүлэлтээр шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо 14.4 хувиар буурсан тоо баримт байна. Энэхүү судалгааны үр дүнгээс шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэд шүүхийн нээлттэй, ил тод байдалд итгэдэггүй (39.8 хувь) эсвэл энэ талаар мэдэхгүй (21.5 хувь) буюу эдгээр иргэдийн нийт 61.3 хувь нь шүүхийн талаар сөрөг хандлагатай байгаа нь ажиглагдлаа.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр дуудвал шүүхэд очих эерэг хандлагатай иргэдийн эзлэх хувь харьцангуй өндөр, 18-24 насны залуучуудын дунд очно гэсэн хариулт бүр 95 хувьд хүрч байгаа нь сайшаалтай байна. Иргэд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцох боломжтой гэдгийг ойлгож, мэдэж байгаа байдал ч нийтлэг байгаа нь энэхүү судалгаанаас гарсан эерэг үр дүн мөн боловч 25-30 насны иргэдэд шүүхэд очихоос айх байдал багагүй хэмжээнд илэрсэн, судалгаанд оролцогчдын дунд шүүхэд итгэх итгэлгүй байна гэсэн хариулт олон гарсан зэрэг нь өнөөгийн манай улсад шүүхийн үйл

19 Шүүхийн ерөнхий зөвлөл. ЗХДЭШШүүхийн захиргааны ажилтнуудаас авсан асуумж., 2020

20 (Номин-Эрдэнэ, Гангэрэл, 2020)



ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг оновчтой, хүртээмжтэй байдлаар, нийгмийн тодорхой бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан сонгож хүргэх нь чухал гэдгийг харуулж байна. Тухайлбал энэ судалгаанд оролцсон төрийн захиргааны байгууллагын алба хаагчид бүгд шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байдаггүй гэж дүгнэснийг анхаарч төрийн албан хаагчдад чиглэсэн мэдээллийн урсгалыг бий болгож болох юм.

Энэ судалгаанд оролцсон тусгай дунд боловсролтой иргэдийн 70.6 хувь нь шүүхийн үйл ажиллагаа ил тод биш гэж хариулсан, боловсролын түвшин доогуур иргэд шүүхийн үйл ажиллагааны талаар мэдлэг багатай байдаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа бөгөөд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр бүрэн дунд боловсролтой болон боловсролгүй иргэд оролцох байдалөндөр (62 хувь) байгаатулэнэсудалгаандсаналболгосончлониргэдийн шүүхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд сургуулийн өмнөх наснаас эхлэн бүх түвшний боловсролд эрх зүйн боловсролыг багтаан олгох нь зүйтэй байна.

Шүүхээс үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг сайжруулах зорилгоор иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эрх зүйн боловсрол олгох цахим хуудас, вертуал төхөөрөмж болон мэдээллийг хүргэх нэгдсэн сувгийг оновчтой тодорхойлох, цаашид эрх зүйн боловсролыг дэмжих ажлын хүрээнд шүүхийн талаар ямар мэдээллийг өгөх нь зүйтэй талаар хэвлэл мэдээллийн баг ажиллаж нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийх, шүүхийн салбарын цахим хөгжлийг үр дүнтэй, хүртээмжтэй хүргэх чиглэлээр төрийн бусад байгууллага тэр дундаа боловсролын байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах зэргээр шүүхийн салбарт зарим арга хэмжээ, сайн туршлагыг нэвтрүүлж болох юм. Үүний зэрэгцээ гадаадын улс орнуудад шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж байгаа байдал шүүхийн эх сурвалжаас авсан мэдээллээ аливаа байдлаар мушгин гуйвуулах боломжгүйгээр олон нийтэд хүргэх зохицуулалт, цахим орчны ёс зүйг төвөлшүүлэх сайн туршлагыг улс орны хөгжилд тулгуурлан шүүхэд нэвтрүүлснээр шүүхийн цахимжилт эрчимтэй хөгжиж, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх, шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр ажиллах идэвх, сонирхлыг нь дэмжих чухал алхам болж чадна гэж үзэж байна.



САНАЛ

1. Нийгмийн тодорхой бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн хэлбэр, агуулгаар шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдлэг олгох, МУ-ын хэмжээнд шүүхүүдэд болж буй үйл явдлын мэдээллээр шуурхай хангах сувгийг тодорхой болгохын тулд хэвлэл мэдээллийн төвтэй байх нь стратегийн хувьд нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага болоход чухал ач холбогдолтой,
2. Шүүх эрх мэдлийн байгууллагын зүгээс хэвлэл мэдээллийн салбартай хамтран ажиллах, шүүхийн албан ёсны нээлттэй эх сурвалжаас авсан мэдээллийг мушгин гуйвуулж, олон нийтийг төөрөгдүүлэхгүй хүргэх, хүний эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлсэн цахим орчны ёс зүй, соёлыг түгээсэн нарийвчилан журмаар зохицуулах,
3. Эрх зүйн боловсролтой болсноор шүүхийн талаарх зөв ойлголттой, хуулиар олгосон эрх, үүргээ биелүүлэх нь ямар ач холбогдолтой болохыг ухамсарласан, хариулагатай насан хүрсэн иргэн болж чадна. Шүүхийн нээлттэй ил тод байдлыг хангахад нэг талаас иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал хэдий ч нөгөөтэйгүүр шүүхийн үйл ажиллагаанд ямар нэгэн хэлбэрээр үр нөлөөтэй оролцдог эрх зүйн мэдлэг, боловсролтой иргэдийн оролцоо чухал юм. Тиймээс Төрөөс бодлогоор дэмжиж, сургалтыг бүх шатны боловсролын хөтөлбөрт тусгуулах саналыг дэвшүүллээ.



ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж болон бусад албан ёсны баримт бичгүүд:

1. НҮБ, Хууль зүйн үндэсний төв. //Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл. -Уб.,1993. 3-4 дэх тал.
2. Чимид,Б. Үндсэн хууль ёс ба үндэсний эрх зүйн тогтолцоо олон улсын симпозиум. //Хууль дээдлэх ёсыг хангахад шударга шүүхийн үүрэг илтгэл. -Уб., 2 009. 28 дахь тал.
3. Б.Өлзийсайхан, “Шүүхийн эрх зүй бие даасан салбар эрх зүй болох нь”, //Монголын төр, эрх зүй” сэтгүүл. Уб., 2021-№1(97). 50-67 дахь тал.
4. <http://pdf.usaid.gov>
5. (Баярсайхан, Баянбилэг 2010)
(Баярсайхан, Баянбилэг 1990)
6. Yuoth legal Services, YLS. (2023) “The importance of community legal education.
7. Bedzow, By Michael J. Broyde & Ira. (2019) “Education week.
8. George, Anitha Rinu. (2023) “Why Teaching Basic Law and Legal Education in Schools is Crucial.
9. Centre, Bingham. (2022) “Each Other.
10. Centre, Bingham. (2022) “Each Other.
11. Асуумж. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн захиргааны ажилтнуудаас авсан асуумж., 2020
12. Бадамрагчаа, П. ННФ ТББ менежер, Шүүхэд хэрэг маргааныг хянан хэлэлцэх ажиллагаан дахь иргэдийн оролцоо. Бодлогын асуудал. СХДШүүхийн Шүүх хуралдааны ажиглалтын тайлан. 2010.
13. (Содномдаржаа, Давааням, 2019)
14. Бадамрагчаа, П. ННФ ТББ менежер, Шүүхэд хэрэг маргааныг хянан хэлэлцэх ажиллагаан дахь иргэдийн оролцоо. Бодлогын асуудал. СХДШүүхийн Шүүх хуралдааны ажиглалтын тайлан. 2010.
15. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо», Монгол Улсын шүүхийн 2022 оны тайлан, Уб., 2023, 297 дахь тал



16. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо», Монгол Улсын шүүхийн 2022 оны тайлан, Уб., 2023, 297 дахь тал
17. “Иргэдийн төлөөлөгч”, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021-2023 оны тайлан, Уб., 2023, 154 дэх тал,
18. Монгол улсын шүүхийн 2022 оны тайлан, Иргэдийн төлөөлөгчийн оролцоо., 2023, 154 дэх тал
19. Шүүхийн ерөнхий зөвлөл. ЗХДЗШШүүхийн захиргааны ажилтнуудаас авсан асуумж., 2020
20. (Номин-Эрдэнэ, Гангэрэл, 2020)



ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ ДЭХ ХУУЛЬ ЁСНЫ ИТГЭЛИЙГ ХАМГААЛАХ ЗАРЧМЫН ОНОЛЫН ОЙЛГОЛТ, ЗАХИРГААНЫ ШҮҮХИЙН ХЭРЭГЛЭЭ



Л.БАТБААТАР
*Нийслэл дэх Захиргааны хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч*

Өгүүллийн бүтэц

Хураангуй (Abstract)

Түлхүүр үг

Удиртгал

Нэг. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын онолын ойлголт

- 1.1 Захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын онолын үндэслэл
- 1.2 Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын ач холбогдол
- 1.3 Монгол Улсын Захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим

Хоёр. Захиргааны шүүхийн хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглээ

- 2.1 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эсрэг И ХХК
 - 2.2 Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс эсрэг И ХХК
 - 2.3 Нийслэлийн Засаг даргын эсрэг С ХХК
- Гурав. Судалгааны дүгнэлт, санал
- Дөрөв. Ном зүй



Хураангуй

Энэхүү өгүүллээр Захиргааны ерөнхий хуульд тусгагдсан “Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”-ын онолын үндэслэл, ойлголт, ач холбогдол, захиргааны шүүхээс тус зарчмыг хэрэглэж буй практикийг судалсан болно. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь төрийн захиргааны эрх мэдлийг хязгаарлах эрх зүйт төр, хууль дээдлэх ёсны үндсэн дээр бий болсон зарчим, сургаал юм. Энэхүү зарчмыг манай улс төдийгүй эх газрын эрх зүйн тогтолцоотой болон Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой улсуудад хэрэгжүүлж байна. ЗЕХ-д захиргааны байгууллага, албан тушаалтан өөрийн гаргасан хууль бус эерэг үйлчлэлтэй захиргааны актыг хүчингүй болгох эрхтэй боловч бүхий л нөхцөлд энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжгүй. Учир нь хууль ёсны итгэлийг хамгаалж ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийн 48.2-т энэхүү эрхийн хязгаарлалтыг хууль тогтоогч тусгаж өгсөн юм. Энэхүү зарчмыг Захиргааны хэргийн шүүхээс хэрхэн хэрэглэж байгаа тухай энэхүү судалгаагаар хөндөх болно.

Түлхүүр үг: Захиргааны шүүх, Захиргааны байгууллага, албан тушаалтан, Хууль ёсны итгэл, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим, хууль хэрэглээ, шүүхийн практик

Удиртгал

Энэхүү өгүүллийн зорилго нь Монгол Улсын захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэл хамгаалах зарчмын онолын ойлголт болон ач холбогдол, шүүхийн практикийг судлах юм. Судалгаанд харьцуулалтын арга, кэйс төвт дүн шинжилгээний арга, анализ-синтез, индукц-дедукцийн аргыг ашигласан. МУ-ын хувьд сэдвийн судлагдсан байдал тун бага байна. Монгол Улсад Т.Мөнх-Эрдэнэ, Г.Гэсэр, (2019), Монгол Улсын Захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим, МУИС, Хууль зүйн сургууль, Эрх зүй сэтгүүл (№4, Цуврал 48), Д. Сүнжид, (2017), Захиргааны ерөнхий хууль: Үзэл баримтлал, хэрэглээ, Г.Банзрагч, (2013), Эдийн засгийн захиргааны эрх зүй, Д. Сүнжид нар, (2017), Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар зэрэг бүтээлүүдэд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын талаар судалсан байна. Гэхдээ онолын үзэл баримтлал болон шүүхийн практикийг хослуулан судалсан судалгаа байхгүй юм. Иймээс энэхүү агуулгаараа тус судалгаа нь шинэлэг, ач холбогдолтой.



Нэг. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын онолын ойлголт

1.1 ЗЭЗ дэх ууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын онолын үндэслэл

Захиргааны эрх зүйд хууль ёсны итгэлийг хамгаалах сургаал, зарчим байдаг. Эх газрын болон Англи-Саксоны эрх зүйн бүлийн улс орнуудын аль аль нь энэхүү сургаал зарчмыг хэрэгжүүлж, хүлээн авсан. Англиар The Concept of Legitimate Expectation, мөн Doctrine of Legitimate Expectation эсхүл The Principle of Protection of Trust гэж нэршсэн. Манай Улсын хувьд Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим гэсэн агуулгаар хүлээн авч хуульд томъёолсон. Энэхүү сургаал зарчим нь Германы захиргааны эрх зүйн нөлөөгөөр Европын бусад улсуудад хөгжсөн.¹ ХБНГУ-д тус зарчмыг vertrauensschutz гэж нэрлэж, хэрэглэдэг. 1965 онд Берлин дэх Захиргааны хэргийн Дээд шүүхээс халамжийн хэрэг маргааныг шийдвэрлэхдээ vertrauensschutz буюу Итгэлийг хамгаалах зарчмын анх удаа хэрэглэсэн түүхтэй. Улмаар ХБНГУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт тусгалаа олжээ.

Харин Франц Улсын Захиргааны эрх зүйд “protection de la confiance legitime” гэсэн нэр томъёогоор хэрэглэж байна. Англи-Америкийн эрх зүйн бүлийн улс орнуудад энэхүү сургаал нь жам ёсны буюу шударга ёсны онолд тулгуурладаг, харин Эх газрын эрх зүйн бүлийн орнуудад эрх зүйн тодорхой байдал, хууль ёсны зарчим, нийтийн удирдлагын итгэлийн хүрээнд тулгуурлаж бий болсон.² Англи Улсад 1969 онд Schmidt v. Secretary of state for home affairs маргааныг шийдвэрлэхдээ дээрх зарчмыг анх удаа хэрэглэсэн. Хэдийгээр өөр өөр газар нутагт хөгжиж бий болсон боловч агуулга, шинж, ач холбогдлын хувьд адил юм.

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь зөвхөн захиргааны эрх зүйн хүрээнд хэрэглэгддэг сургаал биш. Иргэний эрх зүйд “Итгэлийг хамгаалах зарчим” хэрэгждэг. Агуулга нь төстэй боловч салбар эрх зүйн ялгаатай байдлаас шалтгаалан хэрэглээ өөр байна.

Иргэний эрх зүй дэх итгэлцлийг хамгаалах зарчмын талаар Хууль зүйн ухааны доктор, шүүгч Ж.Оюунтунгалаг “Иргэний эрх зүй I: Ерөнхий анги” бүтээлдээ³

“энэхүү зарчим нь үгийн шууд утгаар Иргэний хуульд тусгагдаагүй боловч иргэний эрх зүйн хэм хэмжээ нь эрх зүйт ёсны үүднээс хуульд захирагдан амьдрах иргэншсэн нийгмийн гол шинж болох итгэлцэх гэх нийгмийн үнэт зүйлийг хамгаалахад чиглэдэг. Нөгөө талаас уг зарчим нь эрх зүйн үндсэн чиг үүрэг болох нийгэмд тодорхой байдлыг бий болгох, нийгэм, эдийн засгийн

1 By Geo Quinot, Substantive Legitimate Expectations in South African and European Administrative Law, German law journal, Vol. 05 No. 01.2004, p67

2 Louise Otis, Jérémy Boulanger-Bonnely, The Protection of Legitimate expectations in Global Administrative law, p8

3 Оюунтунгалаг.Ж, (2020), Иргэний эрх зүй I: Ерөнхий анги, УБ., х38



харилцаан дахь иргэд хоорондын арилжаа, солилцоо, тохиролцоо нь үр ашигтай байх боломжийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг” гэж бичсэн байна.

Үүнээс үзэхэд, Захиргаа болон Иргэний эрх зүйн итгэлийг хамгаалах зарчмын ялгаа нь салбар эрх зүй хоорондын зохицуулах зүйл байх боловч эрх зүйт төр, хууль ёсны зарчим, эдийн засгийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх гэсэн шинжүүдээр адил төстэй юм. Иймээс энэхүү зарчмыг зөвхөн Захиргааны эрх зүйн зарчим гэж үзэж болохгүй. Харин хууль дээдлэх ёс, эрх зүйт төрийн хүрээнд зайлшгүй хэрэгжүүлэх ач холбогдол бүхий зарчим гэж ойлгож байна.

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын зорилго бол захиргааны байгууллага аливаа үйлдэл хийхээсээ өмнө иргэдэд бий болсон хууль ёсны итгэлийг өөрсдийн эрх мэдлийг ашиглан устгахаас сэргийлэх явдал юм.⁴ Гэхдээ захиргааны байгууллага цаг ямагт өөрсдийн амласнаар үйл ажиллагаа явуулдаггүй юм. Жишээлбэл: Нийтийн ашиг сонирхол, санхүүгийн хязгаарлагдмал байдал, шударга ёс, улс төрийн байдал зэргээс шалтгаалан иргэдэд бий болсон хууль ёсны итгэл алдагдахад хүрдэг байна. Захиргааны байгууллага зорилгодоо хүрэхийн тулд өөрсдийн мөрдөж буй дүрэм журмыг өөрчилж шинэ дүрэм баталж, мөн бодлого боловсруулдаг. Иргэдийн хувьд захиргаанаас олгосон эерэг үйлчлэлтэй акт, шийдвэр болон баталсан дүрэм журмууд өөрчлөгдөх үед хууль ёсны итгэл алдагдахад хүрдэг. Тиймээс шинэ дүрмийг дагах уу эсхүл хуучин дүрмийг дагах уу гэсэн асуудал үүснэ. Энэхүү асуудлыг шийдвэрлэх хүрээнд Захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим бий болсон.

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь Rule of Law зарчмын нэг хэсэг болно. Эрх зүйт төрийн зарчим буюу хуулиар жолоодуулах зарчим объектив эрхийн хувьд төрөөс хүний эрхийг хамгаалах үүргээр илэрдэг гэж үздэг бол субъектив эрхийн хувьд төрөөс иргэний итгэлийг хамгаалах зарчмаар илэрдэг гэж үздэг байна.⁵ Энэ хүрээндээ хууль дээдлэх ёс бол эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ хуульд тулгуурладаг боловч хууль нь төр, албан тушаалтныг хязгаарладаг гэсэн үндсэн шаардлагыг хүлээн зөвшөөрдөггүй төрийг хуулиар засаглах ёс юм.⁶ Үүнээс үзэхэд, төр, түүний албан тушаалтны зүгээс гаргасан шийдвэр, дүрэм, журмаа өөрчлөх замаар иргэдэд олгосон итгэлийг умартах нь хууль дээдлэх ёсыг үгүйсгэх нэг нөхцөл болно. Иймээс Захиргааны хэргийн шүүхийн хувьд төрийн тэр дундаа захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан үйлдэл, эс үйлдэл нь иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны итгэлийг зөрчсөн үү эсхүл зөрчөөгүй юу гэдгийг хянахад чиглэнэ. Ингэснээр хууль дээдлэх ёс нь шүүх засаглалаар дамжиж хэрэгжиж байгаа юм.

4 Мөнх-Эрдэнэ,Т, Гэсэр,Г, (2019), Монгол Улсын Захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим, МУИС, Хууль зүйн сургууль, Эрх зүй сэтгүүл (№4, Цуврал 48), УБ., х119

5 Сүнжид,Д, (2017), Захиргааны ерөнхий хууль: Үзэл баримтлал, хэрэглээ, УБ., х51

6 Мөнхсайхан,О, (2022), Үндсэн хуулийн хяналт ба тайлбар, МУИС-ХЗС, УБ., х13



Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчимд эдийн засгийн захиргааны эрх зүй дэх эдийн засгийн хүрээн дэх төрийн буюу захиргааны үйл ажиллагаа урьдчилан тооцох буюу урьдаас харах боломжтой байх зарчим багтдаг. Энэ талаар Хууль зүйн ухааны доктор Г.Банзрагчийн Эдийн засгийн захиргааны эрх зүй бүтээлд “Эдийн засаг ажиллах чадвартай, өндөр бүтээмжтэй, үр дүнтэй, үр ашигтай, дасан зохицох чадвартай байх эсэх нь төрөөс хэрэгжүүлж байгаа эдийн засгийн арга хэмжээ нь иргэдийн хувьд урьдаас харах, тооцоолох боломжтой байхаас их хамаардаг. Эдгээр шалгуурууд нь эдийн засгийн хүрээн дэх төрийн арга хэмжээ нь тодорхой нэг хэлбэржсэн ажиллагаагаар явагдах үед төрийн үйл ажиллагааны талаар нийтэд болон холбогдох эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй иргэд буюу тухайн салбарынханд мэдэгдэх боломжийг олгосноор хэрэгждэг” гэж бичигдсэн байна.⁷

Хувь хүн, хуулийн этгээд нь хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг зөрчсөн агуулга бүхий нэхэмжлэл гаргах үед шүүхээс нэхэмжлэгчид “хууль ёсны итгэл байсан” гэдгийг тогтоох үүрэг оногддог. Хууль ёсны итгэл нь засгийн газар эсвэл төрийн эрх бүхий байгууллагаас баталсан эсхүл зарласан амлалт, төлөөлөл, үйл ажиллагаа бодлого төлөвлөлтийн үр дүнд үүсдэг гэж үздэг.⁸ Энэхүү итгэл олгосны үр дүнд нэхэмжлэгч нь мөнгөөр үнэлэгдэх ашиг тусыг хүлээж байдаг. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь материаллаг болон процедурын гэсэн хоёр төрөлд хуваагддаг. Захиргааны шүүхээс захиргааны байгууллага нь хувь хүн, хуулийн этгээдэд гэрээтэй адил амлалтаар итгэл өгсөн эсэх, хууль тогтоомж, дүрмээр итгэл хүлээлгэсэн эсэх, тухайн хууль тогтоомж, дүрмээ өөрчилсөн эсэх талаар хяналт хэрэгжүүлэх юм. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчид материаллаг хэм хэмжээгээр итгэл олгож, эдийн засгийн ашиг тус бий болгох нөхцөл бүрдүүлсэн эсэхийг шалгана гэсэн үг юм. Энэхүү материаллаг хуулиар олгож байгаа хууль ёсны итгэлийг материаллаг хууль ёсны итгэл гэсэн төрөлд ойлгоно.⁹

Харин захиргааны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гаргахаасаа өмнө тодорхой журмын дагуу явна гэж хувь хүн, хуулийн этгээдэд итгүүлсэн нөхцөлд тус итгэлийг олж авч буй этгээдэд процедурын итгэл үүсдэг. Үүнийг процедурын хууль ёсны итгэл гэсэн төрөлд ойлгоно. Эдгээр журам нь зөвлөлдөх, асуулга явуулах, сонсох, шаардлагатай бол тайлбар өгөх хугацаа өгөх зэрэг янз бүрийн хэлбэртэй байна. Энэхүү үзэл санаа нь захиргааны байгууллага, албан тушаалтан нь өөрийн дур зорго, мэдлийн хүрээнд бус харин хуульд заасан эрхийн хүрээнд үндэслэж үйл ажиллагаагаа явуулна гэсэн агуулгыг илэрхийлдэг. Ингэснээр сайн захиргааны байгууллагын төлөвшил бий болно гэж үздэг.¹⁰

Итгэлийг хамгаалах зарчмын өмнө хууль ёсны гэсэн шинж хэрэглэгдэнэ. Учир нь тухайн хувь хүн нь хууль ёсны хүрээнд энэхүү итгэлийг олж авсан

7 Банзрагч, Г. (2013), Эдийн засгийн захиргааны эрх зүй, УБ, х41

8 <https://www.lawteacher.net>

9 Neethu N. (2020), Doctrine of Legitimate expectation: An Analysis, Nalsar University of Law, p10

10 Neethu N. (2020), Doctrine of Legitimate expectation: An Analysis, Nalsar University of Law, p9



байх шаардлага тавигддаг. Хууль бусаар итгэл олж авсан тохиолдолд шүүх хамгаалахгүй юм. Түүнчлэн Захиргаа нь нийтийн ашиг сонирхлын үүднээс хувь хүнд олгосон итгэлээ өөрчилсөн бол шүүх тухайн нийтийн ашиг сонирхол болон хувь хүнд олгосон итгэлийн алиныг нь хамгаалах эсэхийг шийдвэрлэнэ. Онолын бүтээлүүдээс харахад, хууль ёсны итгэлийг хамгаалж байгаа нь тухайн иргэнд байгаа эрхийг хамгаалж байгаа ойлголт гэж үздэггүй байна. Хууль ёсны итгэл бол хуулиар олгогдсон эрх биш юм.¹¹ Харин шүүх захиргааны байгууллага нь аливаа шийдвэрийг гаргахдаа шударга ёсны шаардлага /the requirement of fairness/-д нийцүүлсэн эсэхийг хянах юм.

Иргэний хувьд шүүхэд шударгаар шүүлгэх эрхтэй учраас захиргааны байгууллага нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ шударгаар хандсан эсэхийг шалгуулах, тогтоолгохыг шүүхээс шаардах эрхтэй. Энэхүү үйлдэл нь дээр дурдсанаар Rule of law зарчмыг хэрэгжүүлж байгаа илэрхийлэл болно. Энэ талаар судлаач Foram R. Patel, Rishin Patel нар нь “Хууль ёсны итгэлийг хамгаалах сургаал: Английн хөгжлөөс Энэтхэг хүртэл” өгүүлэлдээ

“Энэхүү сургаалийн зорилго нь төрийн бодлого олон нийтийн сайн сайхны төлөө, ухамсартай хандахад чиглэнэ. Засгийн газрын зүгээс олон нийтэд мэдээлэхгүйгээр бодлогыг үл тоомсорлох, өөрчлөх нь шударга бус байна. Энэхүү итгэлийг хамгаалах зарчмыг зөрчих нь шударга ёсны зарчимд нийцэхгүй юм. Тус сургаал нь төрийн эрх мэдлийг дур зоргоор ашиглахыг хязгаарлах тухай. Энэхүү сургаалийн үндэс бол төр олон нийттэй харилцахдаа урьдчилан тооцоолохуй, тодорхой байхыг шаарддаг хууль дээдлэх зарчим юм”¹² гэж бичсэнтэй санал нэг байна.

1.2 Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын ач холбогдол

Хууль ёсны итгэлийг хамгаалах сургаал гарснаар Захиргааны хэргийн шүүхийн хяналтын хүрээг нэг шатаар нэмэгдүүлсэн гэж үздэг.¹³ Захиргаанд тавьдаг шүүхийн хяналт нь захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэсэн үндэслэлээр шүүхэд маргаан үүссэн үед л хэрэгждэг.¹⁴ Бусад тохиолдолд хязгаарлагддаг. Харин хууль ёсны итгэлийг хамгаалах тухай сургаал гарснаар захиргааны шүүхэд энэ асуудлаар өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн үндэслэлээр хандах нөхцөл бүрдсэн. Энэ агуулгаараа хууль ёсны зарчим, хууль дээдлэх зарчим хэрэгжих ач холбогдолтой юм. Товчхондоо, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь захиргааны шүүхийн хяналтын хүрээг тэлэх, хяналтыг хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулсан.

11 Foram R. Patel, Rishin Patel, (2021), The Doctrine of legitimate expectation: From development in England to Indian scenario, IJI Law Review, p139

12 Foram R. Patel, Rishin Patel, (2021), The Doctrine of legitimate expectation: From development in England to Indian scenario, IJI Law Review, p139

13 Foram R. Patel, Rishin Patel, (2021), The Doctrine of legitimate expectation: From development in England to Indian scenario, IJI Law Review, p139

14 Банзрагч.Г, (2023), Захиргааны процессын эрх зүй, Хоёр дахь хэвлэлт, УБ., х19



Манай Улсын хувьд Захиргааны ерөнхий хуульд хууль ёсны итгэлийг хамаалах зарчмыг тодорхой зааж өгсөнөөрөө ач холбогдолтой. ХБНГУ-д Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг тодорхойлж тусгаагүй боловч энэ нь эрх зүйн ерөнхий зарчим, тайлбар, хууль хэрэглээний практикт тодорхойлогддог. Энэ зарчим нь хууль зүйн тогтвортой байдал, иргэдийн хуульд итгэх итгэлийг хамгаалах зорилготой бөгөөд хэд хэдэн эрх зүйн зохицуулалтад тусгалаа олдог. Германд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь захиргааны эрх зүйн салбарт онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ зарчим нь “Үнэнч байх, итгэх” (Treu und Glauben) гэсэн ерөнхий зарчмын нэг хэсэг бөгөөд хууль тогтоомж, хууль хэрэглээний тайлбар, захиргааны практикт чухал байр суурьтай байдаг.

Энэхүү зарчим нь эрх зүйт төрийн зарчмын нэг хэсэг болох тул нийтийн албан тушаалтан, захиргааны байгууллагын үйл ажиллагааг хуульд нийцсэн, үндэслэсэн байхыг шаарддагаараа ач холбогдолтой. Тухайлбал: ХБНГУ-ын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн 3 дах хэсэгт “Гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдэл нь хуульд захирагдана.” гэж заасан. Энэ заалт нь хууль ёсны итгэлийг хамгаалах, төрийн үйл ажиллагааны найдвартай байдал, урьдчилан таамаглах боломжийг хангахад чиглэгдсэн эрх зүйт төрийн зарчмын нэг хэсэг юм. Мөн ХБНГУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48-р заалт нь захиргааны актыг эгүүлэн татах асуудлыг зохицуулан хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг агуулдаг. Энэхүү заалт нь акт гарсны дараа хууль ёсны итгэлтэй байж, итгэл нь хууль зүйн баталгаатай байх шаардлагыг тодорхойлдог. Ингэснээр захиргааны актыг буцаан татах буюу өөрчлөхгүй байх зарчмыг баталгаажуулан хууль зүйн тогтвортой байдлыг хангах, иргэдийн хууль ёсны итгэлийг дээдлэхэд чухал үүрэгтэй юм.

1.3 Монгол Улсын Захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим

А.Монгол Улсын Захиргааны эрх зүйд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим тусгагдсан түүх

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд эрүү, иргэн, захиргааны төрлөөр дагнан үйл ажиллагаа явуулах шүүх байгуулах боломжийг бүрдүүлж өгсөн. Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 хэсэгт шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж заасан. Энэ хүрээнд Монгол Улсын Улсын Их Хурлаас 2002 оны 12 дугаар сарын 06 өдөр Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулийг баталсан. Эдгээр хуулиуд нь 2004 оны 06 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөнөөр Монгол Улсад анх удаа нийтийн эрх зүйн субъект болох захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, актыг хянах, түүний улмаас иргэдийн зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээх, Үндсэн хуульд тусгагдсан хууль дээдлэх ёс, эрх



зүйт төрийн зарчмыг хэрэгжүүлэх нэг томоохон алхмыг хийсэн гэж үздэг. Хэрэв захиргааны шүүхийг байгуулаагүй нөхцөлд Үндсэн хуульд тусгагдсан эрх мэдэл хуваарилах зарчим, хууль дээдлэх ёсны зарчмууд нь хэрэгжих нөхцөлгүй юм. Харин захиргааны шүүх байгуулагдсанаар захиргааны дур зоргын үйл ажиллагааг хязгаарлах шат тавигдсан.

МУ-д анх удаа 2002 оны 12 дугаар сарын 26 өдөр батлагдсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсан түүхтэй. Хүчингүй болсон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4-11 дүгээр зүйлд заасан зарчмуудыг нөхөн хэрэглэж байсан. Энэхүү зарчимд “Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим” байгаагүй.

Үүний дараа 2016 онд анх удаа Захиргааны ерөнхий хуулийг баталж, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн найруулсан. Захиргааны ерөнхий хуулийн зорилго нь нийтийн эрх зүйн хүрээнд Гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэх юм. Энэ хүрээнд тус хуулийн 4 дүгээр зүйлд захиргааны үйл ажиллагаанд баримтлах үндсэн болон тусгай зарчмуудыг баталсан. Үндсэн зарчим нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны зарчмууд хамаарна. Харин тусгай зарчмыг тодорхойлохдоо анх удаа хууль ёсны итгэл хамгаалах зарчмыг зааж өгсөн. Тус зарчим тусгагдсанаар Захиргааны хэргийн шүүхээс захиргааны байгууллагын үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээдэд олгосон хууль ёсны итгэлийг хамгаалаагүй гэсэн үндэслэлээр хянах, хяналтын хүрээ өргөжсөн.

Б. Монгол Улсын Захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын агуулга

Иргэн хүн хуулийн дагуу хийсэн үйлдэл нь хууль, эрх зүйн акт өөрчлөгдсөнөөр дагаж өөрчлөгдөхгүй гэдэгт итгэлтэй байхыг энэхүү итгэл хамгаалах зарчимд ойлгоно. Захиргаанаас иргэнд хамааруулан хуулийг буцааж хэрэглэхгүй байх нь захиргааны ажиллагаанд иргэдийн итгэлийг хамгаалдаг. Хэрэв сүүлд өөрчлөгдсөн хууль, эрх зүйн акт нь иргэнд үүрэг хүлээлгэсэн эсхүл сөрөг үр дагавар үүсгэхээр байгаа бол тухайн хуулийг захиргаанаас буцааж хэрэглэхийг хориглодог.¹⁵

Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8-д Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг зааж өгсөн юм. Ингэхдээ тухайн зарчмыг хууль тогтоогч аутентик тайлбар хийж, дор дурдсан байдлаар тайлбарласан. Үүнд:

“Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим гэж нийтийн эрх зүйн аливаа харилцаанд захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд эдийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эрх зүйн үр дагавар үүссэн

15 Д.Сүнжид нар, (2017), Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, ХБНГУ-ын Ханнс Зайделийн сан, УБ., х67



тохиолдлыг ойлгоно. Харин энэ хуулийн 48.2-т заасан тохиолдол үүсвэл захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн итгэл хамгаалагдахгүй. Иргэн, хуулийн этгээдэд эерэг үр дагавар үүсэхээр байсан ч уг харилцаа дууссан бол итгэл хамгаалах зарчим хэрэглэгдэхгүй”¹⁶

Үүнээс харахад, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хангахын тулд:

- (1) Итгэл нь хууль ёсны байх;
- (2) Зарчмын хүрээнд иргэн, хуулийн этгээдэд эдийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эрх зүйн үр дагавар үүссэн байх,
- (3) Иргэн, захиргааны хоорондын тухайн харилцаа дуусгавар болоогүй байх;
- (4) Захиргааны үйл ажиллагаа хууль бус байх /ЗЕХ-ийн 48.2/;
- (5) Захиргааны актыг хүчингүй болгох хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байх /ЗЕХ-ийн 48.3/ гэсэн 5 нөхцөлийг хангасан байх шаардлага тавьсан байна.

Хууль ёсны хэмээн итгэл хамгаалах зарчмын өмнө тодотгосны учир нь хэрэв хууль бус үйлдэл байгаа тохиолдолд шүүхээс итгэлийг хамгаалахгүй гэдгийг тодотгож байгаа илэрхийлэл юм.

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь иргэн, хуулийн этгээдэд эдийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эрх зүйн үр дагаврыг үүсгэж байдаг. Захиргааны акт, шийдвэрээс шалтгаалан иргэн, хуулийн этгээдэд эерэг болон сөрөг үр дагаврууд үүснэ. Эрх зүйн үр дагавар гэдэгт хууль тогтоомж, акт, шийдвэрийн хүрээнд эрх, үүрэг үүсэх, дуусгавар болох, өөрчлөгдөхийг хэлнэ. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын хувьд хувь хүнд олгох халамж, тэтгэлэг зэрэг материаллаг тусламж нь төсвөөс зарцуулагдах тул нөгөө талд нь захиргааны хувьд санхүүгийн асуудал нь нийтийн ашиг сонирхлын илэрхийлэл болно. Материаллаг байдлаар илрэхгүй өөр бусад захиргаа, иргэн хооронд үүсэх харилцаанд хамаарах асуудал нь хууль ёсны итгэлд хамаарахгүй. Үүнд: Тусгай зөвшөөрөл олгох, иргэний харьяалал олгох зэрэг багтана.¹⁷

Дээрх зарчмыг хэрэглэх нэг урьдчилсан нөхцөл нь захиргаа, иргэний хооронд үүссэн харилцаа нь дуусгавар болоогүй байх юм. Аутентик тайлбараас харахад, иргэнд эерэг үр дагавар үүсгэхээр байсан ч уг харилцаа дууссан нөхцөлд итгэлийг хамгаалах зарчим хэрэглэгдэхгүй байна. Эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт гэдэгт Захиргааны Ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.4-т заасны дагуу эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээдэд эрх олгосон, эсхүл ашигтай нөхцөл байдлыг бий болгосон актыг ойлгохоор заасан. Харин сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт гэж эрх зүйн үйлчлэл чиглэсэн

16 Захиргааны ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл: 2015 он, №28

17 Д.Сүнжид нар, (2017), Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, ХБНГУ-ын Ханнс Зайделийн сан, УБ., х68



этгээдэд үүргийг бий болгосон, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарласан актыг ойлгоно гэж зохицуулсан байна. Эерэг үр дагавар гэдгийг дээрх агуулгаар эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт, шийдвэр гэж ойлгож хэрэглэнэ.

Захиргааны ерөнхий хуулийн хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн итгэл хамгаалагдахгүй байхаар зохицуулсан. Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-т Эерэг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актыг хүчингүй болгох нөхцөлүүдийг зааж өгсөн. Тухайлбал: хууль, захиргааны хэм хэмжээний актаар, эсхүл захиргааны актад түүнийг хүчингүй болгохоор заасан; бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн; захиргааны актаар олгосон эрхийг хэрэгжүүлээгүй; захиргааны актыг гаргуулахдаа хууран мэхлэх, айлган сүрдүүлэх, авлига өгөх буюу бусад хууль бус аргыг хэрэглэсэн бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан зэрэг хамаарах юм. Захиргааны шүүхээс тус зарчмыг хэрэглэхдээ дээрх урьдчилсан нөхцөлүүдийг анхаарч, хэрэглэнэ.

Хоёр. Захиргааны шүүхийн хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын хэрэглээ

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын хэрэглэж буй тоон мэдээлэл

2018 онд Эрх зүйн боловсрол академи болон Ханнс-Зайделийн сангаас ЗЕХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ гэсэн судалгааны тайланг гаргасан. Энэхүү тайланд “ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш ЗЕХ-д заасан, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчимд үндэслэн хэрэг шийдвэрлэсэн зөвхөн 1 тохиолдол гарсан байх бөгөөд эндээс тус заалт амьдралд хэрхэн хэрэгжиж байгаа талаар дүгнэлт өгөх боломжгүй байна”¹⁸ гэж дүгнэсэн. Гэвч судлаачийн хувьд ЗЕХ батлагдсанаас хойш буюу 2015-2018 оны хооронд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын хэрэглээтэй холбоотой маргаан шийдвэрлэгдсэн эсэх асуудлыг тодруулах зорилгоор шүүхийн шийдвэрийг шүүж үзэхэд, УДШ-ийн нийт 26 тогтоол гарч, маргаан шийдвэрлэсэн байна. Иймээс дээрх үнэлгээ хийсэн судалгааны дүгнэлт нь бодит байдалд нийцэхгүй байгааг харж болно.

2019-2023 оны хооронд буюу сүүлийн 5 жилийн хугацаанд Захиргааны хэргийн шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхдээ 222 удаа хууль ёсны итгэл хамгаалах зарчмыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох болон үндэслэх хэсэгтээ тусгаж, хэрэглэсэн байна. Он хугацаагаар харьцуулбал 2019 онд 30 удаа, 2021 онд 39 удаа, 2022 онд 57 удаа, 2023 онд 73 удаа хэрэглэсэн. Үүнээс товч дүгнэхэд, Захиргааны ерөнхий хуульд хууль ёсны итгэл хамгаалах

¹⁸ Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи ТББ, ЗЕХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, УБ., 2018 он, х9



зарчим тусгагдсанаас хойш жил ирэх тусам энэхүү зарчмын хэрэглээ ихэссэн байгааг харж болно. 2019-2023 оны хооронд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуул /Цаашид ЗХШХШтХ гэх/-ийн 106 дугаар зүйлээр нийт 3595 хэрэг хянан шийдвэрлэгдсэнээс 222 буюу 6.2 хувьд нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8-д тусгагдсан хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим хэрэглэжээ¹⁹. Харин Улсын Дээд шүүхээс 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 2023 оны 10 сарын 24-ний өдөр хүртэл хугацаанд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэх эсэхтэй холбоотой нийт 65 маргаан шийдвэрлэж, 65 тогтоолыг гаргасан байна²⁰.

Захиргааны хэргийн шүүхийн хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэж буй практик, түүнд хийсэн дүн шинжилгээ

Судлаачийн хувьд Захиргааны шүүхээс ЗЕХ-д тусгагдсан хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрхэн хэрэглэж байгаа талаар судалсан. Энэхүү судалгааны ажилд Захиргааны хэргийн 3 шатны шүүхээр шийдвэрлэгдсэн маргааныг сонгон авлаа. Учир нь Улсын Дээд шүүхээс шүүх хоорондын хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж ажилладаг. Иймд Улсын Дээд шүүх ЗЕХ-д тусгагдсан хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрхэн хэрэглэж байгаа эсэхэд дүгнэлт өгөхийг зорив.

2.1 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эсрэг И ХХК

А. Маргааны агуулга, үйл баримт

Нэхэмжлэгч нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/87 дугаар тушаалаар аялал жуулчлалын зориулалттай 0.44 га газар ашиглах зөвшөөрлийг авч, төслөө хэрэгжүүлэх явцад хариуцагчаас 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/407 тушаалаар газар ашиглах эрхийг хүчингүй болгосон. Үүний дараа тус шүүхэд хандаж, дээрх хүчингүй болгосон шийдвэрийг 2020 оны 128/ШШ2020/0000 дүгээр шийдвэрээр хүчингүй болгож, эрхээ сэргээлгэсэн. Улмаар уг шийдвэрийн дагуу баталгаажсан газар ашиглах эрхээ хэрэгжүүлэх явцад Ковид-19 цар тахал гарч, хязгаарлалтын дэглэм, хөл хорио тогтоогдсон. Гэтэл хариуцагчаас 2021 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн А/286 дугаар тушаалаар дээрх газар ашиглах эрхийг цуцалсан.

Б. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн агуулга

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс тус маргааныг хянан үзээд 2022 оны 04 сарын 18 өдөр 0289 дугаартай шийдвэрийг гаргасан. Шийдвэрийнхээ үндэслэх хэсэгтээ:

19 Судлаач нь түүврийн арга ашиглан энэхүү тоон судалгааг гаргасан болно.

20 www.shuukh.mn буюу шүүхийн цахим шийдвэрийн сангаас шүүлт хийсэн болно.



Нэхэмжлэгч компанид захиргааны байгууллагаас газар ашиглах эрх олгосон шийдвэрийг үндэслэн архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгажих талбайн схем зураг, мөн аялал жуулчлалын төвийн барилгын эскиз зургийг баталж, цахилгаан холболт хийх техникийн нөхцөл, барилгын ажлын зөвшөөрөл зэргийг холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон, бөгөөд тухайн газрын байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам хийж, мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталсан атлаа 4 жилийн дараа “хууль зөрчиж олгосон” гэх үндэслэлээр хүчингүй болгосон нь нэхэмжлэгч компанийн газар ашиглахтай холбоотой үйл ажиллагаа тасалдахад хүргэж, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндсөн төдийгүй захиргааны үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны итгэл хамгаалах зарчим алдагдахад хүргэжээ.

Мөн Захиргааны байгууллагаас нэхэмжлэгч компанийн газар ашиглах эрхийг хүчингүй болгосон үндэслэлээ “дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд аялал жуулчлалын зориулалтаар хууль зөрчин олгосон” гэж тайлбарлан маргаж байгаа хэдий ч хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр “Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-д эерэг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актыг хүчингүй болгох зохицуулалтыг зааж өгсөн, энэ үндэслэлд хамаарагдахгүй дээр сайдын 2017 оны 4 сарын 14 өдрийн А/87 дугаар тушаалыг хууль бус гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй, нэхэмжлэгч И ХХК нь энэ газар дээр аялал жуулчлалын төвийг барихаар эрх бүхий захиргааны байгууллагуудаас холбогдох зөвшөөрлийг хуульд заасан журмын дагуу авч үйл ажиллагаа явуулж байсан, энэ төсөлд 1,319,751,000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн нь тогтоогдож байна” гэж үйл баримтуудыг дүгнэсэн тул хариуцагчийн дээрх тайлбар үндэслэлгүй, шүүхээс дахин дүгнэх шаардлагагүй байна” гэж нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.

В. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалын агуулга

Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхээс 2022 оны 06-р сарын 21 өдөр анхан шатны шүүхийн шийдвэрийг хянан үзээд, 0440 дугаартай магадлалыг гаргасан. Магадлалынхаа хянавал хэсэгтээ:

Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдсан шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахдаа тухайн салбарын харилцааг зохицуулсан хууль, журамд нийцүүлэхээс гадна Захиргааны ерөнхий хуулиар тогтоосон үндэслэлд журамд нийцүүлэх, шийдвэр чиглэгдсэн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх үндэслэлтэй эсэхийг нарийн нягт хянан тогтоож, хууль зүйн үндэслэлтэй, бодит нөхцөлд тохирсон шийдвэр гаргах үүрэгтэй учраас хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн дээр дурдсан үндэслэлүүдээр “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар дархан цаазат газрын



хамгаалалтын дэглэмийг тогтоосон байхад Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг хуулиар тогтоосон дэглэмд нийцээгүй, зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагааны зорилгоор дархан цаазат газрын хамгаалалт, хязгаарлалтын бүсэд ... газар ашиглах эрх олгож ирсэн ... хуулиар хүлээсэн үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй барилга байгууламж бариулахаар гэрээ байгуулж ирснээс дархан цаазат газрын хязгаарлалтын бүс нь ... хуульд зааснаар хамгаалагдаж ирээгүй нь нийтэд илэрхий боловч энэ нь хүчин төгөлдөр хууль, хуулиар тогтоосон журмыг цаашид мөрдөхгүй байх үндэслэл болохгүй ... нэхэмжлэгчийг ... холбогдох барилгын ажлын зөвшөөрөл авсан байхад нь анх олгосон хууль бус тушаалыг хүчингүй болгосон нь хууль ёсны итгэл хамгаалах зарчмаар буруутгагдах учиргүй ... хууль зөрчсөн захиргааны ... шийдвэр нь Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд хүчингүй болгох, цуцлагдах боломжтой ... ” гэх агуулга бүхий гомдлыг хүлээн авах үндэслэлгүй гэж үзэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Г. Дүн шинжилгээ

Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ЗЕХ-ийн 4.2.8-д заасан хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэхдээ захиргаа иргэнд хууль ёсны итгэлийг актаар олгосон эсэх, мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх үр дагавар үүссэн эсэх, ЗЕХ-ийн 48.2 дахь зохицуулалт хэрэглэгдэх эсэх, харилцаа дуусгавар болсон эсэхийг хянажээ. Хариуцагч нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 -дуулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд аялал жуулчлалын зориулалтаар хууль зөрчин газар олгосон гэсэн үндэслэлээр нэхэмжлэгч компанийн газар ашиглах эрхийг хүчингүй болгосон. Нэхэмжлэгчийн хувьд газар олгосон шийдвэр нь эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт болно. Эерэг нөлөөлөл бүхий захиргааны актыг хүчингүй болгох хэм хэмжээг ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийн 48.2-т заасан. Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1-т хууль, захиргааны хэм хэмжээний актаар эсхүл захиргааны актад түүнийг хүчингүй болгохоор заасан нөхцөлд эерэг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актыг Захиргаа өөрөө хүчингүй болгож болно. Гэтэл энэхүү акт нь хууль бус захиргааны акт биш, нөгөө талаас хуулиар хүчингүй болгохоор заагаагүй гэж дүгнэсэн нь үндэслэлтэй байна.

Учир нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нь анх зөвшөөрөл өгсөн үеэс хойш 4 жилийн дараа гаргасан захиргааны актаа хууль бус гэж үзэж, хүчингүй болгох шийдвэр гаргасан. Гэтэл энэхүү шийдвэр гаргахаас өмнө газар ашиглах зөвшөөрлийг олгосон шийдвэр гаргахдаа нэхэмжлэгч компанид актаар итгэл хүлээлгэсэн гэж үзэх үндэслэл байна. Нөгөө талаас энэ харилцаа нь дуусгавар болоогүй үргэлжилж байсан. Энэхүү актын хүрээнд нэхэмжлэгч нь 1 тэрбум гаруй төгрөгийн эдийн үр дагаврыг үүсгэсэн. Иймээс хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэх нөхцөл бүрдсэн гэж үзэж байна. Гэхдээ Анхан



болон Давж заалдах шатны шүүхээс ЗЕХ-д тусгагдсан хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэхдээ тусгайлан урьдчилсан нөхцөлүүдийг нэг бүр шалгаж, үндэслэх хэсэгтээ бичээгүй байна. Харин захиргааны байгууллага, албан тушаалтан нь өөрийнхөө гаргасан шийдвэрийг хүчингүй болгохдоо хязгаарлалт бүхий хэм хэмжээг дагаж мөрдсөн эсэхэд илүүтэй анхаарч, хуулийг хэрэглэсэн байна.

2.2. Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс эсрэг И ХХК

А. Маргааны агуулга, үйл баримт

Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсээс 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 693 дугаартай шийдвэрээр тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй гэсэн үндэслэлээр нэхэмжлэгч талын хайгуулын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. АМГТГ-ын кадастрын хэлтсээс зөрчил нэгэнт арилсан буюу И ХХК-иас 2018 оны алданги, төлбөрийг хамт төлсний дараа 2017 оны 12 сарын 14-ний өдөр тусгай зөвшөөрлийг цуцалсан. И ХХК бодит байдалд нийцээгүй, хууль зөрчсөн гэж үзэж Захиргааны хэргийн шүүхэд хариуцагчийн гаргасан 693 дугаар бүхий захиргааны актыг хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан байна.

Б. Анхан болон Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн агуулга

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2018 оны 09 сарын 18-ны өдөр 0571 дугаартай шийдвэрээр Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 693 дугаартай шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүхээс 2018 оны 11 сарын 21-ний өдрийн 0598 дугаартай магадлалаар анхан шатны шүүхийн дээрх шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

В. Улсын Дээд шүүхийн тогтоолын агуулга

Хариуцагч Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсээс гаргасан гомдлыг хянан үзээд, 2019 оны 01 сарын 14-ний өдөр 08 дугаартай тогтоолоор, Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. Хянавал хэсэгтээ:

Захиргааны байгууллага зөрчил нэгэнт арилсан буюу нэхэмжлэгчээс 2018 оны төлбөрийг алдангийн хамт төлсний дараа 2017 оны 12 дүгээр сарын 14-ны өдөр тусгай зөвшөөрлийг цуцалж байгаа нь бодит байдалд нийцэхгүй, захиргааны шийдвэрийн үндэслэл болсон үйл баримт үгүйсгэгдсэн байна. Тодруулбал, захиргааны байгууллагын шийдвэр гаргасан 2017 оны 12 дүгээр сарын 14-ний өдөр тусгай зөвшөөрлийн төлбөр төлөгдсөн байсан буюу



захиргааны байгууллагын шийдвэрийн үндэслэл нь бодит нөхцөл байдалтай тохироогүй, захиргааны байгууллагын илрүүлсэн зөрчил нэгэнт арилсан учир Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5-д “зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх”, 4.2.8-д “хууль ёсны итгэлийг хамгаалах” гэж тус тус заасныг захиргааны байгууллага хэрэгжүүлээгүй, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг зөрчжээ.

Г. Дүн шинжилгээ

Захиргааны хэргийн гурван шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн ач холбогдол нь Улсын Дээд шүүхээс хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг актын маргааныг шийдвэрлэхдээ хэрэглэсэн, шийдвэрийнхээ үндэслэл хэсэгтээ тусгасан гэдэг хоёр зүйлээс харж болно. Нэхэмжлэгч нь 2017 оны 12 сарын 01-ний өдөр 2018 оны хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр, алдангийн хамт төлсөн. Харин хариуцагч нь тус хугацааны дараа буюу 2017 оны 12 сарын 14-ний өдөр тусгай зөвшөөрлийг цуцалсан. Шүүхийн хувьд Захиргааны ерөнхий хуулийн 4.2.5 –д заасан захиргааны байгууллагын шийдвэр нь зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлдөө тохирсон, үндэслэл бүхий байх, мөн хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг зөрчсөн гэж үзсэн.

Гэхдээ Улсын Дээд шүүхийн тогтоолоос хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим энэ тохиолдолд хэрхэн хэрэглэгдэж байгаа тухай бичигдээгүй учир дутагдалтай байна. Хариуцагчаас нэхэмжлэгчид ямар итгэлийг өгсөн бэ? гэдэг нь ойлгомжгүй, мөн нэхэмжлэгч нь тухайн эерэг үйлчлэлтэй актын үр нөлөөгөөр мөнгөөр үнэлэгдэх ямар үр дагаврыг олж авсан бэ гэдэг нь тодорхойгүй байна. УДШ-ээс хариуцагчийг хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг зөрчсөн гэж дүгнэсэн боловч энэ тохиолдолд дээрх зарчим хэрэглэгдэх эсэх нь маргаантай байна. Учир нь захиргаа хуульд заасан эрхийн хүрээнд тусгай зөвшөөрлийг цуцлах арга хэмжээ авсан, нөгөө талаас өөрийн гаргасан эерэг нөлөөлөл хууль бус актыг хүчингүй болгох шийдвэр гаргаагүй гэдгийг анхаарч үзээгүй байна. Нэхэмжлэгч төлбөр, алдангийг төлж байгаа үйлдэл нь актын зөрчлийг арилгаж байгаа үйлдэл тул захиргааг үргэлжлүүлэн сунгасан гэж итгэсэн байж болох юм. Нөгөө талаас энэ үйлдэлтэй нь холбоотойгоор нэхэмжлэгч тал эдийн засгийн буюу мөнгөөр үнэлэгдэх үр дагаврыг үүсгэж болно. Гэхдээ шүүхээс энэ талаар тодруулаагүй, шүүхийн шийдвэрийнхээ үндэслэл хэсэгтээ дүгнэлт өгөөгүй байна.

Энэхүү маргаантай төстэй 2 маргаан шийдвэрлэгдсэн байдаг. Тухайлбал: УДШ-ийн 2017 оны 11 сарын 20-ны өдрийн 472 дугаартай тогтоолоор шийдвэрлэгдсэн М ХХК-ийн нэхэмжлэлтэй Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст холбогдох хэрэг, УДШ-ийн 2018 оны 11 сарын 05-ны өдрийн 426 дугаартай тогтоолоор шийдвэрлэгдсэн Э ХХК-ийн нэхэмжлэлтэй Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст



холбогдох хэргүүд болно. Энэхүү хэргүүдийг шийдвэрлэхдээ дээрх байдлаар хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг зөрчсөн гэж шийдвэрлэсэн. Гэхдээ дээрх тогтоолоос ялгаатай нь хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрхэн хэрэглэж байгаа талаараа хянавал хэсэгтээ тусгаж өгсөн. Тухайлбал: УДШ-ийн 2017 оны 11 сарын 20 өдрийн 472 дугаартай тогтоолоор шийдвэрлэгдсэн М ХХК-ийн нэхэмжлэлтэй Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст холбогдох хэрэгт:

Захиргааны байгууллага зөрчил үүссэн тухайн цаг хугацаанд тусгай зөвшөөрлийг цуцлах шийдвэр гаргаагүй атлаа нөхцөл байдал өөрчлөгдсөний дараа буюу төлбөр төлсний дараа нэхэмжлэгчээс гэрчилгээний үнэ гаргуулах, алдангийг төлүүлэх зэргээр тусгай зөвшөөрлийг цуцлаагүй байснаар нэхэмжлэгчид итгэл төрүүлж, нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчжээ. Нөгөө талаар иргэний хууль ёсны итгэл хамгаалагдах зарчмыг захиргааны байгууллагаас хөндсөн гэж үзлээ. Учир нь захиргааны байгууллага хуулиар олгогдсон хугацааг бүх аж ахуй нэгжид адилхан тохиолдолд адил хугацаагаар тооцож шийдвэр гаргах үүрэгтэй. Гэтэл тухайн тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл 2016 оны 8 дугаар сарын 2-ны өдөр үүссэн байхад 5 сарын дараа буюу 2017 оны 2 дугаар сарын 09-ны өдөр тусгай зөвшөөрлийг цуцалж, өөрийн үзэмжээр хугацаа тогтоосон, ийнхүү 5 сар шийдвэр гаргаагүй удаасан захиргааны үйл ажиллагааны хууль зүйн үндэслэл тодорхойгүй байна.

Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8-д зааснаар нийтийн эрх зүйн аливаа харилцаанд захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд эдийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эрх зүйн үр дагавар үүссэн тохиолдолд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим үйлчлэх юм. Тодруулбал, нэхэмжлэгч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй буруутай болохыг захиргааны байгууллага мэдсэн атлаа итгэл үзүүлсэн үйлдэл гаргаж, нэхэмжлэгчээс гэрчилгээний үнэ, хугацаа хэтэрсний алданги гаргуулсан тул нэхэмжлэгчийн “итгэл хамгаалагдах” зарчим үйлчилнэ гэж үзлээ.

Дээрх УДШ-ийн тогтоолд “хууль ёсны итгэл хамгаалагдах зарчим”-ыг хэрхэн хамгаалагдах талаар хянавал хэсэгтээ тусгасан. Нэхэмжлэгч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй буруутай болохыг захиргааны байгууллага мэдсэн атлаа итгэл үзүүлсэн үйлдэл гаргаж, алданги, төлбөрийг төлүүлсэн гэж дүгнэсэн. Гэтэл энэ дүгнэлт нь хууль ёсны итгэл байсан уу? гэдэг ойлголтыг үгүйсгэж байгаа юм. Учир нь төлбөрөө хуульд заасан хугацаанд төлөх нь төлбөр төлөгчийн үүрэг байдаг. Энэхүү үүргээ биелүүлээгүй нь хууль ёсны гэх шинжийг үгүйсгэнэ. Харин захиргааны байгууллага нь бодит нөхцөл байдлыг тооцохгүйгээр хугацаа өнгөрснөөс хойш 5 сарын дараагаар шийдвэр гаргасан нь ЗЕХ-ийн 4.2.5-д заасан зарчмыг зөрчсөн үйлдэл болно. Энэ нөхцөлд нэхэмжлэгчид ямар эдийн буюу мөнгөөр илэрхийлэгдэх үр дагавар үүсч байгаа вэ гэдэг нь тодорхой бус байна. Үүнийг шүүх тодруулахгүйгээр



шийдвэрлэсэн байна. Тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн нь зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг болохоос бус нэхэмжлэгчид үүсч буй эдийн засгийн давуу байдал, үр дагавар биш. Иймээс шүүхээс энэ нөхцөл, шалгуурыг анхаарч үзээгүй байна.

2.3 Нийслэлийн Засаг даргын эсрэг С ХХК

А. Маргааны агуулга, үйл баримт

С ХХК нь эмнэлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд СБД-т байрлах 2291 м.кв эзэмших эрхтэй газрыг эзэмшдэг. Газар эзэмших эрхийн хугацааг 2016 онд Нийслэлийн Засаг даргаас 15 жилийн хугацаагаар сунгаж, олгосон. Нэхэмжлэгч тал нь хамтрагч байгууллагын хамтаар тухайн газар дээр 2018 онд 10,000 м.кв эмнэлэг барьж, ашиглалтад оруулсан. Харин Нийслэлийн Засаг дарга нь 2019 оны 07 сарын 08-ны өдөр А/687 дугаартай захирамжаар тус газар эзэмших эрхийг хүчингүй болгосон. Энэхүү захирамжийг хүчингүй болгуулахаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандсан байна.

Б. Анхан болон Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн агуулга

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2020 оны 03 сарын 23-ны өдөр тус маргааны хянан үзээд, 0185 дугаартай шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Шийдвэрийнхээ үндэслэх хэсэгтээ:

Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.2.8-д заасан зарчмын дагуу хууль ёсны итгэл хамгаалагдах ёстой. Нэхэмжлэгч нь гуравдагч этгээд Х ХХК-тай хамтран 10 давхар эмнэлгийн барилгыг барьж, улсын комисст хүлээлгэн өгсөн үйл баримт тогтоогдож байна. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын ерөнхий агуулга буюу хэрэглээ нь захиргааны үйл ажиллагаа буюу тодорхой актын улмаас тухайн чиглэсэн этгээдэд мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эрх зүйн үр дагавартай итгэл үүссэн тохиолдолд, уг актын хууль бус байдал хожим тогтоогдсон ч нэгэнт үүссэн итгэлийг хууль ёсны гэж үзэж хамгаалах, Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-т заасан онцгой үндэслэлүүдээс бусад тохиолдолд, эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт эрх зүйн үйлчлэлтэй байх, өөрөөр хэлбэл хууль бус байсан ч түүнийг хүчингүй болгохгүй, ингэснээр тухайн захиргааны актын хандсан этгээдийн буюу С ХХК-ийн итгэл хамгаалагдах ёстой юм.

Маргаан бүхий захиргааны актаар хүчингүй болгож шийдвэрлэсэн захирамжуудыг батлан гаргасан буюу хууль зөрчсөн этгээд нь хариуцагч нийслэлийн Засаг дарга өөрөө болохыг дурдах нь зүйтэй байна. Нийслэлийн Засаг даргын 2011 оны 438 дугаар захирамжийн С ХХК-д холбогдох хэсгийг



зерэг нөлөөлөл бүхий захиргааны акт гэж үзнэ. Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-т зерэг нөлөөлөл бүхий захиргааны актыг хүчингүй болгох 5 үндэслэлийг л дурдсан бөгөөд С ХХК-д газар эзэмших эрх шилжүүлэх, эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай захирамжуудыг хүчингүй болгох хуульд заасан үндэслэл байхгүй байна гэж дүгнэсэн.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс дээрх анхан шатын шүүхийн шийдвэрийг хянан үзээд, 2020 оны 06 сарын 17-ны өдөр 0385 дугаартай магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. Магадлалдаа:

“Маргаан бүхий газрыг нэхэмжлэгчид шилжүүлэн эзэмшүүлж, улмаар газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгасан, тухайн газар дээр барилга барих зөвшөөрөл өгч, түүний дагуу үл хөдлөх эд хөрөнгө бий болсны дараа “анх төрийн байгууллагын эзэмшиж байсан газрыг Газрын тухай хууль зөрчиж шилжүүлэн эзэмшүүлсэн” гэсэн үндэслэлээр нэгэнт эрх зүйн үйлчлэлгүй болсон захиргааны актуудыг хүчингүй болгох замаар (газар шилжүүлэн эзэмшүүлсэн захирамжууд) нэхэмжлэгчийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 болон Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д нийцээгүй байна” гэж дүгнэжээ.

В. Улсын Дээд шүүхийн тогтоолын агуулга

Улсын Дээд шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдэрүүдийг хянан үзээд, 2020 оны 09 сарын 16-ны өдөр 330 дугаартай тогтоолоор хариуцагч талын гаргасан гомдлыг хангахаас татгалзаж, анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг үндэслэлтэй байна гэж шийдвэрлэсэн. Хянавал хэсэгтээ:

Нийслэлийн Засаг даргын 2011 оны 05 сарын 30-ны өдрийн “Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нэр шилжүүлэх тухай” 438 дугаар захирамжаар “А” ХХК-иас “См с” ХХК-д шилжүүлж, улмаар “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай” 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/450 дугаар захирамжийн дагуу уг газрын эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасан захиргааны шийдвэрүүд нь эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээд болох нэхэмжлэгчид эрх олгож түүнд ашигтай нөхцөл байдлыг бий болгосон захиргааны зерэг нөлөөлөл бүхий захиргааны акт юм. Давж заалдах шатны шүүх Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8-д заасан “хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”, 48.2-д заасан зерэг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актыг хүчингүй болгох нөхцөлүүд, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 40 дүгээр зүйлд заасан эрх зүйн харилцааг зөв тайлбарлан хэрэглэж хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэсэн гэж дүгнэсэн.



Г. Дүн шинжилгээ

Энэ маргаан нь анхан, давах, хяналтын гэсэн 3 шатны шүүхээр шийдвэрлэгдсэн байна. 3 шатны шүүхээс адил байдлаар нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. ЗЕХ-д заасан хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг үндэслэх хэсэгтээ тусгасан. Өмнөх дүн шинжилгээ хийсэн шийдвэрүүдтэй харьцуулахад, энэ маргааныг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрт хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим түүний агуулгыг тодорхой тайлбарлаж, хэрэглэсэн гэж дүгнэхээр байна. Анхан шатны шүүхээс хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэхдээ үндсэн 4 урьдчилсан нөхцөлийг шалгаж, үндэслэл бүхий шийдвэрийг гаргасан. Нэхэмжлэгч тал нь А ХХК-иас маргаан бүхий газрыг шилжүүлэн авсан бөгөөд тус газрын Нийслэлийн Засаг дарга нь 15 жилийн хугацаатайгаар сунгасан. Энэхүү шийдвэр нь ЗЕХ-ийн 48.2 дугаар зүйлд заасан эерэг үйлчлэл бүхий захиргааны акт мөн юм. Эерэг үйлчлэл бүхий захиргааны актыг хүчингүй болгоход захиргаанаас ЗЕХ-ийн 48.2-т заасан үндэслэлийг баримтлах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, энэ зохицуулалт нь өөрийнхөө гаргасан эерэг үйлчлэл бүхий актыг цуцлах хязгаарлалт юм.

Маргаан бүхий газрыг нэхэмжлэгчид шилжүүлэн эзэмшүүлж, улмаар газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгасан, тухайн газар дээр барилга барих зөвшөөрөл өгч, түүний дагуу үл хөдлөх эд хөрөнгө бий болсны дараа “анх төрийн байгууллагын эзэмшиж байсан газрыг Газрын тухай хууль зөрчиж шилжүүлэн эзэмшүүлсэн” гэсэн үндэслэлээр нэгэнт эрх зүйн үйлчлэлгүй болсон захиргааны актуудыг хүчингүй болгох замаар (газар шилжүүлэн эзэмшүүлсэн захирамжууд) нэхэмжлэгчийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон нь ЗЕХ-ийн 4.2.8-д заасан зарчмыг зөрчиж байгаа үйлдэл мөн. Энэ агуулгаараа захиргаа нь нэхэмжлэгч талд итгэл хүлээлгэсэн байна. Үүний үр дүнд 10,000 м.кв талбай бүхий эмнэлгийн зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тухайн газар дээр барьж, ашиглалтад оруулж байгаа үйлдэл нь тухайн актын хүрээнд нэхэмжлэгч нь эдийн үр дагаврыг үүсгэсэн болохыг илтгэж байна. Түүнчлэн эрх зүйн харилцаа дуусгавар болоогүй, газар эзэмшүүлэх шийдвэр нь хууль бус захиргааны акт биш байгаа тул 3 шатны шүүхээс үндэслэл бүхий шийдвэрлэсэн гэж дүгнэх боломжтой байна.

Эдийн засгийн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээд нь төрийн хууль тогтоомж, шийдвэрт итгэсний үндсэн дээр хөрөнгө оруулалт, худалдан авалт хийх, үйл ажиллагаагаа өргөтгөх, төлөвлөх зэргээр тодорхой хэмжээний зарлага гаргадаг, иймд энэхүү иргэдийн “итгэл хамгаалагдах” ёстой гэж үздэг.²¹ Хэдийгээр захиргааны байгууллага нь өөрийнхөө гаргасан хууль бус шийдвэрийг хүчингүй болгох эрхийг хуулиар олгосон боловч хязгаарлалтыг мөн хуульд зааж өгснийг шүүх анхаарч, хэрэглэсэн байна. Захиргаа нь өөрийн

21 Банзрагч-Г, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны шүүгчийн тусгай санал.



гаргасан шийдвэр бүрийг хүчингүй болгосноор түүнд итгэж үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээд хохирох сөрөг үр дагавартай. Иймээс хууль тогтоогч хууль ёсны итгэлийг хамгаалах тухай зарчмыг тусгах замаар энэхүү хязгаарлалтыг оруулжээ. Гурван шатны шүүхээс энэхүү зарчмыг хэрэглэхдээ энэхүү агуулгыг тайлбарлаж, хэрэглэсэн нь ач холбогдолтой байна.

Гурав. Судалгааны дүгнэлт, санал

Манай улс анх удаа Захиргааны ерөнхий хуулиа 2015 онд баталсан. Энэхүү хуулиар захиргааны эрх зүй дэх шинэлэг зарчим, ойлголтууд тусгагдсан. Үүний нэг зарчим нь энэхүү өгүүллээр хөндөж буй хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим юм. Захиргааны хэргийн шүүх 2004 онд байгуулагдсанаас хойш захиргаа нь өөрийнхөө гаргасан буруутай шийдвэрүүдийг хүчингүй болгох замаар зөвтгөх, үүний үр дүнд түүнд итгэсэн иргэн, хуулийн этгээд хохирох сөрөг үр дагаврууд гарч байсан юм. Хүчингүй болсон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын агуулга, заалт тусгагдаагүй байсан. Иймээс 2017 оноос өмнөх шүүхийн шийдвэрүүдэд хууль ёсны итгэлийг хамгаалсан эсэхтэй холбоотойгоор дүгнэлт өгч байгаагүй юм. Харин 2015 онд энэхүү зарчим МУ-ын Захиргааны эрх зүй, Захиргааны ерөнхий хуульд тусгагдсанаар захиргаа дур зоргоороо өөрийнхөө гаргасан шийдвэрийг буцаан хүчингүй болгох эрх нь хязгаарлагдсан. Мөн Захиргааны шүүхээс энэ агуулгаар маргаан хянах хяналтын цар хүрээ нэмэгдсэн гэж дүгнэж байна.

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын зорилго бол захиргааны байгууллага аливаа үйлдэл хийхээсээ өмнө иргэдэд бий болсон хууль ёсны итгэлийг өөрсдийн эрх мэдлийг ашиглан устгахаас сэргийлэх явдал юм. Энэхүү агуулгаараа ЗЕХ-д тусгагдсан. Захиргааны хэргийн шүүхээс 2016-2017 оны хооронд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэж, хэвшээгүй байсан. Харин 2018 оноос эхлэн шүүхээс Захиргааны ерөнхий хуулийн 4.2.8, мөн хуулийн 48.2 дахь заалтуудыг хэрэглэж эхэлсэн гэж үзэж болно. Энэхүү өгүүллээр нийт 3 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн. Шүүхийн шийдвэрийг сонгохдоо 3 шатаар шийдвэрлэгдсэн, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг үндэслэл болгосон гэсэн 2 шалгуурыг баримталсан. Шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэхдээ үндсэн 5 урьдчилсан нөхцөлийг харгалзан үзэж байна. Үүнд: Итгэл нь хууль ёсны байх; Зарчмын хүрээнд иргэн, хуулийн этгээдэд эдийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эрх зүйн үр дагавар үүссэн байх, иргэн, захиргааны хоорондын тухайн харилцаа дуусгавар болоогүй байх, мөн ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийн 48.2-т заасан нөхцөл байгаа эсэхийг харгалзаж байна. Үүнээс гадна, ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийн 48.3-т заасан хүчингүй болгох хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг харгалзан үзэж байна.



Шүүхээс шийдвэртээ хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэхдээ эрх мэдэл хоорондын уялдааг хангах шаардлагатай. Зарим шүүхийн шийдвэрүүдэд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэх тохиолдол биш байхад хэрэглэсэн байна. Мөн нөгөө талаас өмнө хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэсэн маргаантай адил хэрэгт хэрэглээгүй тохиолдол гарч байна.

Энэ нь тухайн зарчмыг ямар нөхцөлд, хэрхэн хэрэглэх талаар нэг мөр ойлголт хэвшээгүй байгаатай холбоотой. Энэхүү судалгаа нь тус сэдвийг бүрэн дүүрэн судалсан судалгаа биш тул цаашид энэхүү сэдвээр харьцуулсан судалгаа хийх, практик судалгааг сайжруулах, нарийвчлан судлах шаардлага байна.

Дөрөв. Ном зүй /Ашигласан материалын жагсаалт/

А. Монгол хэл дээрх материал

- Оюунтунгалаг.Ж, (2020), Иргэний эрх зүй I: Ерөнхий анги, УБ
- Сүнжид.Д, (2017), Захиргааны ерөнхий хууль: Үзэл баримтлал, хэрэглээ, УБ
- Мөнхсайхан.О, (2022), Үндсэн хуулийн хяналт ба тайлбар, МУИС-ХЗС, УБ
- Банзрагч.Г, (2013), Эдийн засгийн захиргааны эрх зүй, УБ
- Банзрагч.Г, (2023), Захиргааны процессын эрх зүй, Хоёр дахь хэвлэлт, УБ
- Сүнжид.Д нар, (2017), Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, ХБНГУ-ын Ханнс Зайделийн сан, УБ
- Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи ТББ, ЗЕХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, УБ., 2018 он
- Мөнх-Эрдэнэ.Т, Гэсэр.Г, (2019), Монгол Улсын Захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим, МУИС, Хууль зүйн сургууль, Эрх зүй сэтгүүл (№4, Цуврал 48), УБ



Б. Гадаад хэл дээрх материал

- By Geo Quinot, Substantive Legitimate Expectations in South African and European Administrative Law, German law journal, Vol. 05 No. 01.2004
- Louise Otis, Jérémy Boulanger-Bonnely, The Protection of Legitimate expectations in Global Administrative law
- Neethu N. (2020), Doctrine of Legitimate expectation: An Analysis, Nalsar University of Law
- Foram R. Patel, Rishin Patel, (2021), The Doctrine of legitimate expectation: From development in England to Indian scenario, IJI Law Review

В. Шүүхийн шийдвэр, хууль тогтоомж

- МУ-ын Үндсэн хууль, ТМЭ: 1992 он, №1
- Захиргааны ерөнхий хууль, ТМЭ: 2015 он, №28
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, ТМЭ, 2016 он, №9
- Банзрагч.Г, МУ-ын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны шүүгчийн тусгай санал
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 0289 дугаартай шийдвэр
- Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 0440 дугаартай дугаартай магадлал
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 09 сарын 18-ны өдрийн 0571 дугаартай шийдвэр
- Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2018 оны 11 сарын 21-ний өдрийн 0598 дугаартай магадлал
- УДШ-ийн 2019 оны 01 сарын 14-ний өдрийн 08 дугаартай тогтоол
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 03 сарын 23-ны өдрийн 0185 дугаартай шийдвэр
- Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 06 сарын 17-ны өдрийн 0385 дугаартай магадлал
- УДШ-ийн 2020 оны 09 сарын 16-ны өдрийн 330 дугаартай тогтоол
- УДШ-ийн 2017 оны 11 сарын 20-ны өдрийн 472 дугаартай тогтоол
- УДШ-ийн 2018 оны 11 сарын 05-ны өдрийн 426 дугаартай тогтоол



ХОЁРДУГААР ХЭСЭГ

өгүүлэл нийтлэл



Нийгмийн сүлжээ ба Шүүгчийн ёс зүй: ТУРК



*Б.Сугар
Шүүхийн сахилгын хорооны гишүүн*

Оршил

Цахим эрин хурдацтай хувьсан өөрчлөгдхийн хэм хэрээр, дэлхий даяар социал медиа буюу нийгмийн сүлжээний хэрэглээ нэмэгдэж шүүх болон шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд төдийгүй хувийн амьдралд ёс зүйн шинэ нөхцөл байдал, сорилтуудыг бий болгож байна.

Нийгмийн сүлжээ нь боловсрол, соёл, нийгмийн харилцааг баяжуулах, хязгаарлагдмал харилцааг тэлэх зэрэг олон онцлох давуу талуудтай ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч тусгай субъект болох шүүгчдэд шинэ тулгар сорилт зарим тохиолдол бий болгож, цөөнгүй тохиолдолд энэхүү цахим сүлжээ нь өөрийн сул талуудыг үүсгэж болохыг гадны улс орнууд анзаарч цахим орчинд баримтлах шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг тодорхой заах болов.

Шүүгчийн цахим орчинд баримтлах ёс зүйн шалгуур, шаардлага, зохицуулалт бий болсноор шүүгчийн ёс зүй, хариуцлагатай байдлыг бэхжүүлж, шүүгчээр дамжуулан шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх онцлох ач холбогдолтой гэж үзэж уг үзэл санааг хөхиүлэн дэмжих болжээ.

Тиймээс үндэсний болоод олон улсын түвшинд ёс зүйн асуудлаар нийгмийн сүлжээ, цахим орчныг ашиглах шүүгчдийн ёс зүйн гарын авлага, заавар, цаашлаад ёс зүйн дүрэм, журам, зарчимтай байх нь зайлшгүй гэж улс орнууд үзэх болж, зохицуулалтууд хийгдэж эхэлсэн байна.

Энэхүү нийтлэлээрээ нийгмийн сүлжээ ба шүүгчийн ёс зүй сэдвийн хүрээнд та бүхэнтэй санаа бодлоо хуваалцаж, Турк улсын “Шүүхийн ёс зүйн тунхаглал”-ын хүрээнд “НИЙГМИЙН СҮЛЖЭЭГ АШИГЛАХ ЗААВАР”-ын талаарх мэдээллийг та бүхэндээ хүргэхийг зорив.

НЭГ. Шүүгчийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх

Шүүгч нь хэдий төрийн тусгай чиг үүрэг болох шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж, хэрэг маргаан шийдвэрлэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах бүрэн эрхийг хуулийн дагуу хэрэгжүүлэх хэдий боловч Монгол Улсын



иргэний хувьд Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрхийг ямар нэгэн хориг хязгааргүйгээр эдэлнэ.

Гэсэн хэдий боловч шүүгч хүн үзэл бодлоо илэрхийлэхдээ ямар ёс зүйг баримтлах, ямархуу хүрээ хязгаарын дотор өөрийн үзэл бодлоо илэрхийлэх ёстойг шүүгч бүр ухамсарлан ойлгож байдаг.

Тухайлбал шүүгч хүн маш олон эрхээ хязгаарлуулсан байдаг ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлэхдээ мөн тодорхой хязгаарын хүрээнд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх ёстой болохыг Монгол Улсын шүүхийн тухай хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан материаллаг болон процессын зэрэг олон хуулийн цөөнгүй зохицуулалтаас харж болохоор байна.

Шүүхэрхмэдлийг хэрэгжүүлэгч Шүүгч хүн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хуулиар бүрнээ баталгаажуулсан байдаг хэдий боловч Турк Улсын тухайд шүүхийн ёс зүйн тунхаглал болон мэргэжлийн үйл ажиллагааны хязгаарлалтын хүрээнд уг эрхийг эдэлдэг онцлогтой байх төдийгүй заавар зөвлөмжийг хууль эрхийн актын хүрээнд өгдөг байна.

Тухайлбал цахим сүлжээнд Шүүгч нь хувь хүн, өөрийн орон зай, үг хэлэх эрх чөлөөг эдлэх эрхтэй хэдий боловч тухайлсан нөхцөлийг баримтлах нь зүйтэй. Хэдийгээр шүүгч цахим орчинд, нийгмийн сүлжээнд идэвхтэй байдаггүй ч шүүхийн шийдвэрийг цахим орчинд утга агуулгыг мушгин гуйвуулахаас сэргийлэх зайлшгүй шаардлага байдаг талаар тухайлан дурдсан байна.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд итгэх олон нийтийн итгэлийг хангах ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг тодорхойлсон Туркийн шүүхийн ёс зүйн тунхаглал 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн байдаг ба шүүгчийн ёс зүйн зарчим нь шүүгч, прокурорын цахим орчин ашиглахад баримтлах зааварт шүүгчийн бие даасан, хараат бус байдлыг үг хэлэх эрх чөлөөтэй уялдуулах, тэнцвэртэй байлгах зорилготой ажээ. Турк улсын манай улсаас ялгаатай онцлог зохицуулалт нь Шүүгч, прокурор аль алинд нь энэхүү ёс зүйн тунхаглал, заавал үйлчилдэг явдал байх ба Шүүгч, прокурорын зөвлөл гэсэн байгууллага шүүгч, прокурорын асуудлыг хариуцан ажилладаг байна.

ХОЁР. Шүүгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх ба нийгмийн сүлжээ

Бидний өнөөгийн амьдарч буй нийгэм цахим эрин болж, нийгмийн бүхий л харилцаа цахимд тулгуурлан хөгжих болов. Өдгөө хүн төрөлхтөн хөгжлийн дараагийн үе болох цахимжсан дижитал, хиймэл оюун ухааны эринд хурдтай шилжин орлоо. Хүссэн ч, эс хүссэн ч шүүх, шүүгч, аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цахимжих болов.

Монголд мэдээллийн урсгал цахим хэлбэрт шилжиж, нийгмийн сүлжээгүйгээр нийгмийн амьдралыг төсөөлөхийн аргагүй болжээ. Энэ их цахимжсан орчинд шүүгч нийгмийн харилцаанд орохдоо, ажил үүргээ гүйцэтгэхдээ, мөн бусад этгээдтэй харилцахдаа хянамгай, төвч шударга,



ёс зүйтэй, зөв зохистой биеэ авч явж, үзэл бодлоо илэрхийлэх шаардлага тавигдах болжээ.

2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.32-т “хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа шүүх, шүүгчийн нэр хүндэд харшилсан, эсхүл шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл, зураг, дууны, дуудүрсний бичлэг болон бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл тараах, байршуулах”-ыг шүүгчид хориглож, хэрэв зөрчвөл шүүгчийн сахилгын зөрчил гэж үзэж хариуцлага тооцохоор хуульчлан заасан байна.

Тус заалтын хүрээнд Шүүхийн сахилгын хороонд ирж буй өргөдөл, мэдээллүүдэд шүүгчийн нийгмийн сүлжээнд ёс зүй авирласан гэх буюу ийм төрлийн өргөдөл, мэдээлэл цөөнгүй ирж байгаа ба энэ тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэх хандлага ажиглагдаж байгааг тухайлан дурдууштай.

Шүүгч нийгмийн сүлжээнд хэргийн оролцогчтой найз байх, лайк дарах, коммент бичих, чатлах, шэйр хийх, элдэв янз пост болон зураг, бичлэг, бичвэр оруулах, сэтгэгдэл бичиж үлдээх зэргээр бусадтай хувийн харилцаа тогтоох, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, харилцаанд оролцох, ялангуяа шүүгчийнхээ хувиар хэн нэгэнтэй ёс зүйгүй, зүй бус харилцах явдал нэлээдгүй гарч, үүнтэй холбоотой өргөдөл, мэдээлэл Шүүхийн сахилгын хороонд ирэх болов.

Дээр дурдаж буй үндэслэлээр ирж буй өргөдөл, мэдээлэл буурахгүй, харин эсрэгээрээ цаашид өсөх чиг хандлагатай байгааг шүүгч нарт тухайлан хэлж, сануулж, сэрэмжлүүлэх нь Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүний хувьд өөрийн эрхэм үүрэг гэж ойлгон хүлээн авч байдаг болно.

Хэдий шүүгч хүн Монгол Улсын иргэний хувьд хуулиар олгосон үндсэн эрх болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй боловч эрхэлж буй шүүгчийн ажил үүрэг, албан тушаалтай нь холбоотойгоор эрхийн зарим хязгаарлалтыг хуулиар хүлээдэг. Мөн холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой болон холбоогүй ч биеэ зөв зохистой авч явах шаардлага тавигддаг.

Энэхүү нийтлэлээр гадаадын улс орнуудад нийгмийн сүлжээ, цахим орчинд шүүгч хүн хэрхэн биеэ авч явбал зохих талаар зохицуулалт байдаг эсэхийг судалж шинэ, дэвшилтэт сайн туршлагын талаарх судалгаа, мэдээллийг хүргэхийг зорьсон ба Турк улсыг сонгов. Учир нь Турк улсад “Шүүхийн ёс зүйн тунхаглал”-ын хүрээнд “Нийгмийн сүлжээг ашиглах заавар” байдаг тул уг зааврыг бүрэн эхээр нь орчуулан хүргэхийг зорив. Турк улсын тухайд онцлог нь энэхүү танилцуулж буй Нийгмийн сүлжээ ашиглах заавар нь зөвхөн шүүгч биш мөн прокуроруудад хамааралтай буюу шүүгч, прокурорууд нь бүгд нэгэн ижил дагаж мөрдөх үүрэгтэй байдгаараа онцлогтой ажээ.



БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН “ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ТУНХАГЛАЛЫН ХҮРЭЭНД НИЙГМИЙН СҮЛЖЭЭГ АШИГЛАХ ЗААВАР”

Цахим эрин хөгжиж, дэлхий даяар сошиал медиа буюу нийгмийн сүлжээний хэрэглээ хурдацтай нэмэгдэхийн хэрээр шүүх болон шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд ёс зүйн шинэ нөхцөл байдлыг бий болгож байгаа билээ.

Тиймээс үндэсний болоод олон улсын түвшинд ёс зүйн асуудлаар нийгмийн сүлжээ, цахим орчныг ашиглах шүүгч болон прокуроруудад ёс зүйн гарын авлага, заавартай байх нь зайлшгүй гэж үзэж байна.

Шүүгч болон прокуроруудын үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг үндэсний болоод олон улсын түвшинд баталгаажуулсан байдаг ба Турк Улсын шүүхийн ёс зүйн тунхаглал болон мэргэжлийн үйл ажиллагааны хязгаарлалтын хүрээнд уг эрхийг эдэлдэг болно.

Цахим сүлжээнд Шүүгч болон прокурорууд нь хувь хүн өөрийн орон зай, үг хэлэх эрх чөлөөг эдлэх эрхтэй хэдий боловч тухайлсан нөхцөлийг баримтлах нь зүйтэй.

Хэдийгээр шүүгч, прокурорууд цахим орчинд, нийгмийн сүлжээнд идэвхтэй байдаггүй ч шүүхийн шийдвэрийг цахим орчинд утга агуулгыг мушгин гуйвуулахаас сэргийлэх зайлшгүй шаардлага байдаг.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд итгэх олон нийтийн итгэлийг хангах ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг тодорхойлсон Туркийн шүүхийн ёс зүйн тунхаглал 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Шүүгчийн ёс зүйн зарчим нь шүүгч, прокурорын цахим орчин ашиглахад баримтлах зааварт шүүгчийн бие даасан, хараат бус байдлыг үг хэлэх эрх чөлөөтэй уялдуулах, тэнцвэртэй байлгах зорилготой.

Тухайлбал, дараах үйлдлийн талаар тодорхой тусгасан, үүнд санал бодлоо текст бичгэн болон бичлэг аудио хэлбэрээр илэрхийлэх зэрэг орно.

1. Цахим хэвлэл, нийгмийн сүлжээнд виртуал бие хүнээр таниулахтай холбоотой асуудал шүүгч, прокурорын хувьд
 - 1.1. Ашиглах гэж буй нийгмийн сүлжээний агуулга нь чухал байдаг цахим сүлжээгээ ажил, мэргэжлийн онцлогийг харгалзан сонгох,
 - 1.2. Нийгмийн сүлжээнд өөрийн нэрээр хаяг үүсгэхдээ хувийн болон мэргэжлийн чиглэлээр хөгжүүлэх боломжтой,
 - 1.3. Хуурамч хаяг үүсгэн олон нийтийн нэрээр худал мэдээлэл тараахыг хориглох,
 - 1.4. Өөрийн хаягт оруулах зурагт анхаарч ажил мэргэжлийн эсрэг ашиглах, олон нийтийн итгэлийг бууруулахад нөлөөлөхгүй байх зэрэгт анхаарах,



- 1.5. Өөрийн ажлын и-мэйл хаягийг цахим сүлжээнд ашиглахгүй байх,
- 1.6. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаар мэтгэлцэх, сөрөг утга агуулга бүхий цахим сүлжээг дэмжин like, subscribe дарж, хуваалцахгүй байх,
- 1.7. Мэргэжлийн чиглэлээр үүсгэсэн хаягаараа өөрийн гэр бүл, найз нөхөдтэй холбогдохгүй байх.

2. Цахим орчинд найз нөхөд, бусад этгээдтэй холбоо тогтоох талаар

- 2.1. Цахим сүлжээнд бусдын найзын хүсэлтийг хүлээн авах, дагах үйлдлийг хийхдээ хянамгай байх,
- 2.2. Хувийн харилцаатай найз нөхөд, холбоотой бусад этгээдэд цахим сүлжээнд найз болсноороо өөрийн мэргэжлийн шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжтой мэт сэтгэгдэл төрүүлэхээс зайлсхийх,
- 2.3. Өөрийн ажлын хүрээнд хуваарилан авсан хэргийн оролцогч, өргөдөл, гомдол гаргагч, хуульч, өмгөөлөгч гэрч, эвлэрүүлэн зуучлагч зэрэг хэрэгт хамааралтай байсан, байгаа этгээдүүдтэй холбогдох, найз болохоос зайлсхийх, холбоо тогтоохгүй байх,
- 2.4. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх, олон нийтийн итгэлийг бууруулахаас сэргийлж улс төрийн нэрт зүтгэлтэн, улс төрчтэй холбогдох, холбоо тогтоохгүй байх
- 2.5. Үзэн ядах, ялгаварлан гадуурхах, талцан хуваах үзэл бүхий агуулгатай групп-ын оролцогчтой холбоо тогтоохгүй байх, холбогдохгүй байх, тэдний нийтэлсэн постыг бусадтай хуваалцахгүй байх, like, share хийх.

3. Ёс зүйн зан үйлийн загвар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээнд хуваалцах шалгуур

- 3.1. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сүлжээн дэх хувийн болон байгууллагын хаягаар дамжуулан шүүх эрх мэдлийг төлөөлөхдөө өндөр ухамсар, ёс зүй, соёлтой байж хариуцлагатай ажиллах. Олон нийтийн сүлжээгээр гарч буй шүүгч, прокуроруудын үг хэллэг, нийтлэлүүд шүүхийн нэр хүндэд шууд нөлөөлж байдаг ба энэ нь мэдэх боломжтой илэрхий зүйл юм.
- 3.2. Нийгмийн сүлжээнд лайк, сэтгэгдэл, шэйрийг устгасан ч хэвээр үлдээж, зориулалтын бус үр дагаварт амархан хүргэж болзошгүйг урьдчилан харж сонгон, болгоомжтой, анхааралтай ажиллах, шударга байдлыг эргэлзээтэй болгохгүй байх.
- 3.3. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээн дэх бүх зураг, видео бичлэг болон бусад шэйр нь шаардлагатай бол аюулгүй байдал, нууцлалын тохиргоог хийсэн ч ашиглаж буй платформиас гадуур тархаж болзошгүйг урьдчилан харж, үүний дагуу ажиллах,



- 3.4. хуваалцах, харилцахдаа хүний нэр төр, хүний эрхийг харгалзан үзнэ. Нэн даруй хариу үйлдэл үзүүлэх, үл хүндэтгэсэн, эелдэг бус тайлбар хийх, аливаа маргаанд оролцохгүй байна.
 - 3.5. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээн дэх нийтлэлийг зохих ёсоор хүндэтгэж, хүлээцтэй хандах. Хуваалцсан сэтгэгдэл, асуулт, шүүмжлэлд өгсөн хариултыг гуравдагч этгээд контекстээс хасаж, гуйвуулж, төөрөгдүүлж болзошгүйг санаж байх.
 - 3.6. Эрүүл саруул ухаантай байж тийм зан үйл, үйлдэл хийх. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээн дэх хуваалцах агуулгадаа ёс зүйтэй, эелдэг байхыг анхаарах. Аливаа хор хөнөөлтэй, эелдэг бус, доромжилсон, ёс бус үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх.
 - 3.7. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг улс төрийн агуулгатай эсвэл тийм гэж ойлгож болохуйц байдлаар ашиглахгүй байх.
 - 3.8. Ялгаварлан гадуурхах, үзэн ядсан үг хэллэг, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, кибер дээрэлхэлт, хүчирхийлэл, хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчсөн, бусад хэлбэрээр үймүүлж болзошгүй аливаа мэдээллийг хуваалцах, ийм төрлийн мэдээ, мэдээлэл харилцан үйлчлэхээс татгалзах.
 - 3.9. Шүүхээр шийдэгдсэн болон шийдэгдэх шатандаа яваа хэрэг болон шүүхээс гарсан шийдвэрийн талаар тайлбар хийхгүй байх. Ажиллагаа хийж буй хэрэг болон шүүхээр хэрэг хянагдаж буй хэргийн ажиллагааны явцад болон бусад хэлбэрээр олж авсан мэдээлэл, албан ёсны баримт мэдээллийг олон нийтийн сүлжээ, сүлжээгээр хуваалцахгүй байх.
- 3.10. Хувийн үзэл бодлоо хуваалцахгүй байх. Ирээдүйд шийдвэрлэж болзошгүй хэрэг маргааны талаар өрөөсгөл ойлголтыг бий болгож болзошгүй бодол санаа эсвэл агуулга нийтлэхгүй байх.
- 3.11. Хуулийн зөвлөхийн хувиар үзэл бодлоо илэрхийлэхгүй байх. Ийнхүү ойлгогдож болох аливаа үйлдлээс зайлсхийх.
- 3.12. Хамт олны ур чадвар, нэр төрийг хэлэлцүүлэгт оруулахгүй байх.
- 3.13. Байгууллагынхаа нэрийн өмнөөс олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэлж буй бичлэгийн талаар сэтгэгдэл оруулахгүй байх. Шүүхийн үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэдэг гэдгийг олон нийт мэдэх боломжтой байдгийг анхаарах.
- 3.14. “Хуваалцсан нийтлэлүүд нь өөрсдийнхөө санаа бодлыг илэрхийлэхгүй” гэх байдлаар хариуцлага хүлээхгүй байх нь тэдний хуваалцах, лайк дарах, retweet хийх болон бусад ижил төстэй харилцаандаа ёс зүйтэй байх үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөхгүй гэдгийг ойлгож байх ёстой.
- 3.15. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээнд хуваалцахаасаа өмнө зураг, видео бичлэг зэрэг коммент үүсгэх тохиргоог маш болгоомжтой сонгох.



3.16 Хүний хувийн мэдээлэл /амьдрал/-ийг дээдлэх зарчмын дагуу гуравдагч этгээдийн зөвшөөрөлгүйгээр түүний зураг болон хамаарал бүхий мэдээллийг нь бусадтай хуваалцах, шоглохгүй байх.

3.17. Урлаг, утга зохиол, шинжлэх ухааны бүтээлийн нэрээр хуваалцсан ч гэсэн нийгмийн үнэт зүйлсийг гутаан доромжилсон, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд эргэлзэж болзошгүй олон нийтийн сүлжээний контентыг бусадтай хуваалцахгүй, лайк дарахгүй байх.

3.18. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээнд хуваалцахдаа зураг, видео бичлэг зэргийг маш болгоомжтой сонгох, аливаа албан ёсны баримт бичгийг задруулахаас зайлсхийх.

3.19. Төрийн үйлчилгээнд зориулан гаргасан техник хэрэгслээр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээнд нэвтрэхгүй, мөн нийтлэл хуваалцахгүй байх

3.20. Арилжааны болон сурталчилгааны зорилготой нийтлэлийг түгээхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авахаас зайлсхийх.

3.21. Эргэлзэж байгаа, олон нийтийг төөрөгдүүлж, олон нийтийн дургүйцлийг төрүүлж, эмх замбараагүй байдал үүсгэж болзошгүй аливаа мэдээ мэдээллийг түгээхэд хувь нэмэр оруулахгүй байх.

3.22. Шударга ёс, хараат бус байдал, мэргэжлийн нэр төр, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалж, эдгээртэй зөрчилдөх магадлалтай нийтлэлийг эсэргүүцэх боломжгүй ч гэсэн устгах эсэхэд болгоомжтой хандах. Бусдад буруу ойлголт төрүүлэхээс зайлсхийх.

3.23. Ойр дотны болон гэр бүлийн гишүүдийн олон нийтийн сүлжээгээр нийтэлсэн нийтлэл нь шударга, хараат бус байдал, мэргэжлийн нэр төр, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг эргэлзээтэй болгохгүй байхад анхаарах.

4. Кибер эрсдэлийн эсрэг цахим төхөөрөмж, нийгмийн сүлжээний аюулгүй байдал, нууцлалын тохиргооны ач холбогдлыг судлах

- 4.1. Ашиглах цахим төхөөрөмж, нийгмийн сүлжээний аюулгүй байдал, нууцлалын тохиргоог судалж мэдсэн байх.
- 4.2. Цахим орчинд хадгалсан өгөгдлийг хадгалахад нууцлалтай холбоотой тохиргооны нууцлалыг анхаарч, гуравдагч этгээд авах боломжтой эсэхэд хяналт тавьж, устгасан бичиг баримт, хувийн мэдээлэл зэргээ нягталж байх.
- 4.3. Нийгмийн сүлжээнд хувь хүний мэдээллээ аль болох бага оруулах, хэн үзэх боломжтой байхад тохиргоо хийх, зураг, бичлэг, контент, бичвэртээ хязгаарлалт хийх,
- 4.4. Аюулгүй байдлын үүднээс байрлаж буй газар, зураг, бичлэг болоод хамт ажиллагсдынхаа мэдээллийг нийгмийн сүлжээнд бусадтай хуваалцахгүй байх.



5. Нийгмийн сүлжээний талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх байх

- 5.1. Нийгмийн сүлжээний групп-д нэгдэхдээ тэдний үйл ажиллагааны зорилго, гишүүнчлэл тавигдах шаардлага, элсэхэд шаардагдах мэдээлэл зэргийг мэдсэн байх.
- 5.2. Гэр бүлийн гишүүддээ аюулгүй байдал, нууцлалын талаар анхааруулах.

ДҮГНЭЛТ

Шүүх эрх мэдлийн бие даасан, шүүгчийн хараат бус, халдашгүй байдлын үндсэн зарчмаас хамааран шүүгчийн хувийн буюу иргэний эрхэд тавих хязгаарлалтуудыг тусгайлан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 53 дугаар зүйлд тусган хуульчлан зохицуулсан байдаг билээ.

Шүүгч иргэн хүнийхээ хувиар нийгмийн харилцаанд оролцохдоо нийгмийн сүлжээнд, цахим орчинд хэрхэн биеэ зүй зохистой авч явах талаар мэдлэг мэдээлэлтэй байх зайлшгүй шаардлага тавигдах болов.

Хэдий нэг талаас шүүгч хүн мэдээлэл авах, түгээх, өөрийн хувийн орон зай, үг хэлэх эрх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй боловч мөн нөгөө талаас холбогдох хууль тогтоомжоор шүүгчид хориглосон, хязгаарласан, үүрэг болгосон цөөнгүй тохиолдлууд байдаг.

Ямар тохиолдолд хуулийн хязгаарыг давах, хуулийн хориглосон, хязгаарласан, үүрэг болгосон хязгаарлалт чухам яг хаана байдаг талаар судалж мэдсэн байвал зохих төдийгүй нийгмийн сүлжээ, цахим орчинд дээрх хязгаарын хүрээнд, хуулийн зохицуулалтыг ягштал баримтлах нь зайлшгүй шаардлагатай.

Манай улсад яг одоогоор шүүгчийн ёс зүйг нарийвчлан зохицуулсан дүрэм, журам байхгүй байна. Тэр дундаа нийгмийн сүлжээнд шүүгч хэрхэн биеэ авч явах талаар ямар ч зохицуулалт, ойлголт, мэдлэг мэдэгдэхүүн байхгүй байна гэж дүгнэхэд болохоор байна.

Жишээ нь шүүгч хүн ямар зураг, бичвэр, сэтгэгдэл нийгмийн сүлжээнд нийтлэх, ямар мэдээллийг хуваалцах, дэмжиж байгаагаа илэрхийлэх, хэнтэй найз байх, хэрхэн яаж харилцах, ерөөс нийгмийн сүлжээ гэж юу болох, ямар хэлбэр, төрөлтэй, түүнд ямарваа нэгэн бичвэр бичвэл хэрхэн яаж хадгалагддаг, нийтлэг тавигддаг ёс зүйн шаардлага бий эсэх, нийтээр хүлээн зөвшөөрсөн, зөв эерэг, голч шударга, төвч байдлаар хэрхэн түүнд биеэ авч явах, аливаад хандах, тэгж ойлгогдох зэрэг наад захын мэдлэг мэдээлэл бидэнд дутмаг байна.

Өнөөгийн хурдтай хувьсан өөрчлөгдөж улам бүр цахимжиж, нийгмийн бүхий л харилцаа бүхэлдээ цахимд шилжиж, нийтийг хамарсан цахим орчин, нийгмийн сүлжээ, сошиал хэрэглээ хурдацтай хөгжиж, улам бүр түүнээс хамааралтай болж буй өнөө үед нийгмийн сүлжээнд шүүгчийн баримтлах ёс зүйг тодорхойлон зохицуулах хэрэгцээ шаардлага хэдийн бүрэлдэн бий болжээ.



ХӨДӨЛМӨРИЙН МАРГААНЫ ШҮҮХИЙН ХАРЬЯАЛЛЫН ЗААГ ЯЛГАА



Ч.Хандулам
Хэргийн хөдөлгөөний
удирдлагын хэлтсийн
дарга



Ж.Баянжаргал
Хэргийн хөдөлгөөн
хариуцсан референт



Б.Оч
Хэргийн хөдөлгөөний
бүртгэл, дүн шинжилгээ
хариуцсан ахлах шинжээч

Төрийн албан хаагч нь төрийн захиргаа, төрийн улс төрийн, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагч гэж ангилах бөгөөд тус албан хаагч нь тодорхой чиг үүрэг гүйцэтгэн цалин хөлс авч, ажиллах нөхцөл баталгаагаар хангагдан ажиллаж, эрх нь хамгаалагдаж байхаар Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулсан.

Төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрлөх эрх нь зөрчигдөж, үүссэн маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэж ирсэн хэдий ч иргэний хэргийн шүүх энэ төрлийн хэрэг, маргааныг мөн харьяалан шийдвэрлэх, шүүхийн хэргийн харьяаллын талаарх практикт андуурах асуудал багагүй байдаг тул дээрх зааг ялгааг тодорхой болгох шаардлагатай байна.

Төрийн албаны тухай хууль болон нийтийн эрх зүйн хүрээний салбарын бусад хуулиудаар тухайн салбарт төрийн алба хашиж буй албан хаагчийн эрх зүйн байдлыг зохицуулснаар нийтийн эрх зүйн харилцааны зарим шинжийг агуулсан гэж, эндээс уг харилцаа нь хоёр салбар хоорондын холимог шинжийг агуулсан гэж дүгнэж болно.¹

Энэ харилцаа нь: Уг харилцаанд оролцох субъектээр болон ажлын байрны чиг үүргээрээ онцлог ялгаа бий.

Төрийн алба хашихтай холбоотой хөдөлмөрийн харилцааг оролцогч субъектээр нь авч үзвэл: Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээд төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит

¹ Б.Уранцэцэг. “Төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг хамаарч судлах шинжлэх ухаантай, харьяалж зохицуулах салбартай болгоё”. Удирдлагын академи.Удирдах эрдэм.УБ,2009 он, 38 дахь тал



үйлдвэрийн газрыг байгуулна. Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар² гэнэ.

“Төрийн алба” гэсэн ойлголт нь захиргааны бүтцэд хамгийн бага нэгж бөгөөд орон тоо, ажлын байр, “Захиргааны байгууллага” гэж төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж буй, нийтийн эрх зүйн хэм хэмжээнд үндэслэгдсэн, эрх мэдлийг хэрэгжүүлж буй, нийтийн эрх зүйн хэм хэмжээнд үндэслэгдсэн, тодорхой хариуцсан чиг үүрэгтэй, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах тусгай эрх хуулиар олгогдсон, үйл ажиллагаатайгаа холбогдон гарсан хариуцлагыг бие даан хариуцдаг албан хаагчийн солигдохоос үл хамааран байж байдаг хаагчийг “Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс буюу төсвөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээд” хэмээн тодорхойлсон³.

Төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг онцлогийг авч үзвэл:

Төрөөс дагнан хэрэгжүүлдэг тусгай үүрэг байхаас гадна төрөөс тодорхой хэсгийг нь хэрэгжүүлдэг чиг үүрэг, үйлчилгээ байдаг. Чиг үүргийн энэ ялгаанаас төрийн албыг төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны алба, үндэсний болон хүн амын аюулгүй журмыг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн тусгай алба (төрийн жинхэнэ алба), мөн нийгмийн суурь үйлчилгээг адил тэгш, хүртээмжтэй хүргэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний алба гэж зарчмын хувьд ангилна.⁴

Нийгэм дэх хөдөлмөрийн харилцаа хөлсний хөдөлмөр, төрийн албан хаагчдын хөдөлмөр, хувиараа эрхлэх хөдөлмөр, хоршсон хөдөлмөр гэхчлэн хуваагддаг ч эдгээр нь хүний ажиллах хүч, түүний зарцуулалт шаардагддаг, үр дүнтэй байх, зорилго чиглэлтэй байх гэх мэт нийтлэг шинжүүдийг өөртөө агуулдаг, эдгээрийн онцлог шинжид нь тохирсон зохицуулалт мөн шаардлагатай болдог ба төрийн албаны хүрээнд үүсэж буй хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн эрх зүйн харилцааны суурь зохицуулалт бүхий Хөдөлмөрийн тухай хуулиар, төрийн алба, түүн дотроо төрийн жинхэнэ албаны онцлогоос хамаарч Төрийн албаны тухай хуулиар, төрийн албаны тусгай чиг үүргийн хүрээнд эрхэлж буй албан тушаалын онцлогоос хамаарч салбарын хуулиар тус тус зохицуулагдаж байна.⁵

2 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996 он)-ийн 13.1.1, 14.1.1

3 Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1

4 Төрийн албаны тухай хуулийн 3, 5, 6, 7, 8, 9, 11 дүгээр зүйл

5 Б.Уранцэцэг. “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг зохицуулах хуулиудыг харилцан шүтэлцээтэй болгох нь”, Боловсролын менежмент сэтгүүл, 2008 он, №1, 2 дахь тал



Тодорхой чиг үүрэг гүйцэтгэн цалин хөлс авч, ажиллах нөхцөл баталгаагаар хангагдан ажилладаг хөдөлмөрийн харилцааны үндсэн шинжийг адил агуулж байдгаараа төрийн албан хаагчийн хөдөлмөрлөж буй харилцааны суурь нь Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагддаг.

Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан асуудлаар иргэн /төрийн албан хаагч/ шүүхэд гаргасан нэхэмжлэлийн тоон мэдээллийг Захиргааны хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны “Иргэн-2014” нэгдсэн системээс нэхэмжлэл гаргасан байдлыг судлан үзлээ.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хувьд:

График1. Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүлээн авсан нийт нэхэмжлэл



Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системээс 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар Захиргааны хэргийн анхан шатны шүүх нийт 25843 нэхэмжлэл хүлээн авсны 10.4 хувь буюу 2695 нэхэмжлэл нь Төрийн албаны тухай хуульд заасан асуудлаар гаргасан байна. /График1./

График2. Захиргааны хэргийн шүүхэд Төрийн албаны тухай хуульд зааснаар шүүхэд гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэсэн байдал





Сүүлийн 10 жилийн байдлаар харьцуулан үзвэл :

2018 онд Төрийн албаны тухай хуульд заасан асуудлаар нийт 3 нэхэмжлэл гаргасан байх бөгөөд уг 3 нэхэмжлэлд захиргааны хэрэг үүссэн байна. Энэ нь бусад онтой харьцуулахад хамгийн бага үзүүлэлт байна. Харин 2023 онд нийт 35 нэхэмжлэл гаргасан байх бөгөөд үүнээс 32 нэхэмжлэлд захиргааны хэрэг үүсгэж, 3 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. Энэ нь бусад онтой харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байна. /График2./


Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хувьд:

График3. Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүлээн авсан нийт нэхэмжлэл



Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны “Иргэн-2014” нэгдсэн системээс 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар Иргэний хэргийн анхан шатны шүүх 627904 нэхэмжлэл хүлээн авсны 2.8 хувь буюу 17718 нэхэмжлэл нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан асуудлаар гаргасан байна. /График3./

График4. Иргэний хэргийн шүүхэд Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар шүүхэд гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэсэн байдал



Сүүлийн 10 жилийн байдлаар харьцуулан үзвэл :

2023 онд Хөдөлмөрийн тухай хуульд заасан асуудлаар нийт 1258 нэхэмжлэл гаргасан байх бөгөөд үүнээс 867 нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэж, 379 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байгаа нь бусад онтой харьцуулахад хамгийн бага нэхэмжлэл гаргасан байна. Харин 2017 онд нийт 2518 нэхэмжлэл гаргасан байх бөгөөд үүнээс 2104 нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэж, 386 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байгаа нь бусад онтой харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байна. /График4./


График5.Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нийт хүлээн авсан нэхэмжлэл



Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системээс 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар Төрийн албаны тухай хуульд заасан асуудлаар нийт 2695 нэхэмжлэл гаргаснаас 514 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна./график5./

Татгалзсан нэхэмжлэлийн шалтгаан нөхцлийн дийлэнх нь нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоож, хангаагүйн улмаас нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. Харин шүүхийн харьяалал зөрчсөний улмаас 5 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тохиолдол байна.

График6.Иргэний хэргийн анхан шатны шүүхийн нийт хүлээн авсан нэхэмжлэл





Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны “Иргэн-2014” нэгдсэн системээс 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар Хөдөлмөрийн тухай хуульд заасан асуудлаар 17718 нэхэмжлэл гаргаснаас 1029 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна./графикб./

Татгалзсан нэхэмжлэлийн шалтгаан нөхцлийн дийлэнх нь урьдчилан шийдвэрлэх ажиллагааг зөрчсөний улмаас нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тохиолдол байна.

Дээрх асуудлыг судлан үзэхэд хөдөлмөрийн маргааны талаарх ойлголтын зөрүүтэй асуудлыг тодорхой болгож эргэлзээгүй, нэг мөр ойлголттой болгох шаардлагатай байна.

Үүнд:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.3 дахь заалтад “Нэхэмжлэл гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг.” гэж тус тус зааснаар хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг.

Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар төрийн улс төрийн, тусгай, захиргааны албан хаагчдыг ажлаас үндэслэлгүй халагдсан тухай маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ.



Төрийн үйлчилгээний албан хаагчийг ажлаас халах шийдвэрийг Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.1 дэх заалтад “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага;” гэж заасан захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан хэдий ч нэхэмжлэгч нь тухайн ажлыг эрхлэхдээ онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан бол хөдөлмөрийн эрхийн харилцаа үүснэ. Иймд уг маргааныг ерөнхий харьяаллын шүүх буюу иргэний хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

Өөрөөр хэлбэл, хариуцагчаар татагдсан этгээд нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан байж болох ч ажилд авах тухай тушаалын агуулга нь тухайн ажлыг эрхлэх онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан бол энэ маргааныг иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэнэ.

Дүгнэлт

Иргэд Иргэний хэргийн шүүх, Захиргааны хэргийн шүүхийн аль шүүхэд хандах зааг ялгааг мэдэхгүйгээс шүүхийн харьяаллыг зөрчих явдал цөөнгүй байна. Иргэн хөдөлмөрийн гэрээ байгуулснаар Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандах хууль зүйн зохицуулалттай байдаг. Харин төрийн байгууллагад тушаалаар томилогдож хөдөлмөрийн гэрээ байгуулалгүйгээр хөдөлмөрийн харилцаанд орсон иргэний эрх ашиг хөндөгдсөн бол Захиргааны хэргийн шүүхэд хандах эрхтэй.

Иймд иргэдийн эрх зүйн боловсрол, чадавхыг дээшлүүлэх үүднээс шүүхийн харьяалал, хөдөлмөрийн маргааны зааг ялгааны талаар шүүхэд хэрхэн хандах талаар мэдээ, мэдээлэл, танилцуулгыг олон нийтийн цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хүргэх шаардлагатай байна.

ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС



ГЭР БҮЛИЙН БОЛОН СЭТГЭЛ САНААНЫ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА БА АНХААРАХ ЗАРИМ АСУУДЛУУД



*Т.Энхгэрэл
Шүүхийн захиргааны сургалт судалгааны
төвийн Сэтгэл зүйч-судлаач*

УДИРТГАЛ

“Гэр бүлийн тухай хууль”-ийн 14.4.Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх энэ хуулийн 14.2-т заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцална; гэж заасан байдаг. Энэ заалтын “тогтоогдсон” гэдэг нь хүчирхийллийн улмаас бие махбодод үүссэн гэмтэл, эрүүгийн болон зөрчлийн арга хэмжээ авагдсан, цагдаагийн байгууллагад өгсөн дуудлага, түүний мөрөөр ажилласан албан хаагчийн тэмдэглэл зэргийг ойлгодог. Гэвч хүчирхийлэлд байсан хэр нь түүнийгээ нотлох баримт цуглуулаагүй, сэтгэл санааны хүчирхийлэлд байсан зэрэг асуудлууд нь энэ хуулийн заалтаас гадуур буюу эвлэрүүлэн зуучлалаар дамжин шийдэгддэг. Эдгээр хүмүүстэй уулзалт ярилцлага хийх явцад нийтлэг ажиглагддаг хохирогч, хүчирхийлэгчийн сэтгэл зүйн практикт илэрдэг онцлогууд болон хүчирхийлэлтэй холбогдох очин үеийн чиг хандлагууд, цаашид анхаарах асуудлуудын талаар энэхүү өгүүллээр хөндөх болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.1.«гэр бүлийн хүчирхийлэл» гэж энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг; ойлгохоор хуульчилжээ.

Хүүхэд хамгааллын тухай хуульд 4.1.8.“хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг; хэмээн тус тус тодорхойлсон байна.



Харин хохирогчийн тухайд нэлээд өргөн хүрээнд судлах хэрэгцээ үүссэн ба манай улсын болон олон улсын нийтлэг баримт бичгүүдэд дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- 1985 оны НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 40/43 тогтоолоор баталсан “Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчийн талаарх шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмуудын тухай тунхаглал”-д “Хохирогч” гэж “гэмт хэрэг, эрх мэдлээ хортойгоор ашигласан болон хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас бие эрхтэн, оюун сэтгэхүйн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, сэтгэл санааны зовлон шаналалд автсан, эд материалын хохирол хүлээсэн үндсэн эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдсэн хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ”
- “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-д 8.1. “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ”.
- “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-д 5.1.2. “гэр бүлийн хүчирхийллийн хохирогч” /цаашид “хохирогч” гэх/ гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг;
- Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандарт-д “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон, эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүнийг; гэх зэргээр тодорхойлжээ. Эдгээрт нийтлэг байгаа нэг ойлголт нь бие махбод болон эд хөрөнгөөс гадна оюун сэтгэхүй, сэтгэл санаа, эд хөрөнгийн бус хохирол зэргээр сэтгэл зүйн асуудлуудыг хохирогчийн тухай тодорхойлолтод онцлон тусгасан байна. Гэвч хуульд заасан үндэслэлийн хүрээнд сэтгэл санааны хүчирхийллийг хэрхэн тогтоох, нотлох зэрэг нь учир дутагдалтай байна.

Мөн хохирогч гэх тодорхойлолтод аль нэг хүйсийн хүрээнд давуу эсвэл сул тал байхаар онцлоогүй, харилцан тэгш буюу хүн, хувь хүн, хуулийн этгээд, зэргээр хамруулан тодорхойлсон ч бодит байдал дээр эрэгтэй хүний хүчирхийлэлд өртсөн байдлыг хүлээн зөвшөөрөх, холбогдох хуулийн хүрээнд асуудалд хандах нь бага байгаа нь ажиглагддаг.

Тэгвэл уг асуудлын хүрээнд хүчирхийллийн талаарх дэлхий нийтийн ойлголтод шинэ салхи оруулсан дуулиант шүүх хурал 2022 оны 4-6 сарын хооронд 6 долоо хоногийн хугацаанд болж өнгөрөв. Тус шүүх хуралд жүжигчин Жонни Депп өөрийнх нь нэр төрд халдсан хэргээр гэрлэлт цуцлуулсан эхнэр



жүжигчин Эмбер Херд-ээс 50 сая доллар нэхэмжилсэн байдаг. Гэвч бидний гол анхаарах зүйл бол бүх төрлийн хүчирхийлэлд зөвхөн эмэгтэй хүн өртдөггүй, эрэгтэйчүүд ч мөн өртөж болдог гэх ойлголт юм. Энэхүү шүүх хуралдааны үр дүнд жүжигчин Жонни Депп экс эхнэр Эмбер Хердийн зүгээс бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртдөг байсан нь тогтоогдсон ба Dior брэндийн нүүр царайгаар ажиллах болсон түүнийг эхнэрийнх нь зүгээс хөгшин, өвгөн гэх зэргээс гутаан доромжилж байсан гэх. Эдгээр болон бусад зөрчлүүдийг тодруулсны үндсэн дээр жүжигчин эрийг бие махбод болон, сэтгэл санааны хүчирхийлэлд өртдөг байсан гэж үзэж түүний нэхэмжлэлийн ихэнх хэсгийг хангасан байдаг. Эндээс бид гэр бүлийн хүчирхийлэлд зөвхөн эмэгтэй хүн өртдөг гэх нийтлэг ойлголтоо залруулж гэр бүлийн хүчирхийлэлд эрэгтэй хүн ч мөн өртдөг, мөн эцэг, эхийн хоорондын хэрүүл маргаан, таарамжгүй харилцааны явцад шууд болон шууд бусаар хүүхэд ч мөн адил сэтгэл санааны болон үл хайхрах хүчирхийлэлд өртөж байдаг гэдэгтэй санал нэгдэх шаардлага үүсэж байна. Манай улсад ч мөн ийм байдал цөөнгүй тохиолдох болсон.

... ачигдаад явж байхдаа цагдаагаас нь асуусан юм. Би зодуулаад нүүр ам хөхөрчихсөн байгаа биз дээ. Би өөрийгөө хамгаалах гэж л гарыг нь барьж хориглож байсан. Гэтэл яагаад би арга хэмжээ авхуулаад хоригдохоор болж байгаа юм бэ? гэхэд цагдаа “чи эр хүн юм байгаа биз дээ. Тэр эмэгтэй хүн чамайг зодоод гэмтээж чадах уу?” гэсэн. Бодит байдал дээр эхнэр намайг гартаа таарсан зүйлээрээ цохиж, гэр орноо бусниулж байсан. Ингээд би эрэгтэй хүн учраас хүчирхийлэгч болж, эхнэр хохирогч болоод үлдсэн. Ахиад нэг л удаа ийм байдал үүсвэл би эрүүгийн хэрэгтэн болно гэж надад хэлсэн.

Үйлчлүүлэгчтэй хийсэн ярилцлагаас...

Гэр бүлийн хүчирхийлэл бусад хэрэг, зөрчлөөс ялгаатай нь гэр бүлийн хамаарал бүхий хүний зүгээс үйлдэгддэг. Энэ нь хоорондын холбоо хамаарал байгаа учраас үнэн бодит байдлыг тогтооход хүндрэлтэй байдаг. Иймд зөвхөн цагдаагийн албан хаагч гэлтгүй шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд ч гэсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлын хүрээнд ажиллахдаа мэргэжлийн болон хувь хүний талаас маш мэдрэмжтэй ажиллах шаардлага үүсэж байна.

Хүчирхийллээс үүсэх сэтгэл зүйн гэмтэл, хүндрэлүүд:

Гэр бүлийн хүчирхийллийг сэтгэл зүйн талаас авч үзвэл хамгийн хор уршигтай, тодорхойлох, илрүүлэхэд нарийн төвөгтэй хэлбэр нь сэтгэл санааны хүчирхийлэл байдаг. Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь бусдынхаа хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, доромжлох, дорд үзэх, айлган сүрдүүлэх, заналхийлэх, нэр төр алдар хүндийг нь гутаах, гүтгэх, мөрдөн мөшгөх, ах дүү, төрөл төрөгсөд, хамт олноос тусгаарлах, эд хөрөнгөө сүйтгэх, гэрийн тэжээмэл амьтанд уур хилэнгээ гаргах болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл



санааны хүчирхийлэл гэнэ. Хамгийн түгээмэл үйлдэгддэг хүчирхийллийн төрөл боловч хүмүүс үүнийг хүчирхийлэл гэж ойлгох нь бага, анзаарч таньдаггүй тул байнга давтагдаж байдаг. Мөн хүн бүрийн сэтгэл зүйн төлөв байдал өөр өөр байдаг нь энэ төрлийн хүчирхийллийг эрт мэдэх, тогтооход хүндрэл үүсгэх боломжтой. Зарим хүн мэдрэмж бага байдаг бол зарим нь мэдрэмтгий, эмзэг зөөлөн, зарим нь бүр хэт мэдрэмтгий байдаг. Гаднаас нь харахад сүртэй биш, хүчирхийлэл биш юм шиг харагдах ч тухайн хүний сэтгэл зүйд үүсэж буй нөлөөлөл, хор уршиг нь илүү хурц хэлбэрийн байж болно. Эсрэгээрээ зарим хүмүүс хүчирхийлэлд байдаг ч үүнийгээ хүчирхийлэл гэж үздэггүй, гэр бүлд байдаг л зөрчил мэтээр хүлээн авах нь ч тохиолддог. Ингээд үзэхээр хүчирхийллийг тогтоох, сэтгэл зүйд учрах хор хохирлыг хүн бүрт адил шалгуур тавих нь хүндрэлтэй байдаг.

Хуульд заасан үндэслэл тогтоогдсон юм байхгүй, дээрээс нь энэ хүн надаас салахгүй, хүүхдүүдээ бодно, эвлэрнэ гээд байгаа. Учиргүй барьж аваад зодоод байдаггүй ч хажууд нь байхад их төвөгтэй хүн. Намайг байнга л элдвээр хэлж гоочилж байдаг. Би энэ хүнээс болж амиа хорлох тухай удаан хугацаанд бодож байсан. Эхнэр нь захиа үлдээгээд амиа хорлосон тухай мэдээг фейсбүүкээс хараад коментуудыг нь уншихад нөхөр нь амиа хорлоход хүргэсэн байна гэсэн хүмүүсийн сэтгэгдлийг уншаад надад нөмөртэй санагдсан, намайг ч бас хүмүүс ингэж өмгөөлөх болов уу? зориглоод үздэг ч юм билүү гэсэн бодол төрсөн.

Үйлчлүүлэгчтэй хийсэн ярилцлагаас...

Хэдийгээр хүчирхийлэлд ямар ч зөвтгөл, хүлээн зөвшөөрөгдөх түвшин байх учиргүй боловч хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг хариу үйлдлийн шинжтэй болон түрэмгий зан үйлийн шинжтэй байдлаар нь ялгаж авч үзэх шаардлагатай.

Хариу үйлдлийн шинжтэй хүчирхийлэл нь удаан хугацаанд үргэлжилсэн сэтгэл санааны болон бие махбодын хүчирхийллээс үүдэн өөрт хадгалагдсан сөрөг сэтгэл хөдлөлөө хүчирхийллийн хэлбэрээр илэрхийлэх ба ихэнх тохиолдолд энэ нь тухайн хүний зарчим, төлөвшилттэй зөрчилдөж байдаг. Жишээ нь “би хэзээ ч эмэгтэй хүнд гар хүрэхгүй гэдэг зарчимтай” гэх ч маргааны явцад биеэ хянах чадвар алдагдаж хүчирхийлэлд хүрсэн тохиолдол зөвлөгөөний явцад цөөнгүй тааралддаг. Өдөөгчийн хүчгүйгээр хүчирхийлэл үүсдэггүй төрөл гэж ойлгож болно.

Харин түрэмгий зан үйлийн шинжтэй хүчирхийлэл нь маргаанд давуу байдал олох, хүчээр асуудлыг шийдвэрлэх, илүү хүчирхэг байдлын мэдрэмж үүсгэх, сэтгэл зүйн болон асуудлыг шийдвэрлэх чадваргүй байдлын сул талуудаа өнгөлөн далдлах зэрэг маш олон шалтгаанаар үүсдэг. Ялгаа нь энэ төрлийн хүчирхийлэл давтагддаг бөгөөд хохирогчийн өөрийн эрхшээлд байлгахыг ямагт хичээж байдаг.



Хохирогчийн сэтгэл зүйн 4 үе шат

1-т Айдас. Хамгийн анхны хүчирхийлэлд өртөхөд тархины төвд байрлах сэтгэл хөдлөл түүнтэй холбоотой хариу үйлдэл, боловсруулалтад чухал үүрэг гүйцэтгэдэг хэсэг буюу Амугдала төвд маш хүчтэй цочрол үүсдэг. Ингэснээр аюул, хамгаалалт буюу цочрол паник, айдас үүсдэг. Гэхдээ гадны нөхцөл байдлаас боллоо гэж нөгөө хүнээ зөвтгөх байдал зарим тохиолдолд үүснэ. Надаас боллоо, ууртай байсан болохоороо л ингэлээ, согтуудаа л... гэх зэргээр уучилж өнгөрөөдөг ч айдас үлдсэн хэвээр байдаг. Энэ үе шатын тухай үйлчлүүлэгчид эргэн дурсахдаа “анхнаасаа таслан зогсоогоогүй нь миний буруу байсан. Согтуудаа л тэгчихлээ, уурандаа л цохчихсон байх гэж бодоод тэсдэг байсан” гэхчлэн ярьдаг.

2-т Хариу үйлдэл буюу тэмцэл: Хүлээн зөвшөөрч чадахгүй гэдгээ илэрхийлж хэрүүл, тэмцэл, харилцан хүчирхийлэл үүсгэнэ. Гэвч нөгөө талаас “ингээд нэмэргүй, хүчний давуу тал надад байгаа” гэсэн мэдрэмж үүсгэж байвал давуу талаа хүчирхийлэл үйлдэгч өөртөө авах үед 3 дах шатанд орно. Энэ үе шатандаа гэрлэлт цуцлуулахаар хандсан талууд ихэнхдээ “сүүлийн үед байнгын хэрүүлтэй байгаа, заримдаа харилцан зодолддог” гэхчлэн нөхцөл байдлаа илэрхийлдэг.

3-т Хамгаалалт буюу зайлсхийх. Хэрүүл үүсгэх юм ярихгүй байх юмсан, хийхгүй байх юмсан, уулзахгүй байх юмсан, ажил дээрээ оройтож ажиллах, тусдаа амьдрах зэрэг дайжих шинж тэмдгүүд илэрнэ. Хүүхдийн хувьд гэрээсээ дайжих, дуугаа хураах, харилцааны идэвхгүй болох гэхчлэн шинжүүд илэрнэ. Энэ үе шатанд гэрлэлт цуцлуулахаар хандсан талууд ихэвчлэн гэр бүлдээ цаг гаргаа байсан, илүү цагаар хэт их ажилдаг, согтууруулах ундаа хэрэглэх нь ихэссэн гэх асуудлыг илэрхийлдэг ба үүний бодит шалтгаан нь хэрүүл маргаан, таарамжгүй харилцаанаас зайлсхийх сэтгэл зүйн хамгаалалтын хариу үйлдэл байдаг.

4-т Цөхрөл. Энэ үе шатанд байдал улам хүндэрсэн байдаг. Гэрлэлт цуцлуулах, харилцаагаа бүр таслах алхмыг хохирол улам ихсэхээс өмнө өрсөж хийж эхэлдэг. Мөн айдас нь өрсөх гэдэг команд өгч байдаг. Энэ бол амьтны зөн, хүнд үлдсэн араатанлаг шинжийн илрэл байдаг. Энэ нь хүчирхийлэл үйлдэгч, хохирогч хоёрын хэн хэний амь нас эрүүл мэндэд халтай болж эхэлнэ. Хэргийн оролцогчидтой хийх ярилцлагын явцад “энэ хүнтэй цаашид хамт амьдарвал би эсвэл энэ хүн, хэн нэг нь үхэж магадгүй” гэх ба эрсдэлт нөхцөл байдал үүссэн тухай нийтлэг ярьдаг.

Хэдийгээр шууд маргаан, зөрчил, бие махбодын хүчирхийлэлд оролцоогүй ч дээрх сэтгэл зүйн илрэлүүд зарим хэлбэрээр хүчирхийллийг дэргэдээс нь харж байгаа хүүхдэд мөн илэрдэг. Хүүхэд бага насанд байх тусам хүчирхийллээс илүү хурц түгшүүр болон гүн траума буюу гэмтлийг өөртөө авдаг. Цэцэрлэг, сургуулийн өмнөх насныхан надаас боллоо, би сахилгагүйтсэнээс боллоо гэсэн өөртөө бурууг өгөх байдал



зарим тохиолдолд илэрдэг. Учир нь хүүхдийн тухайн үеийн амьдралын төв нь хүүхэд өөрөө байдаг. Амьдрал, хүүхдийн эргэн тойрон үргэлжилж буй үйл явдлын гол дүр нь гэсэн үг. Гэтэл хайртай хүнийг нь хайртай хүн нь хүчирхийлэх, зодох, үүнийг харах нь хүүхдэд маш хүнд цохилт болох боломжтой. Хүүхдийн үнэлэмжид эцэг эхтэй холбоотой айдас, эргэлзээ бүрэлдэн тогтдог.

Зарим нөхцөлд хүүхдэд дээрх илрэлүүд үүссэнээс үүдэн бага насанд болон насанд хүрсэн хойно гэр бүлийн амьдралд оролцоход хүчирхийлэлд дасан зохицолт явагдах нь цөөнгүй байдаг. Насанд хүрсэн хойно тухайн хүний хүмүүжил төлөвшилт, амьдралын түүх, өссөн орчин, сэтгэл зүйн хувьд цочролыг хүлээн авах байдал зэргээс хамаарч хүн бүрийн хүчирхийлэлд дасан зохицолт явагдах хугацаа өөр өөр байдаг. Нэгэнт дасан зохицолт явагдаж хүчирхийллийг гэр бүлийн харилцаанд хааяа байдаг л зүйл гэх ойлголт үүсэж хүлээн зөвшөөрч эхэлсэн бол гэрлэлт цуцлуулах, хариу арга хэмжээ авах идэвх багасдаг ба хүчирхийллийг хүлцэн зөвшөөрдөг. Үүнийг хааяа л ийм зүйл болдог, уухаараа л хүчирхийлэл үйлддэг, зэргээр зөвтгөж байдаг. Ингэснээр нэгнийхээ болон өөрийнхөө үйлдлийг хянаж эхэлдэг. Уурлуулахгүй байх юмсан, архи уулгахгүй байх юмсан гэхчлэн. Нөхцөл байдал даамжрах тусам айдас ихэсдэг, айдас ихсэх тусам итгэл найдвар багасдаг. Гэрлэгчдийн харилцаанд хайр, хамтын зорилго бус айдас, хүүхдээр холбогдсон харилцаа үлддэг. Энэ нь архаг цочрол, гэмтэлд ордог.

Зарим хүмүүс хүчирхийллийг огт хүлцдэггүйг энд дурдах нь зүй болов уу. Энэ бол тухайн хүний амьдралын түүхийн хэсэгт хүчирхийлэлтэй холбоотой цочрол бага буюу огт байхгүй ба хүчирхийллийн талаар мэдлэг мэдээлэл сайн, эсвэл зарим тохиолдолд өмнөх хүчирхийлэлтэй холбоотой таагүй дурсамжаас үүдэн жигшилт үүссэнээс хүчирхийллийг үл хүлцэх байдал бий болдог байна.

Хүчирхийлэгчийн сэтгэл зүйн дүр төрх:

Хүчирхийлэл үйлдэгчийн тухай түгээмэл дүрслэлийг ихэвчлэн эрэгтэй хүнтэй холбосон байдаг. Үүнийг түрэмгий зан үйл болон биеийн хүчний давуу байдал эрэгтэй хүнд илүү илэрдэгтэй холбон тайлбарладаг. Гэсэн хэдий ч сэтгэл санааны хүчирхийлэл нь бие махбодын чадамж бус, харин эрх мэдлийн шатлал, сэтгэл хөдлөлийн хүлцэнгүй байдлыг хамардаг тул эмэгтэйчүүд ч бас хүчирхийлэл үйлдэгч болж болно гэдгийг анхаарах нь чухал юм. Ихэнх тохиолдолд сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэгчийн дүр төрхийн гол шинж чанарууд нь хүйсээр ялгаатай байдаггүй.

Хүчирхийлэл үйлдэгч нь ихэнхдээ өөрчлөлтөд хүлцэнгүй ханддаг, алдаагаа засан залруулж, өөртөө өөрчлөлт хийж чадна гэсэн итгэлийг хохирогчид өгч байдаг ба энэ найдвар нь хүчирхийлэлтэй харилцаанд хохирогчийг тогтоон барьж байдаг. Мөн төрсөн гэр бүлтэй холбоотой



таагүй дурсамжуудыг хадгалах боловч зарим тохиолдолд үүндээ сэтгэл хангалуун байх нь бий. Гэр бүлийн харилцаанд өөрийн хяналтаа тогтоох нь хүчирхийлэл үйлдэгчийн чухал зорилтуудын нэг байх ба ихэвчлэн уур омог, давуу байдлаа ашигладаг. Эрэгтэй хүний хувьд ихэвчлэн бие мах бодын давуу байдлаа ашигладаг бол эмэгтэй хүний хувьд эмзэг байдал, түүнтэй харьцуулахад сул дорой байдал нь давуу байдал болж болдог. Хүйсийг үл харгалзан хүүхдүүд болон санхүү, сэтгэл зүйн байдал нь хүчирхийлэл үйлдэгчийн чухал давуу талууд болдог. Нийтлэг дүр төрхөөр сэтгэл хөдлөлөө хянадаггүй, өөрийн мэдрэмжээ хуваалцах чадваргүй байдал зэрэг нь хүчирхийл үйлдэгчид давуу ажиглагддаг. Үүний зэрэгцээ бусдыг мэдэрч ойлгох чадвар буюу эмпати чадвар бага, хохирогчийг буруутгах байдал ажиглагддаг. Өөрийн зан байдал, биеэ авч яваа байдал, гэр бүлийн харилцаагаа хэвийн гэж үзэх, хүчирхийлэлтэй харилцааг авч үлдэх, тэсэн тэвчүүлэх зорилгоор хүүхдийг ашиглах зэрэг онцлог шинжүүд хүчирхийлэл үйлдэгчид түлхүү илэрдэг.

Судалгаагаар өссөн хүмүүжил, туулсан амьдрал, хүрээлэн буй нийгмийн харилцаа, орчин гэх мэт олон хүчин зүйлс хүчирхийлэл үйлдэх зан үйл болон хүчирхийлэл үйлдэх сэдэл үүсэхэд нөлөөлдөг гэдгийг хэдийн баталсан ба тухайн хүний сэтгэл зүйн онцлогоос хамаарч хүчирхийлэгч эсвэл хохирогч хэвээр үлдэх гэсэн сонголтод тулна. Эндээс тухайн хүний жендерийн талаарх хэвшмэл ойлголт, хандлага, гэр бүл, нийгмийн орчноос үүдэлтэй хүмүүжил төлөвшлийн дутагдал, зан үйлийн буруу дадал зуршил зэрэг нь хүчирхийлэл үйлдэгчийг бий болгох хүчин зүйл болж болно.

ДҮГНЭЛТ

Хүчирхийлэлд өртсөн насанд хүрэгчид төдийгүй хүүхэдтэй ажиллах болон харилцаа үүсгэхдээ юуны өмнө дотоод сэтгэлдээ юу мэдэрч байгааг нь илрүүлэх, ойлгох нь хамгийн чухал бөгөөд энэ нь тодорхой итгэлцэл, сэтгэл зүйн таатай холбоон дээр суурилсан харилцаа, аюулгүй байдлыг хангасан тодорхой орон зай шаардагддаг.

Энэ бүхнийг мэргэжлийн тодорхой ур чадвар эзэмшсэн мэргэжилтний үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэх нь үйлчилгээний чанар, үнэн бодит нөхцөл байдлыг тогтоох үйл ажиллагаанд шууд нөлөөтэй. Гэвч үүнийг тухайлан заасан хэм хэмжээ стандарт чамлалттай байгаа ба шүүх дэх эвлэрүүлэн зуучлал төдийгүй шүүн таслах ажиллагааны явцад хүчирхийлэлтэй холбогдолтой хэрэг маргааныг шийдвэрлэхдээ анхаарч үзэх, албан хаагчдыг хүчирхийллийн талаар мэдлэг, мэдээллээр хангах, мэргэшүүлэх шаардлагатай байна.

**ШҮҮХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ**

*Б.Нямаа
ШЕЗ-ийн Шүүхийн сургалт судалгааны
төвийн Сэтгэл зүйч-судлаач /ССШУ-ны
магистр/*

Энэхүү өгүүлэлд 2021-2024 оны шүүхийн статистик тоон мэдээлэл болон сэтгэл зүйн чиглэлээр хийсэн судалгаанууд болон анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газарт хэргийн оролцогч нараас гаргасан шүүхийн захиргааны ажилтан¹-ы харилцаа хандлага, ёс зүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол²-ыг 2022-2023 оны байдлаар түүвэрлэн авсан судалгааг ашигласан болно.

1. Оршил

Шүүхийн нөхцөл байдал, үйл ажиллагаанд үнэлэлт өгсөн хөндлөнгийн байгууллагын дүнгээр шүүхийн индекс нь 100 онооноос 2021 онд 51.94 оноо, 2023 онд 53.22 оноогоор үнэлэгдсэн байна³. Үүнийг дэлгэрэнгүйгээр харвал:

Хүснэгт 1. Үндсэн хэмжигдэхүүн тус бүрийн үнэлгээг харуулав.

| № | Үндсэн хэмжигдэхүүн | 2021 он | 2023 он | Өсөлт/бууралт |
|---|--|--------------|--------------|---------------|
| 1 | Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал. | 51.60 | 50.31 | - 1.29 |
| 2 | Шүүхийн нээлттэй, ил тод байдал | 62.30 | 65.71 | + 3.41 |
| 3 | Шүүхэд итгэх олон нийтийн итгэл | 53.17 | 48.40 | - 4.77 |
| 4 | Шүүхийн дэд бүтэц, нөөц | 44.47 | 43.18 | - 1.29 |
| 5 | Шүүгчийн ёс зүй ба хариуцлага | 45.17 | 58.13 | + 12.96 |
| 6 | Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа | 54.93 | 53.61 | - 1.32 |
| 7 | Нийт | 51.94 | 53.22 | + 1.28 |

Монгол Улсын шүүхийн индекс 2021, 2023 онуудын харьцуулсан үнэлгээнд үндсэн хэмжигдэхүүнээс хамгийн өндөр өсөлттэй үнэлэгдсэн нь “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” +12.96 оноо, хамгийн өндөр бууралттай үнэлэгдсэн хэмжигдэхүүн нь “Шүүхэд итгэх олон нийтийн итгэл” -4.77 оноогоор үнэлэгдсэн байгааг хүснэгт 1-ээс харж болно.

- 1 Монгол улсын шүүхийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх заалтад шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн Тамгын газрын ажилтан нь шүүхийн захиргааны ажилтан байна гэж заасан байна.
- 2 Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан хуулийн нэр томъёог ашигласан болно.
- 3 Нээлттэй нийгэм форум. Шүүхийн индекс 2023. Хавсралт 1-ээс



Хүснэгт 2. Үндсэн хэмжигдэхүүн тус бүрд хамгийн багаар үнэлэгдсэн дэд хэмжигдэхүүнүүдийг харуулав.

| № | Үндсэн хэмжигдэхүүн | Дэд хэмжигдэхүүн | 2021 он | 2023 он | Өсөлт/бууралт |
|---|--|------------------------------------|---------|---------|---------------|
| 1 | Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал. | Шүүх, шүүгчийн аюулгүй байдал | 45.62 | 40.42 | - 5.2 |
| 2 | Шүүхийн нээлттэй, ил тод байдал | Хэвлэл мэдээллийн сурвалжилга | 44.30 | 44.01 | - 0.29 |
| 3 | Шүүхэд итгэх олон нийтийн итгэл | Шүүгчийн зан суртахуун | 43.83 | 41 | - 2.83 |
| 4 | Шүүхийн дэд бүтэц, нөөц | Эрсдэлийн удирдлагын тогтолцоо | 36.43 | 29.57 | - 6.86 |
| 5 | Шүүгчийн ёс зүй ба хариуцлага | Шүүгчийн сахилгын зөрчлийн процесс | 42.11 | 47.66 | + 5.55 |
| 6 | Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа | Шүүхийн захиргааны үйлчилгээ | 47.54 | 33.94 | - 13.6 |

Дэд хэмжигдэхүүнүүдийг 2021, 2023 онуудыг харьцуулсан үнэлгээгээр хамгийн их бууралттай дэд хэмжигдэхүүн нь **“Шүүхийн захиргааны үйлчилгээ”** нь **-13.6** оноогоор буурсан үзүүлэлт харагдаж байна.

Энэхүү өгүүллэгийг бичих үндэслэл нь: хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шүүхийн нэр хүндийг дээшлүүлж, олон нийт шударга ёсны үйлчилгээг тэгш хүртэж байгаадаа сэтгэл хангалуун үлдэхэд тулгамдаж буй асуудлуудыг судалж, улмаар шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх талаар санал бодлоо та бүхэнтэй хуваалцахыг зорилоо.

II. Шүүхийн үйлчилгээний чанар, шүүхийн захиргааны ажилтны харилцаа хандлага, ёс зүйн асуудал

Эхлээд бид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэд, хуулийн этгээд цаашлаад хэргийн оролцогчид шүүхийн үйлчилгээг хэрхэн үзүүлж байгаа, хаана ямар алдаа дутагдал гарч байгаагаа мэдэх нь чухал юм. Тэр утгаараа шүүх, шүүхийн захиргааны ажилтан нарт гаргасан өргөдөл, гомдолд анализ хийж, зөрчил дутагдлыг тодруулах зорилгоор “Шүүхийн захиргааны ажилтны харилцаа, ёс зүйн зөрчилтэй холбогдох өргөдөл, гомдолд агуулгын задлан шинжилгээ хийсэн нь”⁴ судалгааг дэлгэрэнгүй харвал:

Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, нийслэл дэх шүүхүүдийн шүүхийн захиргааны ажилтан нарт гаргасан 126 өргөдөл, гомдол, орон нутгийн шүүхүүдийн шүүхийн захиргааны ажилтанд гаргасан 30 өргөдөл, гомдол, нийт 156 баримтад агуулгын задлан шинжилгээ хийсэн

⁴ Шүүхийн ерөнхий зөвлөл, Сургалт судалгааны төв. “Шүүхийн захиргааны ажилтны харилцаа, ёс зүйн зөрчилтэй холбогдох өргөдөл, гомдолд агуулгын задлан шинжилгээ хийсэн нь”. 2024 он



болно. Үүнд:

А/ Шүүх, шүүхийн захиргааны ажилтан нарт өргөдөл гаргасан субъектүүдийн ангилал

Б/ Ирсэн өргөдөл, гомдлыг агуулгаар нь задлан шинжилсэн байдал

В/ Өргөдөл, гомдол ирж буй албан тушаалын ангилал зэргээр агуулгын задлан шинжилгээ хийсэн.

А/ Энэхүү судалгааны 156 өргөдөл, гомдлыг гаргасан субъектүүдийг нийслэл болон орон нутгаар ангилан харвал:

Хүснэгт 3. Өргөдөл, гомдол гаргасан субъект:

| Нийслэл дэх шүүхүүдийн хувьд: | | | | Орон нутаг дахь шүүхүүдийн хувьд: | | | |
|-------------------------------|------------------------|------------|------------|-----------------------------------|----------------|-----------|------------|
| № | Албан тушаал | Тоо | Хувь | № | Албан тушаал | Тоо | Хувь |
| 1 | Иргэн | 84 | 66.7 | 1 | Иргэн | 24 | 80.0 |
| 2 | Өмгөөлөгч | 10 | 7.9 | 2 | Өмгөөлөгч | 4 | 13.3 |
| 3 | Хуулийн этгээд | 8 | 6.3 | 3 | Хуулийн этгээд | 1 | 3.3 |
| 4 | Эвлэрүүлэн зуучлагч | 1 | 0.8 | 4 | Ерөнхий шүүгч | 1 | 3.3 |
| 5 | Хүний эрхийн комисс | 1 | 0.8 | | | | |
| 6 | Шүүхийн сахилгын хороо | 22 | 17.5 | | | | |
| Нийт | | 126 | 100 | Нийт | | 30 | 100 |

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн захиргааны ажилтан нарт гаргаж буй өргөдөл, гомдлыг шүүхээр үйлчлүүлж буй иргэд болон өмгөөлөгч нар өгч байгаа буюу 75-90 орчим хувь байна. Иргэн болон өмгөөлөгч нараас ирж буй өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийж, шүүхийн үйлчилгээний чанарыг сайжруулахад оновчтой алхам хийж, эргээд мониторингийн судалгаа хийх нь бидний өдөр тутмын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой болох нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Өмгөөлөгч нараас ирсэн шүүхийн үйлчилгээг сайжруулахад анхаарах шаардлагатай гомдлын агуулгыг энд эш татан оруулав.

Тохиолдол 1. Хэргийн оролцогчийн өмгөөлөгч /мөн прокурор/ хэргийн материалтай тухтай, нухацтай, бүрэн танилцах, хэргийн материалаас тэмдэглэл хийхэд шүүхийн байрны дотоод зохион байгуулалт зайлшгүй нөлөөлж байна. Бодит нөхцөл байдалтай дасан зохицож шүүгчийн туслахуудын өрөөнд, зарим тохиолдолд цонхны тавцанг ширээний зориулалтаар ашиглаж хэргийн материалтай танилцаж байгаа болно. Энэ нь а/шүүгчийн туслахууд чиг үүргээ гүйцэтгэхэд тодорхой хэмжээгээр саад учруулдаг, б/өмгөөлөгчид хэргийн материалтай тухтай, нухацтай танилцахад хүндрэл учирсаар байна. Зарим шүүхийн Тамгын газар 1 давхартаа шилэн хаалт хийж тусгай өрөө гарган өгсөн байна. Үүнийг бусад шүүхүүдэд хэрэгжүүлэхийг санал болгож байна.

Өмгөөлөгчийн гаргасан өргөдөл



Тохиолдол 2. Шүүгчийн туслахын ерөөнд өмгөөлөгч үйлчлүүлэгчийн хамт хэргийн материалтай танилцаж байтал шүүгчийн туслах зураг даруулахгүй гэж хавтаст хэргийг авч, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зохигчийн болон өмгөөлөгчийн эрхийг хязгаарласан. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1.2 дахь хэсэгт зааснаар хэргийн оролцогч нь хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шүүгчийн захирамж гарсны дараа хэргийн материалтай танилцах эрхтэй. Мөн Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10-д зааснаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу шаардлагатай баримт сэлтийг бэхжүүлэх, хуулбарлан авах зорилгоор зураг, дууны дүрсний, дуу-дүрсний бичлэгийн бусад техник хэрэгсэл ашиглах эрхтэй.

Өмгөөлөгчийн гаргасан гомдлоос

Тохиолдол 3. Хэргийн материалтай танилцахад шинжээч нарт хууль сануулсан баримтыг нөхөж Өдрийн байдлаар гарын үсэг зуруулж, нотлох баримтыг хуурамчаар үйлдэж хэрэгт хавсаргасны дараа хэргээс дур мэдэн авсан байна.

Өмгөөлөгчийн гаргасан гомдлоос

Б/ Ирсэн өргөдөл, гомдлыг нийслэл дэх болон орон нутгаар ангилан агуулгаар нь задлан авч үзвэл дараах зөрчлүүд илэрч байна. Үүнд:

Хүснэгт 4. Агуулгын хувьд:

| Нийслэл дэх шүүхүүдийн хувьд: | | | | Орон нутаг дахь шүүхүүдийн хувьд: | | | |
|-------------------------------|--|------------|------------|-----------------------------------|--------------------------------------|-----------|------------|
| № | Агуулга | Тоо | Хувь | № | Агуулга | Тоо | Хувь |
| 1 | Хариуцлагагүй байдал | 41 | 32.5 | 1 | Харилцааны зөрчил | 6 | 20 |
| 2 | Эрх зүйн актууд хугацаандаа гараагүй | 22 | 17.5 | 2 | Ёс зүйн зөрчил | 5 | 16.7 |
| 3 | Иргэдийг чирэгдүүлсэн | 16 | 12.7 | 3 | Эрх зүйн актууд хугацаандаа гараагүй | 5 | 16.7 |
| 4 | Хууль зөрчсөн | 16 | 12.7 | 4 | Хууль зөрчсөн | 4 | 13.3 |
| 5 | Харилцааны зөрчил | 15 | 11.9 | 5 | Санал хүсэлт | 4 | 13.3 |
| 6 | Ёс зүйн зөрчил | 6 | 4.8 | 6 | Хариуцлагагүй байдал | 3 | 10 |
| 7 | Шүүхийн үйл ажиллагаатай холбоотой | 5 | 4 | 7 | Хувь хүний мэдээлэл нууцлаагүй | 2 | 6.7 |
| 8 | Шүүгчийн өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлсэнтэй холбоотой | 2 | 1.6 | 8 | Албан тушаалаа урвуулан ашигласан | 1 | 3.3 |
| 9 | Санал хүсэлт | 2 | 1.6 | | | | |
| 10 | Нотлох баримт нууцлаагүй | 1 | 0.8 | | | | |
| | Нийт | 126 | 100 | | Нийт | 30 | 100 |



Эндээс харахад Нийслэл дэх шүүхүүдийн шүүхийн захиргааны ажилтнуудад ирсэн өргөдөл, гомдол орон нутаг дахь шүүхүүдтэй харьцуулбал 4 дахин их байгаа нь хүн амын нягтаршил, хэрэг, нэхэмжлэл хүлээн авсан тоо болон шийдвэрлэж буй хэргийн тоотой шууд хамааралтай. Нийслэл дэх шүүхүүдэд хариуцлагагүй байдал /32.5 хувь/, хугацаа хэтрүүлсэн /17.5 хувь/, иргэдийг чирэгдүүлсэн болон хууль зөрчсөн тус бүр /12.7 хувь/ байгаа нь өргөдөл, гомдлын 75 хувийг эзэлж байхад харилцаа хандлага, ёс зүйн зөрчил, шүүхийн үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт 25 хувь байна. Ирсэн өргөдөл, гомдлын агуулгыг эш татан оруулав.

Харин орон нутаг дахь шүүхүүдийн хувьд харилцааны зөрчил /20 хувь/, ёс зүйн зөрчил, хугацаа хэтрүүлсэн тус бүр /16,7 хувь/ байгаа нь орон нутгийн нийт өргөдөл, гомдлын 53.4 хувийг эзэлж байхад хууль зөрчсөн, хариуцлагагүй байдал зэрэг нь 46.6 хувийг эзэлж байна.

Тохиолдол 1. Давж заалдах шатад 2023.03.21-ны өдөр гомдол гаргасан боловч өнөөдрийг хүртэл явуулаагүй, сар бүр сануулж асуухад өнөөдөр, маргааш гэж хэлсээр байна.

Хугацаа хэтрүүлсэн гэсэн гомдлоос

Тохиолдол 2. Сүхбаатар дүүргийн хаягийг Сонгинохайрхан дүүргийн хаяг байна гэж андуурч, ажилдаа хайнга хандаж, онлайн системийг ашиглахыг мэдэхгүй, нэхэмжлэлийг чинь хүлээн авахаас татгалзсан захирамжаа ирж ав, хөдөө байсан ч ирж авах хуультай, Монгол шуудан алга болгочихвол яахын, би олон хүнтэй ажиллаж ажлаа дийлэхгүй байгаа гэх мэтээр ёс зүйгүй авирлаж байна.

Иргэний ирүүлсэн гомдлоос

Тохиолдол 3. Шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах гэтэл анхан шатны шүүгчийн туслах давахын шүүгчийн туслахаас асуу, давж заалдах шатны шүүгчийн туслах анхан шатны шүүгчийн туслахаас асуу гэж хэлсэн. Хэргийн материалтай танилцахад чирэгдэл учруулсан.

Иргэдийг чирэгдүүлсэн гэсэн гомдлоос

Тохиолдол 4. Монгол улсад байхгүй байгаа хүнийг шүүхийн шийтгэвэр гардан авсан хэмээн бичиж, гарын үсгийг нь зурсан байна. Энэ нь шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн дүрмийн 2.1-г зөрчсөн гэж үзэж байна.

Хууль зөрчсөн болон ёс зүйн зөрчил гаргасан гэсэн гомдлоос



Тохиолдол 1. Хол аймагт амьдардаг гэдгээ шүүх хуралдаанд шүүгчид хэлээд шүүхийн шийдвэрээ ирж гардан авах боломжгүй байхад заавал ирж ав, авахгүй бол арга хэмжээ авна гэж ёс зүйгүй харьцсан.

Иргэний ирүүлсэн гомдлоос

Тохиолдол 2. Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй утсаар ярихдаа «хөгшөөн хойшлогдчихлоо» гэж нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн дэргэд ярьсан.

Харилцааны зөрчил гаргасан гомдлоос

Тохиолдол 3. Гомдол гаргах хугацааг буруу тооцон, гомдол гаргах хугацаа дууссан тул гомдлыг хүлээн авахаас татгалзсан тухай захирамж гаргуулсанд гомдолтой байна.

Хариуцлагагүй хандсан гэсэн гомдлоос

Тохиолдол 4. Шүүхэд ажиллаж байсан ... нар албаны нэр барьж, албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглан шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн гадагш чиглэсэн үйлдэл гаргасан. Б.Б, Х.З нар нь албан утсаар иргэн Х.Ө рүү залгаж “шүүхэд нэхэмжлэл ирсэн байна. Шүүхэд ирнэ үү” гэж албаны нэр барьж худал хэлсэн.

Харилцааны болон ёс зүйн зөрчил гаргасан гэсэн гомдлоос

В/ Дээрх өргөдөл гомдлууд ямар албан тушаал дээр ирж байгааг ангилан авч үзвэл:

Хүснэгт 5. Өргөдөл гомдол ирсэн албан тушаалаар:

| Нийслэл дэх шүүхүүдийн хувьд: | | | | Орон нутаг дахь шүүхүүдийн хувьд: | | | |
|-------------------------------|--------------------------------------|------------|------------|-----------------------------------|------------------------------|-----------|------------|
| № | Албан тушаал | Тоо | Хувь | № | Албан тушаал | Тоо | Хувь |
| 1 | Шүүгчийн туслах | 91 | 72.2 | 1 | Шүүгчийн туслах | 22 | 73.3 |
| 2 | Удирдах албан тушаалтан | 11 | 8.7 | 2 | Тамгын газар | 4 | 13.3 |
| 3 | Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга | 9 | 7.1 | 3 | Архив, бичиг хэргийн эрхлэгч | 2 | 6.7 |
| 4 | Шүүхийн үйл ажиллагаатай холбоотой | 7 | 5.5 | 4 | Эвлэрүүлэн зуучлагч | 2 | 6.7 |
| 5 | Мэдээлэл технологийн мэргэжилтэн | 3 | 2.4 | | | | |
| 6 | Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн | 2 | 1.6 | | | | |
| 7 | Архив, бичиг хэргийн эрхлэгч | 1 | 0.8 | | | | |
| 8 | Эвлэрүүлэн зуучлагч | 1 | 0.8 | | | | |
| 9 | Шүүхийн ёс зүйн хороо | 1 | 0.8 | | | | |
| | Нийт | 126 | 100 | | Нийт | 30 | 100 |



Шүүгчийн туслахад гаргасан өргөдөл гомдлыг дотор нь агуулгаар нь задалж, дараах хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 6. Шүүгчийн туслахад гаргасан өргөдөл, гомдлыг агуулгаар нь:

| Нийслэл дэх шүүхүүдийн хувьд: | | | | Орон нутаг дахь шүүхүүдийн хувьд: | | | |
|-------------------------------|--------------------------------------|-----------|------------|-----------------------------------|--------------------------------------|-----------|------------|
| № | Шүүгчийн туслах | Тоо | Хувь | № | Шүүгчийн туслах | Тоо | Хувь |
| 1 | Хариуцлагагүй байдал | 29 | 31.8 | 1 | Харилцааны зөрчил | 6 | 27.3 |
| 2 | Эрх зүйн актууд хугацаандаа гараагүй | 19 | 20.9 | 2 | Эрх зүйн актууд хугацаандаа гараагүй | 4 | 18.2 |
| 3 | Хууль зөрчсөн | 18 | 19.8 | 3 | Хууль зөрчсөн | 3 | 13.6 |
| 4 | Харилцааны зөрчил | 13 | 14.3 | 4 | Ёс зүйн зөрчил | 3 | 13.6 |
| 5 | Иргэдийг чирэгдүүлсэн | 8 | 8.8 | 5 | Хариуцлагагүй байдал | 2 | 9.1 |
| 6 | Ёс зүйн зөрчил | 4 | 4.4 | 6 | Санал хүсэлт | 4 | 18.2 |
| Нийт | | 91 | 100 | Нийт | | 22 | 100 |

Нийслэл дэх шүүхүүдийн шүүгчийн туслахын хувьд ажлын хариуцлага алдах, шүүхийн эрх зүйн актууд хугацаандаа гараагүй, мөн хууль зөрчсөн үйлдэл гаргаж байна гэсэн гомдол 72.5 хувь бол орон нутаг дахь шүүхүүдийн шүүгчийн туслахын хувьд харилцааны зөрчил болон эрх зүйн актууд хугацаандаа гараагүй гэсэн өргөдөл, гомдол 45.5 хувь эзэлж байна. Эдгээрээс харахад шүүгчийн туслахад хандсан өргөдөл, гомдол 72-73 хувь /нийслэл болон орон нутаг/ байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчтой харилцаж байгаа гол субъект бол шүүгчийн туслах, түүний ажил, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, харилцаа хандлага, хувийн зохион байгуулалт нь шүүхийн үйлчилгээний чанарт шууд нөлөөлөхүйц гэж хэлж болохоор байна. Бид анхан болон давж заалдах шатны шүүхэд хэрэг, нэхэмжлэл, тайлбар, гомдол хүлээн авах, танилцуулах, хариу тайлбар авах, нотлох баримт цуглуулах, нэмж бүрдүүлэх, хасах, шүүх хуралдааныг товлох зэрэг шүүх хуралдааны бэлтгэл ажиллагаанаас шүүхийн шийдвэр гардуулах, хавтаст хэргийг архивд хүлээлгэн өгөх хүртэлх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үйл явцад оролцож байгаа байдлаар нь шүүхийн захиргааны ажилтны албан тушаалын чиг үүрэг⁵-ийг судалж үзсэнээ дараах хүснэгтээр харуулбал:

5 Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 237 дугаар тушаалаар анхан болон давж заалдах шатны 9 шүүхийн Тамгын газрын захиргааны ажилтны албан тушаалын чиг үүрэгт ажлын байрны зураг авалт хийсэн болно.

**Хүснэгт 7. Шүүхийн захиргааны ажилтны чиг үүрэг :**

| № | Албан тушаал | Анхан шат | Давж заалдах шат |
|---|--------------------------------------|-----------|------------------|
| 1 | Удирдах албан тушаалтан | | 35 |
| 2 | Шүүгчийн туслах | 30-35 | 30-32 |
| 3 | Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга | 25 | 19 |
| 4 | Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн | 26 | 22 |
| 5 | Мэдээлэл технологийн мэргэжилтэн | | 28 |
| 6 | Архив, бичиг хэргийн эрхлэгч | | 26 |
| 7 | Эвлэрүүлэн зуучлагч | | 17 |
| 8 | Эвлэрүүлэн зуучлагчийн туслах | | 19 |

Шүүгчийн туслахын чиг үүрэг нь шүүхийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.3-т заасан 10 чиг үүргийг шүүгчийн удирдлага дор хэрэгжүүлнэ гэсэн боловч нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад буюу бодит байдалд эрүүгийн шүүгчийн туслах 34 чиг үүрэг, иргэний шүүгчийн туслах болон захиргааны шүүгчийн туслах тус тус 30 чиг үүрэг хэрэгжүүлж байна⁶. Шүүгчийн туслах бусад шүүхийн захиргааны ажилтан нараас илүү их чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна. Мөн 2025 оны 1 сарын байдлаар анхан шатны шүүхийн шүүгчийн туслахын ажиллагаанд байгаа хэргийн тоо⁷-г харахад:

Хүснэгт 8. Анхан шатны шүүхийн шүүгчийн туслахын ажиллагаанд байгаа хэргийн тоо:

| № | Хэргийн төрөл | Нийслэл | Орон нутаг |
|---|------------------|---------|------------|
| 1 | Эрүүгийн хэрэг | 21 | 22-39 |
| 2 | Иргэний хэрэг | 214-284 | 40 |
| 3 | Захиргааны хэрэг | 26 | 6 |

Ажиллагаанд байгаа хэргийн тооноос хамаарч хэргийн оролцогчтой утсаар ярих болон биечлэн уулзах, шүүгчийн гаргасан эрх зүйн актуудыг танилцуулах, талуудын гаргасан хүсэлт, нотлох баримтыг хэргийн материалд


⁶ Шүүхийн ерөнхий зөвлөл. Шүүхийн захиргааны ажилтны чиг үүргийн судалгаа. 2023 он 2-р бүлгээс

⁷ Тус тоог нийслэл дэх Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Дархан-Уул аймаг дахь сум дундын анхан шатны шүүх, Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах нараас мэдээлэл авав.

хавсаргах зэрэг үйлдлүүд нь хэд дахин давтагдан хийгддэг гэдгийг анхаарах нь зүйтэй.

Дээрх судалгааны үр дүнг ерөнхийд нь дараах схемээр харууллаа.

Схем 1. Шүүхийн үйлчилгээний ерөнхий бүтэц, тулгамдаж буй асуудал:



III. Шүүхийн захиргааны хүний нөөц, ажилтны сэтгэл зүйн асуудал

Шүүхийн захиргааны хүний нөөцийн бүтцийг харахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа шүүхийн захиргааны ажилтан Монгол улсын анхан болон давж заалдах шатны шүүхэд 2022 онд 1352 ажилтан, 2023 онд 1374 ажилтан, 2024 онд 1479 захиргааны ажилтан ажилласан байна⁸. 2023 оны байдлаар⁹ шүүхийн захиргааны ажилтны 37.3 хувь нь 20-29 насны, 33 хувь нь тухайн албан тушаалд 1 хүртэлх жил ажилласан ажилтан байна. Үүнийг график 1, 2-оос дэлгэрэнгүй харж болно.

8 Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол улсын шүүхийн тайлан., 2023, 2024, 2025 он

9 ШЕЗ-ийн Шүүхийн захиргааны хүний нөөцийн газрын тоо мэдээнээс иш татав.



График 1.





График 2.



Эндээс харахад мэдлэг, ур чадвар, туршлага хуримтлуулан тогтвор суурьшилтай ажилласан, мөн тухайн ажилдаа мэргэшсэн боловсон хүчин дутмаг байгааг илэрхийлж байна. Энэ нь шүүхийн нэр хүнд, үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдийн итгэл үнэмшил, сэтгэл ханамжид нөлөөлж байна юм.

Дараагийн нэг судалгаа¹⁰ нь шүүхийн захиргааны ажилтны хувь хүний сэтгэл ханамж, ажилдаа хандах хандлага зэргийг судалж үзэхэд:


- а/ Ажлаа сэтгэлээсээ мэдрэх чадвар буурах үзүүлэлт судалгаанд оролцогчдын 88 хувьд өндөр гарч байгаа нь ажилдаа сэтгэл ханамжгүй, харин 12 хувь нь хийж буй ажилдаа чин сэтгэлээсээ хандаж ажилладаг гэсэн үзүүлэлттэй байна. Энэ нь тухайн хүний зорилгоо ухамсарласан байдал, өөрийгөө сэдэлжүүлэх чадвар, хамт олонтойгоо харилцах харилцаа, ажилдаа хандах хандлагатай холбоотой юм.
- б/ Хувь хүний бүтээмжийн хувьд шүүхийн захиргааны ажилтны 84.4 хувьд нь бага, 15.6 хувь нь хөдөлмөрийн бүтээмж өндөр байна. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хувь хүний хувийн зохион байгуулалт, багаар ажиллах ур чадвар, цагийн менежмент, тухайн ажил үүргийг гүйцэтгэх туршлага зэргээс хамаарч байна.
- в/ Судалгаанд оролцогчдын 33.8 хувь нь сэтгэл хөдлөлийн өөрчлөлт бага, 56.6 хувь нь сэтгэл хөдлөлийн өөрчлөлт дунд, харин 9.6 хувь нь сэтгэл хөдлөлийн өөрчлөлт өндөр байна. Сэтгэл хөдлөлийн өөрчлөлт өндөр гэсэн үзүүлэлт нь тухайн захиргааны ажилтны харилцааны илэрхийлэл болох дуу хоолойны өнгө, нүүрний хувирал, үйлдэл төрх, биеийн хэлэмж зэргээр илэрч байдаг.

10 ШЕЗ. Шүүхийн сургалт судалгааны төв. Шүүхийн захиргааны ажилтны сэтгэл зүйн байдлыг тодорхойлсон судалгааны тайлан, 2024 он. Тус судалгаанд МУ-ын анхан болон давж заалдах шатны шүүхийн 449 захиргааны ажилтан санамсаргүй түүврийн аргаар оролцсон.



Дээрх үзүүлэлтүүд дээр үндэслэн ажлаас халшрах хам шинжийг тодорхойлсон бөгөөд судалгаанд оролцогчдын 6 хувь нь ажлаас халшрах хам шинж өндөр, 13 хувь нь дунд зэрэг, 81 хувь нь ажлаас халшрах хам шинж бага илэрч байна. Иймд шүүхийн захиргааны ажилтны 19 хувьд нь ажлаас халшрах хам шинж илэрч байгаа нь 5 ажилтны 1 нь ажлаас халширсан сэтгэл зүйтэй байна гэсэн үг.

График 3. Шүүхийн захиргааны ажилтны сэтгэл ханамж болон хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлж буй хүчин зүйлс:



Судалгааны хоёр дахь бүлэг асуудал нь шүүхийн захиргааны ажилтны сэтгэл ханамж болон хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлж буй хүчин зүйлсийг судалсан тус судалгаанд оролцогчдын 66 хувь нь сүүлийн 6 сарын байдлаар эрүүл мэндийн асуудал үүссэн, цалин урамшуулалдаа 71 хувь нь сэтгэл ханамжгүй /өөр ажлын санал ирвэл цалинг чухалчилна/ гэсэн ба чөлөөт цаг гардаггүй гэж 35 хувь нь хариулсан байна. Энэ нь шүүхийн захиргааны ажилтанд чөлөөт цаг бага, цалин урамшуулалдаа сэтгэл ханамжгүй, эрүүл мэндийн зовуурь их бага хэмжээгээр үүсдэг гэсэн дүр зураг харагдаж байна.

Дээрх судалгааны үр дүнг баталгаажуулах зорилгоор Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн захиргааны ажилтан нарт ажиглалт болон ганцаарчилсан ярилцлагын аргаар чанарын судалгаа¹¹ хийсэн болно. Тус судалгаанд 53 шүүхийн захиргааны ажилтан оролцсон ба оролцогчдын 47,2 хувьд стресс “хэвийн” түвшинд илэрч байгаа бол 52.8 хувьд нь стрессийн шинж тэмдэг үүссэн буюу анхаарал хандуулах, зайлшгүй арга хэмжээ авах шаардлагатай нөхцөл байдалд байна. Стрессгүй болон туйлдсан оролцогчдын 20 хувь нь шүүгчийн харилцаа хандлагаас үүдэн сэтгэл зүйн хямралд орсон байгаа нь ярилцлагын явцад ажиглагдаж байна. Стресс үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлд “ажиллах орчин, нөхцөл муу” гэж хамгийн бага /1.5 оноо/-аар, “ажлын ачаалал их” гэж /1.6 оноо/ үнэлсэн байна. Ажиглалтын явцад нэг зааланд олноороо суух нь нэг шүүгчийн туслахын ажиллагаанд байгаа 24-280 хэргийн хувьд хамгийн багадаа өдөрт 50-100 хэргийн оролцогчидтой

11 Мөн тэнд, 2-р бүлгээс



гар утсаар ярих, хэргийн материал танилцуулж, нэхэмжлэл, тайлбар хүлээн авах зэрэг харилцаа, холбоо үүсгэж байна. Энэ нь бусад шүүгчийн туслахын анхаарал төвлөрөл, ажлын бүтээмж, хүний хувийн мэдээллийн нууцлал зэрэгт сөргөөр нөлөөлж байна. Мөн ажлын ачаалал их байгаа нь сэтгэл зүйн болон бие махбодын туйлдсан байдалд оруулах, гэр бүлдээ цаг гаргаж чадахгүй байх зэрэг асуудал нь тухайн ажилтан нар ажлаа солих нөхцөл болж байна. Эсрэгээрээ ижил түвшний ачаалалтай хэдий ч стрессийн түвшин бага албан хаагчдын хувьд ажилдаа дур сонирхолтой, хийж буй ажлаа өөрийн мэдлэг, туршлага хуримтлуулах, өөрийгөө хөгжүүлэх боломж гэж харж, ирээдүйд шүүх эрх мэдлийн салбарт ажиллах, шүүгч болох зорилготой гэж ярьж байгаа туршлагатай шүүгчийн туслахаас суралцах, туршлага хуваалцах боломжтой байна.

Энд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд монгол хүний эрх зүйн боловсрол, ухамсар, менталитет /монгол хүний онцлог/, газар зүйн байршил, тогтсон хандлага, үзэл суртал, цахим орчны мэдээлэл хэрхэн нөлөөлж байгаа¹²-г (LLD)Н.Баярмаа докторын судалснаар оруулж байна. Үүнд:

- Хараат бус шүүх эрх мэдлийн талаарх олон нийтийн ойлголт сул, хэт туйлширсан, цахим орны мэдээлэлд автдаг,
- Хууль, дүрэм, журамд заасан эрх, үүргийг цаг тухайд нь биелүүлдэггүй, хариуцлагагүй,
- Ажлыг тааваараа хийх, цаг хугацааны сахилга бат, хувийн зохион байгуулалт сул,
- Нүүдэллэн амьдрах, хаяг байршил тодорхойгүй байх,
- Аливаа асуудал үүсэхэд найз нөхөд, танил талаараа аргалуулах гэж оролдох,
- Өөрийн буруутай үйлдлийг хүлээн зөвшөөрдөггүй, бусдаас өө хайх, шүүмжлэлт сэтгэлгээгээр хандах, бусдыг үл сонсох, дураараа байх, хардах
- Арга заль, уур омог, заргач зан аашийг гаргавал асуудал өөрийн талд шийдэгдэнэ гэсэн байр сууринаас харилцаа хандлага гаргах,
- Өмгөөлөгч бус энгийн иргэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бусдыг төлөөлөн оролцох нь түгээмэл,
- Албан бус эх сурвалж, цахим мэдээлэл, дам яриагаар нөхцөл байдалд хандах, урьдчилан таамаглах гэх мэт

IV. Дүгнэлт

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцөл, харилцаа хандлагад тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийжээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн захиргааны ажилтан нарын гаргаж буй зөрчил дутагдлыг судалж үзэхэд хариуцлагагүй

12 Н.Баярмаа /LL.D./ "Цахимжилт: Монгол улсын шүүхийн онцлог, сорилт" итгэл, 2024 он



байдал 32.5 хувь, эрх зүйн актууд хуулийн хугацаандаа гараагүй 17.5 хувь, харилцааны болон ёс зүйн зөрчил 16.7 хувь, хууль зөрчсөн болон иргэдийг чирэгдүүлсэн асуудал тус тус 12.7 хувь байна. Эдгээр асуудлын 72.5 хувь нь шүүгчийн туслахад хандсан өргөдөл, гомдол эзэлж байна. Үүний шалтгаан шүүгчийн туслахын чиг үүрэг бусад шүүхийн захиргааны ажилтан нараас 10-15 чиг үүргээр илүү байна. Нийслэлд шүүхийн захиргааны ажилтны ажлын ачаалал, орчны стрессээс үүдэн харилцааны болон ёс зүйн алдаа гаргаж байгааг дээрх судалгааны үр дүнгүүд харуулж байна. Тухайлбал: Нэг зааланд олноороо суух нь нэг шүүгчийн туслахын ажиллагаанд байгаа 24-280 /эрүү, иргэн, захиргааны анхан шат шүүхийн дундаж/ хэргийн хувьд хамгийн багадаа өдөрт 40-100 хэргийн оролцогчид хэргийн материал танилцуулж, нэхэмжлэл, тайлбар хүлээн авах, нотлох баримт цуглуулах, шүүх хуралдааны тов мэдэгдэх, хуралдааны бэлтгэл ажлыг хангах, шүүхийн шийдвэрийг албажуулан, хэргийн оролцогч нарт гардуулах зэрэг байнгын харилцаа, холбоо /биечлэн, утсаар, цахим/ үүсгэж байна. Энэ нь бусад шүүгчийн туслах нарын анхаарал төвлөрөл, ажлын бүтээмж, хүний хувийн мэдээллийн нууцлал зэрэгт сөргөөр нөлөөлж байна.

Шүүхийн захиргааны ажилтны 33 хувь нь тухайн албан тушаалд 1 хүртэлх жил ажилласан, 37.3 хувь нь 20-29 насныхан эзэлж байна. Энэ нь мэргэшсэн, дадлага туршлагатай захиргааны ажилтан хомс, хүний нөөц тогтворгүй байгаа нь шүүхийн үйлчилгээний чанарт шууд нөлөөлж байна. Иймээс шүүхийн хүний нөөцийн бодлого, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бодлогын түвшинд анхаарах шаардлагатай.

Судалгаа¹³-нд оролцогчдын 84 хувь нь ажлын бүтээмж бага, 71 хувь нь цалин урамшуулалдаа сэтгэл ханамжгүй, 35 хувь нь чөлөөт цаг гардаггүй, 52.8 хувь нь стрессийн шинж тэмдэг үүссэн буюу анхаарал хандуулах, зайлшгүй арга хэмжээ авах шаардлагатай гэсэн үр дүнгүүд байна. Мөн шүүхийн захиргааны ажилтны 19 хувьд нь ажлаас халшрах хам шинж илэрч байгаа нь 5 ажилтны 1 нь ажлаас халширсан сэтгэл зүйтэй байна. Стресстэй болон сэтгэл зүйн хямралд орсон шүүгчийн туслахуудын 20 хувь нь шүүгчийн харилцаа хандлага, хэргийн оролцогчийн харилцаа, сэтгэл хөдлөл зэргээс хамаардаг болох нь ярилцлагын явцад ажиглагдаж байсан.

Шүүхийн үйлчилгээг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй болгоход хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үйл явцад шүүгч, шүүхийн захиргааны ажилтан, хэргийн оролцогчийн эрх үүрэг, хууль, эрх зүйн үүднээс хэрхэн шүүхийн шийдвэр гарч байгааг тодорхой мэдээлэх, олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн ажлуудыг нийслэл, орон нутагт зохион байгуулах шаардлагатай байна.

13 ШЕЗ. Шүүхийн сургалт судалгааны төв. Шүүхийн захиргааны ажилтны сэтгэл зүйн байдлыг тодорхойлсон судалгааны тайлан, 2024 он.



Ү. Санал зөвлөмж

Шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд дараах зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой үүсэж байгаа асуудал, бэрхшээлийг цаг алдалгүй шийдвэрлэхэд анхааран, асуудлын учир шалтгааныг судалж, хэргийн оролцогч нарт үнэн зөв ойлголт, мэдээлэл өгөх захиргааны ажилтан нарыг бэлтгэх,
- 3 хүртэлх сар дотор ажиллаж буй шүүхийн захиргааны ажилтан нарт өөрийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, ажилдаа дасан зохицох, хувийн зохион байгуулалтаа зөв төлөвлөхөд зөвлөн туслах,
- Шүүхийн захиргааны хүний нөөцийг тогтвортой байдлыг хангах бодлого хэрэгжүүлэх /зэрэг дэв ахих, мэргэшсэн ажилтныг урамшуулах, нийгмийн баталгааг дээшлүүлэх/
- Шүүгчийн туслахын ажлын онцлогийг харгалзан хөдөлмөр зохион байгуулалтын оновчтой шийдлийг нэвтрүүлэх
- Шүүхийн захиргааны ажилтны харилцаа хандлага, ёс зүй, мэргэжлийн үйл ажиллагааны алдаа дутагдлаас урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулах
- Олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилтод хөтөлбөр боловсруулан, жил бүр уламжлал болгон зохион байгуулах. Тухайлбал: сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад танилцах өдөрлөг, эрх зүйн суурь мэдлэг олгох сургалт, шүүхийн нээлттэй хаалганы өдөр, оюутан залуучуудын дунд мэтгэлцээн, хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний илтгэлийг Монгол улсын хэмжээнд
- Шүүхийн захиргааны ажилтны ажлын зохион байгуулалт, орчин нөхцөл, цахимжилтийг нэвтрүүлэхэд монгол хүний сэтгэлгээ, газар зүй, хүн амын нягтаршил, цахим хэрэглээний мэдлэг ур чадварыг харгалзан үзэх зэрэг саналуудыг энэхүү өгүүллээр хүргэж байна.

Уншигч та бүхэн шударга ёсны илэрхийлэл болсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж, шүүхийн нэр хүндийг сайжруулах талаарх санал бодлоо nyamaa@judcouncil.mn цахим хаягаар ирүүлэхийг хүсэж байна.



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД СЭТГЭЛ ЗҮЙЧИЙН ОРОЛЦОО БА ТУХАЙН ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ТООГ БУУРУУЛАХ НЬ

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Сэтгэл зүйч, ахлах дэслэгч Б.Бямбажаргал*

ХУРААНГУЙ

Энэхүү өгүүлэлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэрэг, зөрчлийн тулгамдсан асуудлын талаар авч үзлээ. Уг асуудлын хүрээнд гэр бүл тухайн ойлголт болон гэр бүлийн хүчирхийллийн талаар судалсан болно. Баривчлах байр нь Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 10 төрлийн зөрчил дээр баривчлагдсан этгээдийг хүлээн авдаг. Үүнээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн зөрчил 80%-ийг эзэлж байна. Иймд “Гэр бүлийн гишүүд, хосын харилцааг сайжруулах, дэмжлэг үзүүлэх ажиллагаа”, түүний дотор сэтгэл зүйчийн үүрэг оролцоог энэхүү илтгэлээр хөндөв.

Сэтгэл зүйч, судлаачийн хувьд үйл ажиллагааны хүрээнд хийсэн судалгаа, туршлага, салбарын тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх тодорхой шийдлүүдийг дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үг: Гэр бүлийн хүчирхийлэл, зөрчлийн тухай хууль, сэтгэл зүй, зөвлөгөө.

НЭГ. УДИРТГАЛ

Тухайн улс үндэстний оршин тогтнол, язгуур эрх ашиг, хөгжил цэцэглэлтэд гэр бүл түүний үүсэл хөгжлийн гүйцэтгэх үүрэг онцгой байр суурийг эзэлдэг.

Гэр бүлийн тухай хуулийн 3.1.2.“гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд бий болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг; гэж заасан. Гэрлэлт, гэр бүлийн зохион байгуулалтын хэлбэртэй холбоотой ёс, зан заншил улс орон бүрд өөр өөрийн онцлогтой байдаг. Монголчууд гэр бүлсэг ард түмэн. Тэд эцэг эхтэйгээ, эмээ өвөөтэйгөө урт удаан хамт амьдран үргэлж харилцаа холбоотой байж эцэг эхийн үг сургамжийг голчлон дагадаг.

Хүний амьдрал, гэр бүл, хувь хүний дотоод сэтгэл зүйн дүр төрхийг нарийн мэдрэх, хүний зан үйлд нөлөөлөл үзүүлэх улмаар зохих өөрчлөлтийг бий болгоход сэтгэл зүйн шинжлэх ухаан чухал үүрэг гүйцэтгэдэг. Манай улсын хувьд сэтгэл зүйн шинжлэх ухаан харьцангуй залуу салбар юм. Анх Монгол Улсын Их Сургуульд 1998 онд “Нийгмийн сэтгэл судлал”- ийн анги нээгдсэн. Улмаар 2016 оны сүүлийн хагасаас гэр бүлийн холбогдолтой маргаанд сэтгэл зүйчдийг оролцуулж эхэлсэн. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд нийгмийн




шалтгаанаас гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл ч нэмэгдсээр байна.

ХОЁР.ҮНДСЭН ХЭСЭГ

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэрэг нь 2023 оны байдлаар өмнөх оноос 22.1%-иар өссөн ба 55.1% нь нийслэлд, 44.9% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 773 хэрэгт Прокурорын байгууллага хяналт тавьж, 501 хэргийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн байна. 2023 онд энэ төрлийн хэрэгт шалгагдсан 533 хүнийг насны ангиллаар авч үзвэл 19.6% нь 45-ас дээш, 20.9% нь 18-30 насныхан байсан бол хамгийн өндөр буюу 58.8% нь 31-44 насныхан эзэлж байна. Хүйсийн хувьд 94.6 хувь нь эрэгтэй бол үлдэх хувь буюу 5.4% нь эмэгтэй байна. Мөн нийт хэрэг зөрчлийн 43.2% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил гаргасан байсан ба 63.2% нь эрхэлсэн тодорхой ажилгүй этгээдүүд байна. Эдгээр тоо баримт нь салбарын сэтгэл зүйч мэргэжилтнүүдийн ажиллах талбар болон сэтгэл зүйн үйл ажиллагааны хэрэгцээг тодорхой харуулж байна.

Мөн баривчлах байранд 2022-2023 онуудад гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн зөрчилтэй нийт 4879 этгээд баривчлах шийтгэл эдэлсэн ба зөрчил гаргах нийтлэг шалтгаанаас дурдвал 90 орчим хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил гаргадаг болох нь харагдана. Мөн эхнэр нөхрийн таарамжгүй харилцаа, гэр бүлийн гишүүдэд хүчирхийлэл үйлдэх, ёс бус үг хэллэгээр доромжлох зэрэг дээрх дурдсан нийтлэг шалтгаанаар зөрчил үйлдэгдэж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн зөрчилтэй этгээдийн судалгаа 2022-2023 он.





Зөрчлийн тухай хуулийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр баталж 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлжээ. Тус хуулиар гэр бүл бүлийн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэг, зөрчил хэмээн тодорхойлсон байдаг. Монгол Улс 2017 онд Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, “Зөрчил” гэх ойлголтыг хуульчилж өгсөн. Ингэснээр гэмт хэрэг, зөрчлийг ялган заагласан үйлдэлд шийтгэл хүлээлгэх хариуцлага хэмээн үзэж хууль болгонд торгох шийтгэл тусгаж ирснийг цэгцэлж хууль зүйн нэгдсэн бодлоготой болгосон юм.¹

2.1 Сэтгэл зүйн салбарын тухай:

Сэтгэл зүйн салбар шинжлэх ухааны дотор сэтгэл зүйн зөвлөгөө чухал байр суурийг эзэлдэг. Нийгмийн эрэлт хэрэгцээ амьдралын шаардлагаас хамааран “Сэтгэл зүйн зөвлөгөө” гэсэн биеэ даасан салбар шинжлэх ухаан нэлээд олон чиглэлээр гүнзгийрэн хөгжих хандлага сүүлийн жилүүдэд эрчимтэй явагдаж байна.

Сэтгэл зүйн зөвлөгөөг салбарын судлаач, эрдэмтэд олон талаас нь тайлбарласан байдаг боловч ерөнхий утгаар нь авч үзвэл үйлчлүүлэгч өөрт нь учраад байгаа бэрхшээлээ олж харах, бодитойгоор ойлгох, өөрийгөө дайчлах, даван туулахад чиглэсэн үйлчлүүлэгч болон сэтгэл зүйч хоорондын хамтын идэвхтэй үйл ажиллагаа гэж ойлгож болно. Хүмүүс хоорондын харилцаа болон зан үйлийн зөрчил, доголдолтой холбоотой олон янзын бэрхшээл саадыг даван туулахад сэтгэл зүйн зөвлөгөөг голчлон ашигладаг.

Сэтгэл зүйн зөвлөгөөний үндсэн зорилго бол өөрсдийн дотоод нөөц боломжоо нээж ашиглах, сайн сайхан гэрэлт амьдралын төлөө тэмүүлэх, тэмцэх, хүсэл эрмэлзэл, итгэл найдварыг төрүүлэх, бэрхшээлийг даван туулах арга замаа олж харах, зөв шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байдаг.²

Дээрх ойлголтуудыг нэгтгээд үзвэл “сэтгэл зүйч” нь үйлчлүүлэгчийн шийдвэрийг өөрчлөх, ятгах, сэнхрүүлэхтэй холбоотой агуулга энэ салбарын эрдэмтэн судлаачдын тодорхойлолтод тусгагдаагүй байдаг. Харин бэлтгэгдсэн мэргэжилтэн нь сэтгэл зүйн зөвлөгөөний онол арга зүй, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон шинжлэх ухааны үндэслэлтэйгээр явуулдаг нь найз нөхөд дотнын хүмүүсийн бие биедээ өгөх зөвлөгөө сургамжаас ялгагдаж байдаг³.

1 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйл. <https://legalinfo.mn/>

2 Д.Эрдэнэчулуун “Сэтгэл зүйн зөвлөгөөний онол-арга зүйн үндэс” УБ, 2008 он, 8 дах тал

3 Д.Эрдэнэчулуун “Сэтгэл зүйн зөвлөгөөний онол-арга зүйн үндэс” УБ, 2008 он, 11 дэх тал



2.2 Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт

Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар зохицуулсан байдаг. Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан этгээд нь Хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг, гэр бүлийн хүчирхийлэл гэнэ” хэмээн тодорхойлсон. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбодын, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг хэлнэ гэжээ.

Өнөөгийн нийгэмд зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд дан ганц шийтгэл оногдуулах нь эцсийн шийдэл биш гэдгийг эрх зүйн салбар хүлээн зөвшөөрч, тухайн хууль зөрчсөн үйлдлийн учир шалтгаанд дүн шинжилгээ хийх, улмаар урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага бий болсоор байгааг олж харсны нэг нь сэтгэл зүйч, сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх нэн шаардлагатай гэж үзэж байна. Баривчлах шийтгэл оногдуулсан Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэж баривчлагдсан этгээдийн Зан үйлд нөлөөлөх, дахин давтан зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт үйл ажиллагааг сэтгэл зүйчид хийж байна.

Сэтгэл зүйчийн хувьд хүчирхийлэл үйлдсэн болон архины шалтгаант зан үйлд нөлөөлөх гэр бүлийн сэтгэл зүйн боловсрол олгох, сэтгэл хөдлөл, уур бухимдал, стрессээ хянан зохицуулах, харилцаа, хандлагыг нь өөрчлөх зэрэг агуулгын хүрээнд сургалт, зөвлөгөө боловсруулан баривчлах шийтгэлтэй зөрчил гаргасан этгээдэд хувь хүний хөгжлийн сургалтыг зохион байгуулдаг болно.

Баривчлах шийтгэл эдлүүлэх явц дахь сургалт нөлөөлөл нь зөвхөн нэг талд буюу хүчирхийлэл үйлдэгчид чиглэдэг ба хүчирхийллийн хохирогч түүний ойр тойрныхон, ар гэрт нь нөлөөлөх, хүрэлцээ бага байна. Ингэснээр хүчирхийллийн хохирогч сэтгэл зүйн гэмтэлтэйгээ үлдсээр байдаг. Үүнтэй холбогдуулж хүчирхийлэл үйлдсэн этгээдийн ар гэртэй хороо, дүүргийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид эргэх холбоотой ажиллах нэн шаардлагатай асуудлын нэг билээ.

Сэтгэл судлал нь хүний тархи, дотоод ертөнц, танин мэдэхүйн хөгжил, тогтолцоог судалдаг шинжлэх ухаан болохоор зөрчил гаргасан этгээдтэй ажиллах түлхүүр болдог. Тэртүлхүүрийг хэрхэн тохируулж тааруулах нь сэтгэл зүйчээс шалтгаална. Тиймээс ч сэтгэл зүйчид бид мэргэжлийн үйлчилгээг хүндээ хүрч ажиллахад ихээхэн ур чадвар хэрэгтэй. Нөгөөтээгүүр сэтгэл зүйч хэчнээн мэдлэг чадвартай, хичээл зүтгэлтэй байлаа ч давтагдашгүй хүчин зүйлүүд олон бий. Хүчирхийлэлд өртсөн болон хүчирхийлэл үйлдэгч нь баривчлах шийтгэлийн хугацаа дууссанаар цааш сэтгэл зүйн зөвлөгөө,



үйлчилгээ үргэлжлэхгүй зогсдог. Зөвлөгөө, үйлчилгээний гол зорилго нь үйлчлүүлэгчийн дотоод нөөц боломжийг нээх, гэрэлт ирээдүйн төлөө тэмүүлэхэд сэдэл өгөх, бэрхшээлийг даван туулах арга замд суралцуулах, зөв шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны нэгээхэн хэсэг нь Баривчлах байранд явагддаг. Үүнд засал хүмүүжил олох санаа сэдэл, ухаарал, итгэл найдварыг төрүүлж анхан шатны сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл үйлчилгээг тухайн баривчлагдсан этгээдийн шийтгэврийн хоногтой нийцүүлэн олгодог. Иймд дээр дурдсан асуудлыг тодорхой төвшинд шийдэж эхэлбэл сэтгэл зүйч нь сэтгэл зүйн зөвлөгөөний онол арга зүй, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажилласнаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, зөрчил гаргасан этгээдийн тоог бууруулахад бодитой хувь нэмэр оруулж болохоор байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Тухайн орон нутгийн гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, дүүрэг болон хорооны нийгмийн ажилтнууд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сэтгэл зүйчид хамтын ажиллагааг өргөжүүлэн ажилласнаар шүүхийн шийдвэрийн хугацаа дуусаж суллагдсан этгээдүүдэд үргэлжлүүлэн сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх боломж бүрдэх боломжтой. Ингэснээр дахин давтан зөрчил, гэмт хэрэг үйлдэх болон холбогдох асуудлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлэхэд дэмжлэг болно гэж үзэж байна.

Цаашид сэтгэл зүйч мэргэжлийн боловсролын чадамжийг нэмэгдүүлэх, лиценз олгох, үйл ажиллагааны үндсэн чиглэл нь илүү мэргэжлийн үйл ажиллагаанд зориулагдах нөхцөл боломжоор хангах, сэтгэл зүйчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлага салбарын хэмжээнд үүсэж байсан.

Ашигласан материал

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйл, <https://legalinfo.mn/>
2. Д.Эрдэнэчулуун “Сэтгэл зүйн зөвлөгөөний онол-арга зүйн үндэс” УБ, 2008 он,
3. О.Мягмар “Сэтгэц заслын зөвлөгөөний онол арга зүй” УБ, 2019 он,
4. Ч.Байгалмаа, Ш.Батболд, Г.Галсанжамц нарын хамтарсан “Гэр бүл сэтгэл зүйн боловсрол” УБ, 2021 он,
5. “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн тулгамдсан асуудлууд” УБ, 2012 он.



КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЦАХИМ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Б.Сайжидмаа

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах байр
Архив, бичиг хэргийн ажилтны албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.*

УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл:

Орчин үеийн техник, технологийн дэвшил хөгжлийн шинэ боломж олгохын зэрэгцээ нийгмийн бусад саар үзэгдлүүд ч бий болсоор байна. Тэдгээрийн нэг нь “цахим” гэмт хэрэг юм. Сүүлийн жилүүдэд манай улсад санаатай болон болгоомжгүй байдлаас энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх, золиос болох, хохирох асуудал гарч байна.

Цахим орчин нь энэ цаг үеийн олон нийтийн харилцааны гол хэрэгслийн нэг төдийгүй, нийгмийн хөгжлийг тодорхойлогч болсон компьютер, смарт буюу ухаалаг технологи салшгүй холбоотой.

Иймд байгууллага, хамт олон, хувь хүний мэдээлэл, түүний аюулгүй байдлыг баталгаатай хангах, хамгаалах явдал чухал ач холбогдолтой бөгөөд тулгамдсан бодит а суудал нь мэдээллийн аюулгүй байдал ба кибер орчны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар энэхүү судалгааны ажил оршино.

Судалгааны арга:

- Бичиг баримтад судалгаа хийх
- Асуулгын арга
- Математик боловсруулалтын арга

Судалгааны зорилго, зорилт:

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол Улс дахь цахим гэмт хэргийн түвшинг тодорхойлж, түүний шалтгаан нөхцөл, цаашдын чиг хандлага, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, санал зөвлөмж боловсруулахад оршино.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЦАХИМ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ОНОЛ АРГА ЗҮЙН СУДАЛГАА

Кибер аюулгүй байдал, цахим гэмт хэргийн нөхцөл байдал:

Кибер гэдэг үг нь кибернетикийн шинжлэх ухаантай холбоотой бөгөөд анх энэ үгийг 1948 онд Америкийн математикч Норберт Винер¹ (1894-1964) болон түүний хамтран зүтгэгчид математикийн шинжлэх ухаантай холбож хэрэглэсэн. Кибернетик гэсэн нэршлийг тэд амьтан болон машин дахь харилцаа холбооны онол болон удирдлагыг бүхэл нь хамарсан талбар гэдгийг томъёолсон. Винер грекийн “kubernetes” буюу удирдагч гэх үгийн үндэс залуурч гэх утгатай үгийг хэрэглэсэн байдаг. Норберт Винерийн энэхүү онол нь инженерчлэл, системийн удирдлага, компьютер, биологи, философийн шинжлэх ухаануудтай холбоотой.² Кибернетикийн ухаан нь бүх өөрөө удирдах цогц системүүдийн дотоод харилцаа холбоо болон удирдлага нь хоорондоо ижил төстэй гэж үздэг. Туршилтад суурилсан эмпирик шинэлэх ухаануудтай адил материаллаг шинж чанарт анхаарахаасаа илүүтэй нэгж хэсгүүдийн зохион байгуулалт, хэлбэр, хоорондын харилцаа хамаарлыг судалдгаараа ялгаатай. Улам хурдасч буй компьютерын хөгжил, тэднийг хүнтэй төстэй болгох оролдлогуудаас үүдэн өнөө үед кибернетик нь хиймэл оюун ухаан болон автоматжуулалттай нягт холбогдож, мэдээллийн онолын салбарын санаануудаас олныг өөриймшүүлэн авч байна.³

Монгол хэлний тайлбар тольд “Цахим” гэдэг нь нэгдүгээрт, цахилгаан тооцоолон бодох техник, ийм төрлийн техник ашиглан үйл ажиллагаа явуулах. Цахим бараа, цахим тооцоолуур, цахим захиа, цахим шуудан, цахим багаж, цахим тоноглол, цахим карт, цахим хуудас. Хоёрдугаарт, маш хурдан. Цахилгаан цахих мэт хурдтай, цахим хурдыг⁴ ойлгоно гэж заасан байдаг. Electronic mail /e-mail/-ийг цахим шуудан гэж бид орчуулдаг. Тэгэхээр цахим гэдэг үгийн язгуур нь цахих, цахилгаан гэдэг үг болж байна. бидний өдөр тутам сонсож байдаг, өргөн хэрэглэгдэж байдаг e-game, e-office, e-citizen, e-government гэх зэрэг нэр томъёо нь “e” угтвар авснаар онлайн, дижитал байдлаар буюу интернэт, сүлжээний орчинд үйл ажиллагааг явуулж байна.

Цахим гэдэг нь мэдээлэл технологийн орчин дахь үйлчилгээ болон үйл ажиллагааны талаарх ойлголтыг өгч байгаа юм. Харин “кибер” гэсэн үг нь илүү өргөн хүрээний ойлголт бөгөөд эдгээр цахим үйл ажиллагааг явуулж буй дэд бүтэц, орчны үйл ажиллагаа түүний удирдлагын талаарх ойлголтыг агуулж байдаг. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын

1 [Norbert Wiener - Wikipedia](#)

2 [Oxford Learner's Dictionaries | Find definitions, translations, and grammar explanations at Oxford Learner's Dictionaries \(oxfordlearnersdictionaries.com\)](#)

3 “Britannica” ширээний нэвтэрхий толь 1530 дахь тал.

4 Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”



3.6.1.11-д “Кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх, аливаа гэмт хэргийг илрүүлэх, нотлоход тооцоолох хэрэгслийн криминалистик техникийн шинжилгээ ашиглах үндэсний чадавхыг бий болгоно”, 3.6.1.1-т “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн орчинд сөргөлдөх аюулаас сэргийлэх, кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх чиглэлд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ” гэх зэргээр тусгасан байдаг.

Тэгвэл “Кибер гэмт хэрэг” гэж юу вэ? Кибер гэмт хэрэг гэдэгт юуг ойлгох талаар судлаачдын олон янзын байр суурь байдаг. Тухайлбал судлаач Ц.Хүрэл-Очирын тэмдэглэснээр кибер гэмт хэрэг гэдэг нь товчхондоо компьютерын гэмт хэрэг болон интернэтийн гэмт хэргийг нэрлэж буй нэр томъёо юм. Интернэтийн гэмт хэрэг гэдгийг “компьютерын сүлжээгээр хийгдэж буй өөр өөр төрлийн гэмт хэргүүдийн нийлбэр” гэж томъёолж болох юм. Энэ талаар дэлхий нийтэд нэгдсэн тодорхойлолт өдийг хүртэл байхгүй. 2001 оны “Кибер гэмт хэргийн тухай” европын /Будапештийн/ конвенцид ч энэ талаар тодорхойлолт алга байгаа юм. Энэ нь мэдээж техник технологийн өсөлт, хурдацтай хөгжилтэй холбоотой юм.

“Britannica” нэвтэрхий тольд дурдсанаар “Кибер гэмт хэрэг” гэж компьютерыг залилан хийх, хүүхдийн порнограф болон оюуны өмч наймаалах, нэрийн хулгай, хувийн нууцад халдах зэрэг хууль бус үйлдэлд ашиглан аливаа үйлдлийг хэлнэ гэж тайлбарласан хэдий ч өнөө үед энэ төрлийн гэмт хэргийг дан ганц компьютер ашиглан үйлдэхээс гадна утас, таблет, хуурамч чип зэргийг ашиглан үйлдэж байна. кибер гэмт хэргийг дараах байдлаар ангилагдана.

- Хувь хүний эсрэг (вирус, залилан, фишинг, спам гэх мэт)
- Өмчийн эсрэг (бусдын эд хөрөнгийг сүйтгэх, хортой программ тараах гэх мэт)

Компьютер, компьютерын сүлжээ ашиглан үйлддэг гэмт хэргийг төрлөөр жагсаан бичвэл

- Эвдлэх ажиллагаа /сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэх, халдах/
- Тайван байдлыг алдагдуулах буюу кибер мөшгөгчид
- Аж ахуйн /эдийн засгийн тагнуул/
- Хүүхдийн порнограф
- Хулгай, спам
- Айлган сүрдүүлэх явдал
- Оюуны өмчид халдах, түүнийг олшруулах, тараах
- Секс сүрдүүлэлт


- Интернет луйвар
- Гутаан доромжлох, нэр хүндэд халдах
- Зээлийн карт хуурамчаар үйлдэх.

Монголчууд интернэтийг ус цахилгаан шиг хэрэглэх болсон гэж хэлэхэд хилсдэхгүй. Тэгвэл интернэтийн “амьгүй албатууд” буюу botnet-ын тухай авч үзвэл:

Botnet гэж юу вэ?⁵

Энэ нь “robot” болон “internet” гэсэн үгнүүдийн дундаас үүсгэсэн зохиомол үг. Интернэтийн орон зайд тодорхой үүрэг гүйцэтгэхээр программчлагдсан систем юм. Энэ нь дотроо сайн эсвэл муу зорилготой гэж хуваагдана. 2013 оны судалгаагаар дэлхийн нийт интернэт урсгалын (traffic) 40 хүрэхгүй хувийг хүмүүсийн үүсгэсэн урсгал эзэлдэг байна. Харин үлдсэн 60 орчим хувийг хүмүүс биш bot-ууд үүсгэж байна. Энэ 60 хувийг дахин нягталж харвал тал нь “сайн”, тал нь “муу” зорилгын үүднээс бий болсон урсгалууд байгаа ажээ.

Зураг-1



Дэлхийн интернэт урсгалын бүтэц (Эх сурвалж: Statista)

Тэгвэл bot-ын “сайн” урсгал гэж юу вэ?

Үүний ихэнх нь хайлтын систем (search engine) үүсгэж байгаа урсгалууд. Google, Yahoo мэтийн хайлтын системүүд дэлхий даяар ажиллаж байгаа бүх вебсайтуудын контентуудын өөрчлөлтийг шалгаж, индексжүүлэх

5 ИНТЕРНЭТ БОЛОВСРОЛД: Интернэтийн “амьгүй албатууд” (ikon.mn)

ажиллагааг тасралтгүй явуулж байдаг. Ингэснээр таны хайлтын үр дүн маш хурдан илэрдэг гэж ойлгож болно. Энэ бол Google зэрэг хайлтын серверээс бусад вебсайтууд руу хандаж байгаа автомат урсгал.

Харин “муу” буюу сөрөг bot-уудын урсгал гэж юу вэ?

Энэ нь хакеруудын зориуд зохион байгуулсан буруу зорилгоор үүсгэж байгаа урсгал. Энэ үйл явц хэрхэн явагддаг вэ?

Зураг-2



Botnet хэрхэн ажилладаг вэ? (эх сурвалж: Wikipedia)

1. Хакерууд эхлээд вирус хэлбэрээр тусгай программаа хүмүүсийн компьютерт халдаана
2. Аль болох олон компьютерт халдсанаар хакер нь олон компьютерыг эзэнд нь мэдэгдэлгүй удирдах боломжтой болно гэсэн үг. Ингэсэн компьютеруудыг “зомбинууд” ч гэдэг.
3. Үүний дараа хакер нь хэн нэгнээс мөнгө авч захиалга авна.
4. Ингээд хакер нь захиалгат үйлдлийг эзэнд нь мэдэгдэлгүйгээр “зомби” компьютеруудад команд өгч гүйцэтгүүлнэ.



Зорилго нь аль нэг сервер руу “зомби” компьютеруудаас довтолгоо үүсгэх, сурталчилгаа спам тараах, хиймэл ачаалал, урсгал үүсгэх зэрэг.

Дэлхий дээр хамгийн том botnet нь 30 сая “зомбитой” байжээ.

Өөрийн компьютерээ “зомби” болгохгүйн тулд антивирусны програм суулгаж, байнга шинэчлэлт хийж байх хэрэгтэй.

Нэг жишээ татахад хэн нэгэн өөрийн вебийн хандалтыг өсгөхийн тулд мөнгө төлж bot-уудын урсгалыг өөрийн веб рүү үүсгүүлж болно. Дэлхийн хаа нэгтээ байгаа хэн нэг хүний компьютер эзнээ мэдээгүй байхад уг сайт руу зочилж хандалт үүсгэж байгаа гэсэн үг. Ийм үйлчилгээ үзүүлдэг botnet-үүд интернэтэд олон бий. Өдөрт хэдэн “зомби” хэрэглэгчээс хандалт үүсгэх вэ гэдгээсээ хамаараад үнэлгээтэй байдаг. Ингэж вебсайтаа олон хандалттай болгож харагдуулах замаар үнэ хүргэж зарах, эсвэл сурталчилгааны гэрээ байгуулах зэрэг луйвар хийж болно

Вебсайтыг юунд нь итгэж үнэлэх вэ?

Энэ бол цэвэр таны хувийн үзэмж, итгэл үнэмшлийн асуудал. Хийц дизайн, өнгө үзэмж, агуулгын чанар, ашигласан технологи, зах зээлд байршсан брэнд, нэр хүнд зэрэг олон үзүүлэлтээр нь үнэлэх нь хамгийн зөв, найдвартай арга болно.

Хариуцсан хүний нөөц, ажилтан тэмцэж байгаа байдал:

Орчин үеийн шинээр үүсэж буй технологийн гэмт хэргүүд, түүний дотор кибер гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт, чадамжийг Монгол Улсад бий болгохын тулд юуны өмнө Эрүүгийн хуульд гэмт хэргийн шинэ шинж, бүрэлдэхүүнийг нэмэх, “Мэдээллийн технологи, харилцаа холбооны тухай”, “Мэдээллийн аюулгүй байдлын тухай”, “Өгөгдөл хамгаалах тухай”, “Төрийн өгөгдөл, мэдээлэлд хандах тухай”, “Цахим засгийн тухай” хууль, “Төрийн өгөгдөл мэдээлэл, сүлжээ, системийг хамгаалах тухай” хуулийг шинээр батлан гаргах, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай”, “Мэдээллийн эрх чөлөөний тухай”, “Оюуны өмчийн тухай” хууль гэх зэрэг 40 орчим хуульд нэмэлт өөрчлөлт оруулж орчин үеийн кибер гэмт хэргийн шинжүүд, орчин үеийн мэдээллийн технологийн харилцааны зөв зохистой зохицуулалтыг бий болгох, хамгаалах харилцаануудыг тодорхой болгон зохицуулах, цахим нотлох баримт, түүнийг үнэлэх асуудлыг нэмэх, нийгэмд кибер гэмт явдалтай тэмцэх сэтгэхүйг төлөвшүүлэх, мэдээллийн технологийг зөв зохистой хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, өгөгдөл, мэдээллийн үнэ цэнийг бий болгох, хамгаалах сэтгэхүй болон мэдээллийн аюулгүй байдлын үнэ цэнэ, ач холбогдол, түүний тухай ойлголтыг нийгэмд төлөвшүүлэх, кибер



гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан, нөхцөлийг судлах, тэмцэх зохицуулалтыг бий болгох нь шийдвэрлэх арга замуудын нэг юм

Кибер аюулгүй байдлын тухай хуульд зааснаар Кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог дараах байгууллагууд хариуцна.⁶

- Засгийн газар
- Кибер аюулгүй байдлын зөвлөл
- Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- Тагнуулын байгууллага
- Зэвэгт хүчний кибер аюулгүй байдлыг хангах байгууллага
- Цагдаагийн байгууллага
- Төрийн өмчит хуулийн этгээд
- Хуулийн этгээд
- Иргэн
- Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага
- Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв
- Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төв
- Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв
- Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх зэвсэгт хүчний төв

Кибер орчин дахь мэдээллийн аюулгүй байдлын тухай⁷ энэ хаана орох мэдээлэл вэ?

Мэдээллийн аюулгүй байдлын хүрээнд мэдээлэл нь тухайн хувь хүн, байгууллагын үйл ажиллагаа ажил хэргээ хэвийн явуулахад шаардагдах гол хөрөнгө, баялаг учир техникээр, эрх зүйгээр зайлшгүй хамгаалагдсан байх ёстой. МАБ гэдэг нь ажил хэргийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн байх нөхцөл байдлыг хангах, эрсдэлийг багасгах, хөрөнгө оруулалтын үр ашиг, бизнесийн боломжийг нэмэгдүүлэхийн тулд мэдээллийг олон янзын аюул, заналаас хамгаалах ажиллагаа. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, хадгалах, түгээх, дүн шинжилгээ хийж зохистой ашиглах чадвараар байгууллагын манлайлал үнэлэгдэг учраас МАБ чухал.

Мэдээллийн аюулгүй байдал нь мэдээлэл болон мэдээллийн сүлжээ, системд зөвшөөрөлгүй хууль бусаар нэвтрэх, хандах, мэдээллийг ашиглах, ил болгох, өөрчлөх, хуулах, устгах, мэдээллийн системийн үйл ажиллагааг тасалдуулах, хяналтад байлгах зэрэг хууль бус бүхий л үйл ажиллагаанаас хамгаалах цогц тогтолцоог ойлгоно. МАБ-ын үндсэн 4-н зарчмыг тодорхойлж болно:

Үнэн зөв, бодитой мэдээллийг зөв хүнд зөв цагт зөв хэлбэр бүтэцтэй бүрэн бүтэн хүргэж байх явдал. Мэдээлэл харилцааны салбарт үндэсний аюулгүй

6 КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ (legalinfo.mn)

7 КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ (legalinfo.mn)



байдлыг хамгаалах үүднээс Улс, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй хэвийн байдлыг баталгаажуулах тухай цогц ойлголт багтана. МАБ-ыг хангах хууль тогтоомжийн түвшин гол хоёр багц арга хэмжээг авах зорилгоор хэрэгжүүлдэг. Үүнд:

- Нийтэд МАБ-ын ойлголт, мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, амьдрал үйл ажиллагаанд хэвшүүлэх, сургах арга хэмжээ авах үйл ажиллагааг зохион байгуулах
- МАБ-ын зөрчил, зөрчил гаргагчдыг нийтийн зүгээс буруутгах, ял шийтгэл оноохыг шаардах зэрэг сэтгэл зүйг төлөвшүүлэх арга хэмжээ авахад чиглэгдэнэ.

МАБ-ын чухал шинж нь аливаа шинжилгээ, судалгаа, бодлогын ажилд мэдээллийн нөөцийг төвлөрүүлэх, дээрх дөрвөн түвшний хандлагыг байгууллага, иргэн бүрт бий болгох, боловсролын үйл ажиллагаанд танин мэдүүлж сургах, зөрчил гаргагчдыг шийтгэх хандлагыг бий болгох, төлөвшүүлэхэд бодлого, хууль тогтоомжуудыг чиглүүлэх онцлогтой. Үүний тулд энэ салбарт хэрэглэгддэг үйл ажиллагааны дэс дараалал, ашиглагддаг техник-хэрэгсэл, хэрэглэгддэг нэр томъёог нэгдмэл байдлаар танин мэдсэнээр зохицуулах нэгдмэл хууль тогтоомжийг боловсруулах, аливаа сөрөг үзэгдэлтэй тэмцэх арга, арга зүйг богино хугацаанд хэрэгжүүлж чадна гэж үздэг.

Цахим гэмт хэрэг нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгт тооцогддог бөгөөд дэлхийн эдийн засагт жилд дунджаар 1 их наяд орчим ам.долларын хохирол учруулдаг байна. Иймээс цахим гэмт хэргээс сэргийлэхийн тулд цагдаагийн байгууллагууд дараах арга хэмжээг авч, зөвлөмж боловсруулсан байна.

Өрх гэр болгон интернэттэй, хүн болгон ухаалаг гар утас хэрэглэгч, интернэт хэрэглэгч болсон гэхэд хилсдэхгүй. Гэвч энэ өсөлт хөгжлөө дагаад цахим орчинд хуурамч нэр хаягаар өсвөр насны хүүхдүүдийг буруу, хорт зуршил руу уруу татах, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, дарамтлах, залилах, хууран мэхлэх гэмт хэргүүд ихээр гарах болсон. Эдгээр хүчин зүйлсийг авч үзвэл эцэг, эхчүүд, асран хамгаалагч нарын хяналт сул, анхаарал болгоомж, мэдээлэлгүйгээс болоод энэ төрлийн гэмт үйлдлүүд гарсаар байгааг цагдаагийн байгууллагаас сануулж, олон талын урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлуудыг зохион байгуулж байгаа аж.

Цахим гэмт хэргийн аюулаас өөрийгөө болон гэр бүлээ хамгаалахад баримтлах гол зүйл бол цахим гэмт хэрэг үйлдэх этгээдтэй адилаар бодож, сэтгэх явдал юм. Өөрөөр хэлбэл, кибер гэмт хэрэгтний голчлон хэрэглэдэг арга, хэрэгслийн эсрэг арга хэмжээ авах нь зүйтэй гэдгийг ЦЕГ-аас зөвлөмж болгож байна. Ингээд кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтлэг 10 аргыг танилцуулъя. Иргэд, олон нийтэд гэр бүлээ цахим гэмт хэрэгт өртөхөөс



хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ямар алхмуудыг хийх ёстой вэ.⁸ Үүнд:

1. Компьютерын системээ шинэчилж байх
2. Системийн тохиргоогоо хамгаалах
3. Нэвтрэх үг буюу нууц үгээ сайжруулж, хамгаалах
4. “Галт хана”-аа асаалттай байлгах
5. Вирусны эсрэг программ суулгах буюу түүнийгээ шинэчилж байх
6. Хувийн мэдээллээ хамгаалах
7. Вэб сайтын нууцлалын бодлогыг хэвлэн авч, анхааралтай унших
8. Санхүүгийн мэдээлэл, дансны хуулгаа тогтмол хянах
9. “Үнэгүй зүйл зөвхөн хавханд л байдаг” буюу танд маш их аз тохиолдоход эргэлзэн нягтлан шалгаж байх
10. Компьютероо унтраах

Нэгдүгээр бүлгийн дүгнэлт:

Мэдээлэл, технологи хурдацтай хөгжихийн зэрэгцээ “шинэ” харилцааг бий болгож байна. Үүний илрэл нь цахим мэдээлэл, харилцаа, орчин, орон зайг бий болгож байгаа явдал юм. Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд олон нийтийн сүлжээ ашиглаж /цахим хуудас, фейсбүүк, твиттер, юүтүб зэрэг/ аливаа зүйлийг нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх орон зай нэгэнт бүрдсэн. Энэхүү цахим харилцаанд оролцохдоо худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох зүй бус үйлдэл гарах болсноор бусдын эрх чөлөөг хамгаалах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Ер нь цахим орчинд худал мэдээ, мэдээлэл тараах, бусдын нэр төр, алдар хүндийг гутаах үйлдлийг иргэний буруу гэхээс илүүтэй гэмт хэргийн үндсэн шинж, учруулсан хор хөнөөлийг нарийвчлан тодорхойлж гэмт хэрэг гэж үзэж тусгайлсан хуулиар зохицуулахыг санал болгодог хэсэг байхад, нөгөө хэсэг нь үүнийг Үндсэн хууль, Иргэний хууль, журмаар зохицуулах, эсхүл хувь хүний өөрийнх нь соёлын хэмжүүр болгох, мэдээлэл хүлээн авах боловсрол олгох тал дээр илүүтэй анхаардаг байна. Иймээс цахим орчинд худал мэдээ, мэдээлэл тараах, бусдын нэр төр, алдар хүндийг гутаах үйлдлийг зохицуулахдаа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ашиг сонирхол, нөгөөтээгүүр хүний нэр төр, алдар хүндэд халдсанаас үүсэх ноцтой хохирол, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөө зэргийг харгалзан үзэж судалсны үндсэнд цахим орчин дахь гэмт хэрэг мөн эсэхийг тодруулж хуульчлах хандлагатай байна.

8 [Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт /харьцуулсан судалгаа/ – Хууль зүйн үндэсний хүрээлэн \(nli.gov.mn\)](#)



ХОЁРДУГААР БҮЛЭГ: ЦАХИМ ОРЧИНД ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ СУДАЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН.

Цахим орчин дахь гэмт хэргийн талаар иргэдийн дунд хийсэн судалгааны арга зүй:

2021-2024 оны цахим гэмт хэргийн тоон судалгааг харьцуулсан байдал.



2021-2024 оны цахим гэмт хэргийн харьцуулалтын график⁹

Хөл хорионы үеэр ихэнх хүмүүс гэрээсээ ажиллах болсноор кибер гэмт хэрэгтнүүд хуурамч Zoom, Microsoft Teams болон Google Meet платформуудыг ашиглаж эхэлсэн ба 2021 оны 1-р сараас өдийг хүртэл дэлхийн хэмжээнд 6,576 Zoom-тэй холбоотой домэйн бүртгэгдсэн байна. BleepingComputer цахим сэтгүүлийн мэдээлснээр Zoom-ийн 500 гаруй мянган хэрэглэгчийн мэдээлэл хууль бус цахим хаягуудад байршиж байсан ба уг хаягуудыг ашиглан Zoom-ийн хуралд урилгагүйгээр орж ирэх тохиолдлууд гарсан.

2020 оны мэдээлэл алдагдлын тухай тайлангаас харахад 32% нь фишинг имэйлээс үүдэлтэйгээс гадна кибер тагнуулын 78% нь фишинг халдлагаар ажиллагаагаа эхэлж байсан байна.

2022 оны эхний таван сарын байдлаар 5,523 залилах гэмт хэргийн 3,618 буюу 65.5 хувь нь цахим орчинд үйлдэгдсэн байна. Цахим төрлийн гэмт хэргийн хохирогчдын дийлэнх хувийг 35-аас дээш насныхан эзэлж байгааг цагдаагийн газраас мэдээлж байв. Мөн 2022 оны эхний арван сарын байдлаар цахим залилангийн гэмт хэргээр 19 тэрбумын хохирол учирч байжээ.

1,233 буюу 34.1% нь фейсбүүкээр мөнгө зээлэх, бараа худалдан авалт хийх, цахим орчинд харилцаа тогтоон тухайн хүнийхээ илтгэлийг олж мөнгө шилжүүлэх хүсэлт илгээх, бага хүүтэй зээл санал болгож урьдчилгаа шимтгэл авах, олны танил хүмүүс болон байгууллагын нэрийг барьж азтан тодруулах зэргээр, 754 буюу 20.8% нь хандив тусламж авахаар цахим орчинд хандсан

9 News.MN - Мэдээллийн эх сурвалж



иргэдийн фейсбүүк хаягийг ашиглан хуурамч данс нээж залилах, 110 буюу 3% нь байр түрээслэх, 1,476 буюу 40.1% нь найз нөхдийн нэртэй хуурамч хаягаас яаралтай мөнгө зээлэх хүсэлтийг явуулж урьдчилан бэлтгэсэн дансанд мөнгийг шилжүүлж авах зэрэг арга хэлбэрээр үйлдэгдсэн байна.


Цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо, хохирол асар хурдацтай өсөн нэмэгдэж байна. Цагдаагийн байгууллагын мэдээллээр зөвхөн 2023 онд цахим орчинд үйлдэгдсэн 8,563 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Ганцхан жилийн дотор цахимаар залилах гэмт хэрэг 99.8 хувиар буюу 2 дахин, алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг 95.2 хувиар, кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэрэг 70.7 хувиар, хулгайлах гэмт хэрэг 37 хувиар, хүүхдийг садар самуунд уруу татах, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг 18.5 дахин, бусдын эд хөрөнгийн авахаар заналхийлэх гэмт хэрэг 8.9 дахин өсжээ. Энэ бүх тоо статистикийг дурдаад өнгөрөх нэг хэрэг. Нугарч өссөн тоо хэмжээ, хувь бүрийн цаана монгол хүний амьдрал, хувь заяа, амь нас, эрүүл мэнд, хүүхдийн ирээдүй, насан туршид нь үл арилах сэтгэлийн шарх, гэмтэл үлдэж хоцорно гэдгийг төсөл санаачлагч илтгэлдээ дурдсан. 2023 онд цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас 19 тэрбум төгрөгийн хохирол учраад байгаа аж.

2024 онд кибер аюулгүй байдал өмнөх оныхоос 39,5%- иар буурсан байна. Энэ нь цагдаагийн байгууллага болон бусад холбогдох албан байгууллагууд иргэдийн аюулгүй байдлын хангах үүднээс системийн хамгаалалтыг сайжруулах үйл ажиллагаа хийж байгаатай холбоотой юм.

Google from ашиглан асуулга боловсруулж, түүнийгээ интернэт орчинд байршуулан ард иргэдээс судалгаа авсан. Судалгаанд нийт 200 иргэн оролцсон. Судалгааны үр дүнг нэгтгэн гаргавал:

1. Таны бодлоор цахим гэмт хэрэг гэж юу вэ?

Цахим гэмт хэргийн үзэл бодол



Үүнээс үзэхэд цахим гэмт хэрэг гэдгийг судалгаанд оролцсон хүмүүсийн 45% нь залилан гэж ойлгож байна. Энэ нь магадгүй манай улсад онлайн шоп, интернэт покер, интаграмм, твиттер, ютүбе, фейсбүүк, хуурамч цахим хаягууд гэх мэт маш олон программ бий болсноор хүмүүст цахим дарамт,



бие биеэ гутаан доромжлох, интернэт хаягаар нь нэвтрэн орж ойр дотны хүмүүсээс мөнгө авах, онлайн шопыг түлхүү ашигладаг болсонтой холбоотой хуурамч захиалга авч мөнгө санхүүгээр нь хохироох, тоглоом нэрийдлээр хүмүүсийн цахим тоглоомд их хэмжээгээр хамруулж, санхүү, цаг зав, эрүүл мэнд, эд хөрөнгөөр нь хохироож байна.


2. Цахим гэмт хэрэгт өртөж байсан уу?



■ Цахим гэмт хэрэгт өртсөн эсэх

53% нь цахим гэмт хэрэгт өртөж байсан гэж хариулсан. Үүнээс харахад иргэдийн дийлэнх нь цахим гэмт хэрэгт өртөж байгаа гэсэн таамаглал дэвшүүлж болох юм. Энэ нь мэдээж мэдээлэл, технологи хурдацтай хөгжихийн зэрэгцээ “шинэ” харилцааг бий болгож байна. Үүний илрэл нь цахим мэдээлэл, харилцаа, орчин, орон зайг бий болгож байгаа явдал юм. Энэхүү цахим харилцаанд оролцоходоо худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох зүй бус үйлдэл гарах болсноор бусдын эрх чөлөөг хамгаалах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

3. Тийм бол ямар төрлийн гэмт хэрэгт өртөж байсан вэ?



Энэхүү судалгаанаас үзэхэд интернэт луйвар 66,7%-ийг эзэлж байна. Энэ мөн л цахим орчин алхам тутамд хөгжиж байгаатай холбоотой. Хэн нэгний цахим хуудсыг хакердах, зөвшөөрөлгүй нэвтрэх үйлдлээс болж хэрэглэгчид бие махбод, мөнгө санхүү, эд материалаараа хохирч байна. Мөн гутаан доромжлох нэр хүндэд халдах 33,3%-ийг эзэлж байна. Цахим орчинд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг цаг үе ирсэн учраас бусдын асуудалд хэт оролцох, түүний хувийн орон зайд халдах, зургийн зөвшөөрөлгүй авч



гутаан доромжлох асуудал гарсаар байгаатай холбоотой юм. Сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэх, халдах 28,6%-ийг эзэлж байна. Бусдын хувийн мэдээлэлд үндэслэн цахим хаяг руу нь алдах, нэвтэрч орж залилан хийх үйлдлүүд гарсаар байгаагийн тод жишээ юм. Секс сүрдүүлэлт, порнографийн халдлагад 9,5%-ийг эзэлж байна. Энэ нь цахим орчин, зурагт, контент гэх мэт зүйлүүдийг насны хязгаар заахгүйгээр бүх насны хүн үзэж болохоор олон нийтийн сүлжээнд цацагддаг. Үүнээс үүдэн магадгүй сэтгэцийн өөрчлөлтөд өртсөн хүмүүс, гаж донтон гэж нэрлэгддэг хүмүүс эдгээр зүйлийг үйлдэж байна.



Цахим гэмт хэрэгт өртсөн хүмүүсийн дийлэнх нь найз, нөхөд болон бусад(хуурай ах, эгч, ажлын газрын хүмүүс) гэсэн сонголтыг сонгосон байгаагаас харахад цагдаагийн байгууллагад хандаж албан ёсны арга хэмжээ авч ажиллахгүй байгаагаас үүдэж гэмт хэрэгтнийг дахин хэрэг үүлдэх боломжийг бий болгож байна. Цахим гэмт хэргийг ойр дотны найз нөхөд ч үүлдэх боломжтой учир албан ёсны байгууллагад мэдэгдэх хэрэгтэй.

5. Та цахим гэмт хэргээс хэрхэн сэргийлж байна вэ?

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн сэргийлдэг арга замаас урьдвал:

- Цахим хаягаар мөнгө асуувал тухайн хүний утасны дугаар луу залгаж асуух
- Цахим системд хувийн мэдээлэл оруулахгүй байх
- Танихгүй дугаар авахгүй. Янз бүрийн цахим шуудан руу орж холбоосон дээр дарахгүй байх.
- Нийтлэг болдог цахим гэмт хэргээс хамгаалах талаар судалж үзсэний үндсэн дээр хамгаалж байна.
- Хувийн мэдээллээ цахим сүлжээнд дэлгэхээс татгалздаг. Ямар ч хүний явуулсан линк рүү хамаагүй ордоггүй.
- Өөрийн мэдээллийг нууцлан цаашид давхар шалган нягталж байгаа.



- Танихгүй хүний хүсэлтийг авдаггүй. Өөрийн зургийг цахим орчинд нийтлэхээ больсон.

Эдгээр хариултуудаас харахад цахим гэмт хэргээс сэргийлэхийн тулд өөр өөрсдийн арга барилыг ашиглаж байна. Энэ нь хүн бүр дор бүрнээ цахим гэмт хэрэгтэй тэмцэж байгаа нэг жишээ юм. Дийлэнх хүмүүс цахим гэмт хэргээс сэргийлэхдээ хакардуулахгүй байхын тулд нууц үгээ чандлан нууцлах хэцүү код оруулах, өөр хүн нэвтэрч орж байгаа талаарх мэдээллийг жимэйл хаяг нь дээр мэдэгдэл ирүүлэх гэх мэт маш олон аргаар сэргийлж байна.

6. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг та хаанаас авдаг вэ?

Иргэдийн судалгаанаас урьдвал:

- Ойр дотны хүмүүсээсээ
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
- Ихэвчлэн хохирч байсан хүмүүсийн яриа туршлагаас.
- Интернет, ажлын мэдээллийн аюулгүй байдлын алба

Иргэдийн дийлэнх хувь нь олон нийтийн сүлжээ буюу интернет орчин, цахим хуудаснуудаас авч байна гэж хариулсан байна. Цаасаар хэвлэсэн зүйл гэхээс илүү одоо үед цахим хаяг байгаа л бол цахим орчинд бүх мэдээлэл бэлэн байгаа учраас ард иргэд цахимаар мэдээлэл авч сэргийлж байна.

7. Цахим гэмт хэрэгт өртөхгүй байхад иргэдийн үүрэг оролцоо чухал уу? Яагаад?

Иргэдийн судалгаанаас урьдвал:

- Иргэд бүр хувьдаа хариуцлагатай байвал цахим гэмт хэрэгт өртөхгүй байх болов уу. Гэхдээ энэ зүйлийг хүн дор бүрнээ хийж хэрэгжүүлэх нь бас хэцүү зүйл.
- Чухал. Анхаарал болгоомж хариуцлага байх оролцооны нэг хэлбэр юм.
- Иргэдийн хянамгай, шүүн тунгаах чадвар урьдчилан сэргийлэхэд чухал. Мөн мэдээ мэдээлэл хүлээж авдаг байх нь өөрсдийн болон эргэн тойрны хүмүүсийн аюулгүй байдлыг хангахад чухал.
- Өөрийгөө маш сайн хамгаалбал аливаа гэмт хэрэгт өртөхгүй ээ
- Ар гэрийн хараа хяналт чухал, цахим гэмт хэрэгт өртөгчдийн нээлттэй байдал чухал



Цахим гэмт хэрэгт өртөхгүй байх нь мэдээж иргэдээс 100% хамаарна. Яагаад гэвэл найз нөхөд, хамаатан садан мөнгө асуулаа гэхэд тухайн хүний угтасны дугаар луу залгаж асуудаг байх. Нууц үгээ алдахгүй байхын тулд маш чанартай нууц үг хийх, цахим орчинд байгаа эх сурвалж нь тодорхойгүй холбоос руу орохгүй байх, цахим орчинд хувийн мэдээллээ бага оруулах, янз бүрийн зураг оруулахгүй байх гэх мэт зүйлүүдийг иргэд өөрсдөө хийх учраас энэ бүгдийг зөв зохистой ашиглаж чадвал цахим гэмт хэрэгт өртөхгүй байж чадна.

Хоёрдугаар бүлгийн дүгнэлт

Цахим орчинд үйлдэж буй гэмт хэрэг эсхүл цахим хэрэгсэл ашиглан үйлдэж буй гэмт хэрэг гэдэг нь цахим орчинд бусдын эд хөрөнгө, нэр хүндэд халдахад чиглэсэн үйлдлээс гадна бусдыг хууль бусаар мөрдөх, мэдээллийн аюулгүй байдалд халдах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хүний наймаа, хүүхдийг садар самуунд уруу татах, бусдыг айлган сүрдүүлэх, хар тамхи, мансууруулах төрлийн бодис худалдаалах зэрэг гэмт хэргийг үйлдэхдээ цахим хэрэгсэл ашиглаж байгаа бүхий л үйлдлийг хэлнэ. Иймээс л иргэд цахим орчны талаарх ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар судалгаа авахад 53% нь цахим гэмт хэрэгт өртөж байсан. Үүнээс дийлэнх дийлэнх буюу 66,7% нь интернэт луйварт өртөж байна гэсэн үзүүлэлт гарсан. Өртсөн талаараа ажлын найз, албан тушаалтан, хуурай ах, эгч, дүү нартаа хэлдэг байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Кибер гэмт хэргийн тухай конвенцод нэгдэн орох, соёрхон батлах, эсхүл түүний агуулгыг Эрүүгийн хуульд нэг бүрчлэн хуульчилж одоогийн эрх зүйн зохицуулалтаа сайжруулж, шинэ төрлийн цахим гэмт хэргийн нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, энэ зорилгоор олон улсын болон бүс нутгийн, хоёр талт харилцаатай байх боломж бүрдэнэ. Мөн дараах ойлголтыг хуульчлах нь эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээд ял завших явдлыг таслан зогсооход чухал үр нөлөөтэй.

Үүнд: компьютерын сүлжээ, компьютерын систем, компьютерын мэдээлэл, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч, мэдээллийн урсгал, компьютерын мэдээлэл, сүлжээний нууцлал, бүрэн бүтэн байдал, ашиглалт гэх мэт байдлаар гэмт хэрэг, зөрчлийн төрөл, онцлогоор нь хуульчлах шаардлагатай. Түүнээс гадна мэдээлэлтэй холбоотой эрх зүйн актууд, төрийн бодлогын баримт бичгүүдэд энэ төрлийн гэмт үйлдэл, зөрчлөөс сэргийлэх, хүүхэд залуус, нийгмийн гишүүдийг зөв, соёлтой, аюулгүй зан үйлд сургах, төлөвшүүлэх талаар тусгаж өгөх шаардлагатай нь харагдаж байна. Цэцэрлэг, дунд сургуулиас нь эхлэн хүүхэд, өсвөр үеийнхэнд аюулгүй зохистой хэрэглээ, соёлтой зөв зан



үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтын агуулга, хөтөлбөрийг бий болгох, мэдээлэл зүйл хичээлийг агуулгад нэмж оруулах шаардлага харагдаж байна. Их дээд сургуулийн мэргэжлийн оюутнуудад “Кибер орчинд ажиллах ёс зүй, соёл” хичээлийг ордог болгох хэрэгцээтэй байна.

Санал зөвлөмж:

- Үл таних хүнээс ирсэн имэйлийг нээж үзэхгүй байх;
- Вэбсайт, домайны нэрийг нягталж шалгах;
- Линк дээр шууд товшиж хандах бус хөтөч дээрээ хаягийг өөрөө шивж оруулах;
- Өөр бусад аппликешн болон аккаунтуудын нууц үгийг давхар ашиглахгүй байх.



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

АНУ-ЫН ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



*С.Золзаяа
Судлаач*

- I. Оршил
- II. Үндсэн хэсэг
 - A. Захиргааны хэм хэмжээг тогтоох үйл ажиллагаа (Rule making)
 - B. Албан бусаар хэм хэмжээг тогтоох үйл явц (Informal rulemaking process)
 - C. Мэдэгдэл болон тайлбарт тавигдах шаардлагаас үл хамаарах зүйлүүд (Exceptions to the notice and comment requirements)
 - D. Нэг талын төлөөх холбоо харилцаа (Ex Parte contacts)
 - E. Бусад хэм хэмжээг тогтоох үйл ажиллагаа (Other rulemaking procedures)
- III. Дүгнэлт, зөвлөмж
- IV. Ном зүй
- V. Товч утга

I. Оршил

A. Судалгааны объект, судлагдахуун

АНУ-ын захиргааны эрх зүйд захиргааны хэм хэмжээ тогтоох гэдэг нь захиргааны байгууллагуудын хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгон нийтээр дагаж мөрдөх заавал дагаж мөрдөх хэм хэмжээг батлах үйл явцыг хэлдэг байна. Уг судалгааны ажлаар бид дараах дэд сэдвүүдийг дэлгэрүүлэн АНУ-ын захиргааны эрх зүйн хэм хэмжээ тогтоох үйл ажиллагааг үйл явц, шат тус бүрд нь дэлгэрүүлэн авч үзэн судалж, дүгнэхийг



зорьсон билээ.

1. Rule making (Хэм хэмжээг тогтоох)
2. Informal rulemaking process (албан бус хэм хэмжээг тогтоох)
3. Exceptions to the notice and comment requirements
4. Ex Parte contacts
5. Other rulemaking procedures

АНУ-ын засаг захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа норматив актуудыг боловсруулах, батлан гаргах болон тодорхой этгээдийн хэргийг хянан үзэх, энэ талаар шийдвэр (ганцаарчилсан актууд) гаргах гэсэн хоёр үндсэн хэлбэрээр илэрдэг. АНУ-ын Үндсэн хуулиар эрх зүйн актууд батлан гаргах бүрэн эрхийг Конгресст олгосон бөгөөд Филадельфийн чуулганаар Үндсэн хуулийг баталсан түүхийг баталсан түүхийг задлан шинжилж үзэхэд үндэслэгч эцгүүд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад хэм хэмжээ тогтоох бүрэн эрх хадгалагдахаар үндсэн хуулийг бодож хийгээгүй нь харагддаг. Хэдий тийм боловч засаг захиргааны байгууллагууд ажиллаж эхэлсэн цагаасаа л норматив актууд батлан гаргаж ирсэн юм. Үндсэн хуульд зааснаар ийм эрхгүй байгаа хэр нь уул эрхийг Конгрессоос эхлээд Ерөнхийлөгч, департаментууд, дараа нь хараат бус, бие даасан агентлагууд олж авсан байна.

Б. Судалгааны арга зүй

Социологийн онол арга зүй нь жам ёсны эрхийн онолын нэгэн адил хуулийн хүрээнээс хальж эрх зүйг судалдаг. Гэхдээ жам ёсны эрхийг бус, эрх зүйн зохицуулалт, эрх зүйн хэрэглээний практикийн хүрээнд эрх зүйг судалдагараа онцлог. Тиймээс чанарын судалгааны аргыг ашиглан академик судалгааг хүргэхийг зорив.

В. Шинжлэх ухааны таамаглал

Захиргааны хэм хэмжээг заримдаа дүрэм, журамтай хамтад нь тайлбарладаг. Шүүхийн шийдвэрээс ялгаатай нь буцаан хэрэглэж болох бөгөөд хамрах хүрээ нь хязгаартай байдаг ба захиргааны хэм хэмжээ тогтоох нь (Rulemaking) хууль тогтоох чиг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь хэтийн төлөвтэй бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагддаг өргөн хүрээний ойлголт юм

Г. Судлагдсан байдал, судлах шаардлага

Өрнөдийн улс орнуудын захиргааны эрх зүйн ерөнхий тойм- Ж.Сүхбаатар 2001 он номд АНУ-ын захиргааны хэм хэмжээ тогтоох үйл ажиллагаа сэдвийг судлан авч үзсэн байсан ба тус сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй судалгаа бичлэг ховор байна. Тиймээс уг сэдвийн хүрээнд судалгаа хийх шаардлагатай.



II. Үндсэн хэсэг.

Захиргааны хэм хэмжээ тогтоох үйл ажиллагаа нь шинэ үзэгдэл биш гэдгийг хамгийн түрүүнд онцлон тэмдэглэхийг хүсэж байна

Захиргааны эрх зүй дэх хэм хэмжээг тогтоох үйл ажиллагаа (*Administrative Rulemaking*)

A. Захиргааны хэм хэмжээг тогтоох үйл ажиллагаа (*Rule making*)

Захиргааны хэм хэмжээ тогтоох гэдэг нь захиргааны байгууллагуудын хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгон нийтээр дагаж мөрдөх заавал дагаж мөрдөх хэм хэмжээг батлах үйл явцыг хэлдэг байна.

Эдгээр захиргааны хэм хэмжээг заримдаа дүрэм, журамтай хамтад нь тайлбарладаг. Шүүхийн шийдвэрээс ялгаатай нь буцаан хэрэглэж болох бөгөөд хамрах хүрээ нь хязгаартай байдаг ба захиргааны хэм хэмжээ тогтоох нь (*Rulemaking*) хууль тогтоох чиг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь хэтийн төлөвтэй бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагддаг өргөн хүрээний ойлголт юм.

Агентлаг шинэ дүрэм батлах журмыг Захиргааны журмын тухай хууль («АРА») гэнэ. Түүнчлэн агентлагийн дотоод бодлогод тусгасан болно.

Үндсэн хуулийн “Зохих ёсны үйл ажиллагаа”-ны (*Due process*) зохицуулалт нь агентлагийн хэм хэмжээ боловсруулахад хамаарахгүй тул хэм хэмжээг тогтооход Үндсэн хуульд нийцэх шаардлагатай журам байдаггүй.

Захиргааны журмын тухай хууль нь хууль тогтоох үйл ажиллагаанд хэрэглэгдэхдээ агентлагууд хэрэгжүүлэх ёстой хэд хэдэн журмыг тогтоодог. Гэсэн хэдий ч дэвшүүлж буй бүх дүрмүүд ижил биш байдаг. Хуульд өөрөөр заагаагүй бол ихэнх санал болгож буй дүрмүүд нь албан бус хэм хэмжээ боловсруулах (*Informal Rulemaking*) гэж нэрлэгддэг үйл явцыг дагаж мөрддөг бөгөөд энэ нь хэм хэмжээг агентлаг батлахаас өмнө олон нийтийн оролцоотой «мэдэгдэл, санал»-ын хугацааг хамардаг. Гэсэн хэдий ч Захиргааны журмын тухай хууль нь албан ёсны хэм хэмжээ гэж нэрлэгддэг хэм хэмжээг батлах өөр багц журмыг мөн тусгасан. Агентлагийг удирдаж буй хэм хэмжээг тодорхой төрлийн хэм хэмжээ батлахын тулд “баримт бичгийн сонсгол” явуулахыг шаардсан тохиолдолд агентлагууд албан ёсны хэм хэмжээ (*Formal Rulemaking*) боловсруулалтыг ашигладаг.¹

Ийм тохиолдолд мэдэгдэл, санал өгөх үйл явцын оронд хэм хэмжээг тогтоох үйл явцын нэг хэсэг болгон шүүх хуралдааныг зохион байгуулах ёстой. Ийм үйл явц нь урт бөгөөд үр ашиг бага байдаг тул Конгресс албан ёсны хэм хэмжээ тогтоохыг ховор шаарддаг байна.

¹ APA §553(c); 15 U.S.C. §553(c)



Үүний нэгэн адил шүүхүүд «сонсгол» гэсэн хэллэгийг хатуу тайлбарлаж, хууль тогтоомжид «сонсгол» хийх шаардлагатай байсан ч «Албан ёсны» гэсэн дүрмийг дурдаагүй байсан ч байгууллагууд албан ёсны хэм хэмжээ тогтоох үйл явцыг ашиглах шаардлагагүй болно.²

Конгресс нь Захиргааны журмын тухай хуулийн хэм хэмжээг тогтооход мөрдөгдөж буй процедурын шаардлагуудыг нэмж оруулах замаар тодорхой агентлагуудад зориулсан Захиргааны журмын тухай хуульд буй хэм хэмжээг тогтоох үйл явцыг нэмж болно гэдгийг анхаарах хэрэгтэй.

Б. Албан бусаар хэм хэмжээг тогтоох үйл явц (Informal rulemaking process)

Албан бус, «мэдэгдэл, тайлбар» хэм хэмжээг тогтоох үйл явц нь үр нөлөө болон олон нийтийн ач холбогдолтой оролцоог дэмжих зорилготой юм.

Хэм хэмжээг тогтоох үйл явцын эхний алхам бол дэвшүүлж буй хэм хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх явдал юм. Мэдэгдэл нь холбооны засгийн газрын өдөр тутмын хэвлэл болох Холбооны Бүртгэлд (Federal Register) нийтлэгдсэн байх ёстой. Мэдэгдэлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цаг хугацаа, газар, шинж чанарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, санал болгож буй хэм хэмжээг батлах эрх бүхий байгууллагад олгосон хуулийн байгууллагын тодорхойлолт, санал болгож буй дүрмийн мөн чанар, холбогдох асуудлын тайлбарыг агуулсан байх ёстой.³ Хэрэв шинэ дүрэмд хамрагдах бүх хүмүүсийг нэрээр нь дурдаж, тэдгээр хүмүүс эсвэл компаниудад мэдэгдэл хүргүүлсэн бол хэм хэмжээг Холбооны Бүртгэлд нийтлэх шаардлагагүй.⁴

Холбооны департамент, агентлагууд норматив актын хувиар тушаал заавар, дүрэм, журам зэргийг батлан гаргана. Батлан гаргасан даруйдаа “Federal Register” хэмээх албан ёсны тогтмол хэвлэлд нийтлүүлэх ёстой болдог бөгөөд дараа нь тухайн актаа “Хуулиудын эмхэтгэл”-ийн тохирох гарчгийн дотор байрлуулах болно.⁵

Хэм хэмжээг тогтоох үйл явцын дараагийн үе шат бол олон нийтээс санал авах үе юм. Энэ хугацаанд санал болгож буй хэм хэмжээг сонирхож буй хүмүүс агентлагт бичгээр мэдээлэл, үзэл бодол, аргументыг ирүүлэх замаар үйл явцад оролцох боломжтой.⁶ Захиргааны журмын тухай хуулийн дагуу аргументыг амаар танилцуулах шаардлагагүй ч агентлагууд ихэвчлэн нээлттэй уулзалт зохион байгуулдаг бөгөөд сонирхогч талууд олон нийтэд танилцуулга хийх боломжтой байдаг. Нэмж дурдахад агентлагууд цахим

2 United States v. Florida East Coast R. Co., 410 U.S. 224,93 S. Ct. 810, 35 L. Ed. 2d 223 (1973).

3 APA §553(b); 15 U.S.C. §553(b)

4 APA §553(b); 15 U.S.C. §553(b)

5 Өрнөдийн улс орнуудын захиргааны эрх зүйн ерөнхий тойм- Ж.Сүхбаатар 2001 он, 60-р тал

6 APA §553(c); 15 U.S.C. §553(c)



харилцаа холбоогоор дамжуулан оролцоог ерөнхийд нь хангадаг болсон. Санал хүсэлтийг агентлагийн вэбсайтад байрлуулж болох бөгөөд ингэснээр талууд санал болгож буй дүрмийн талаарх маргаан, хариултыг хянах боломжтой болно.

Санал болгож буй дүрэмтэй холбоотой аливаа чухал дүгнэлт эсвэл өгөгдлийг агентлагууд олон нийтэд мэдээлэх ёстой бөгөөд ингэснээр тайлбар өгөхийг хүссэн хүмүүс ойлголттой, мэдээлэлтэй байх боломжтой болно.⁷ Хэрэв агентлаг шүүмжлэлтэй материалыг задруулахгүй эсвэл тайлбар өгөх хугацаа дууссаны дараа агентлаг шинэ материал олж мэдсэн бол олон нийтэд тайлбар өгөх боломж хангалтгүйн улмаас шүүх уг журмыг хүчингүй болгож болно.⁸ Хэдийгээр тухайн нөхцөл байдлаас шалтгаалах хэдий ч тайлбар өгөх хугацаа нь боломжит хугацаатай байх ёстой⁹

Агентлагууд олон нийтийн санал хүсэлтийн дагуу санал болгож буй хэм хэмжээг анхны хэвлэгдсэн хэлбэрээс нь өөрчилж болно. Гэсэн хэдий ч, агентлагууд дахин мэдэгдэл гаргах шаардлагагүй бөгөөд саналыг анхны хувилбараас нь өөрчилсөн ч нэмэлт тайлбар өгөх хугацааг зөвшөөрөхгүй байж болно. Хэм хэмжээг батлахаас өмнө олон нийтийг хамарсан мэдэгдэл, тайлбар хийх шаардлагатай тул шинэ тайлбар хийх хугацааг шаардах нь агентлагуудад олон нийтийн санал хүсэлтийг оруулахад саад учруулах болно. Тиймээс, өөрчлөлтийг санал болгож буй хэм хэмжээний логик үр дүн гэж үзвэл агентлаг шинэ мэдэгдэл, тайлбаргүйгээр үргэлжлүүлж болно.¹⁰

Мэдэгдэл, санал хүсэлтийг хүлээн авсны дараа, олон нийтийн танилцуулсан мэдээлэл, аргуудыг авч үзсэний дараа агентлаг санал болгож буй хэм хэмжээг баталж болно. Үүнийг хийхдээ баталсан хэм хэмжээний эцсийн хувилбарын нэг хэсэг болгон уг хэм хэмжээний үндэслэл, зорилгын талаарх мэдэгдлийг оруулах ёстой.¹¹ Мэдэгдэлд тайлбар өгөх хугацаанд олон нийтээс гаргасан ноцтой, материаллаг эсэргүүцлийг тусгаж, санал хүсэлтийн дагуу тавьсан асуудлыг хэрхэн авч үзэж, шийдвэрлэсэн талаар тайлбар өгөх ёстой.¹²

Хэм хэмжээг баталсны дараа түүнийг хүчин төгөлдөр болохоос гуч хоногийн өмнө Холбооны Бүртгэлд нийтлэх ёстой. Гэсэн хэдий ч зарим хэм хэмжээ нийтлэгдсэн даруйд хүчин төгөлдөр болно. Эдгээрт бодлогоос чөлөөлөгдөхийг хүлээн зөвшөөрсөн бодит дүрмүүд, хууль тогтоомжид заасан үгийн утгыг тайлбарлах тайлбарын дүрэм, агентлагууд тодорхой салбарт өөрийн үзэмжийг хэрхэн хэрэгжүүлэхийг тайлбарладаг бодлогын хэм хэмжээнүүд орно.¹³

7 See Chamber of Commerce v. SEC. AND EXCHANGE COM'N, 412 F.3d 133(D.C. Cir. 2005).

8 See Idaho Farm Bureau Federation v. Babbitt, 58 F.3d 1392(9th Cir. 1995).

9 Florida Power & Light Co. v. US, 846 F.2d 765(D.C. Cir. 1988).

10 Long Island Care at Home, Ltd. v. Coke, 551 U.S. 158,127 S. Ct. 2339, 168 L. Ed. 2d 54 (2007).

11 APA §553(c); 15 U.S.C. §553(c)

12 United States v. Nova Scotia Food Products Corp., 568 F.2d 240(2d Cir. 1977).

13 APA §553(d); 15 U.S.C. §553(d)



Хэм хэмжээ батлагдсаны дараа агентлагууд хэм хэмжээнд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хүсэлт гаргахыг сонирхогч этгээдэд зөвшөөрөх ёстой. Захиргааны журмын тухай хууль нь агентлагаас тодорхой арга хэмжээ авахыг шаарддаггүй; гэхдээ гагцхүү тухайн байгууллага татгалзсан үндэслэлийн талаар товч мэдэгдлийн хамт ийм өргөдлийг үгүйсгэсэн тухай мэдээллийг шуурхай өгөх ёстой. Ийм няцаалт нь үндэслэлтэй үндэслэлтэй, агентлаг нь баримталж буй баримт, бодлогыг “хангалттай тайлбарласан” тохиолдолд шүүхээр баталгаажуулдаг.¹⁴

Захиргааны зөрчлийн эсрэг давж заалдах эцсийн арга бол холбооны шүүхээс шүүхээр шийдвэрлүүлэх явдал юм. Хэрэв шүүх агентлагийн үйлдлийг үндсэн болон процедурын хувьд хүчин төгөлдөр бус гэж үзвэл уг хэм хэмжээг хууль бус гэж хүчингүй болгох ёстой.¹⁵ Эсвэл шүүх уг хэм хэмжээг хууль эрх зүйн хувьд асуудалтай байгаа асуудлыг дахин хэлэлцэхээр агентлагт буцаан өгч болох бөгөөд энэ нь агентлагт хууль ёсны арга хэрэгслээр хэм хэмжээг засаж, дахин батлах боломжийг олгодог.¹⁶

Шүүхүүд агентлагийн шийдвэрийг Захиргааны журмын тухай хуульд нийцэж байгаа эсэхийг хянаж болох ч шүүхүүд агентлагийн дүрэм тогтоох журамд Захиргааны журмын тухай хуульд зааснаас бусад процессын нэмэлт шаардлага тавьж болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.¹⁷ Энэхүү хязгаарлалтын шалтгаан нь агентлагууд тодорхой, урьдчилан таамаглах боломжтой хэм хэмжээтэй байх явдал юм. Хэрэв агентлагууд шүүхээс нэмэлт хэм хэмжээнд ногдуулахыг урьдчилан таамаглах ёстой бол агентлагууд өргөн хүрээтэй журам бүхий шүүх хуралдааныг илүү их зохион байгуулж, хууль тогтоох үйл явцыг үр ашиггүй болгох хандлагатай байдаг.

В. Мэдэгдэл болон тайлбарт тавигдах шаардлагаас үл хамаарах зүйлүүд (Exceptions to the notice and comment requirements)

Холбооны агентлагуудын гаргасан бодлогын бүх шийдвэрт засгийн газраас албан бус хэм хэмжээ тогтоох үйл ажиллагаанд оролцохыг шаарддаггүй. Агентлагийн зохион байгуулалт, журам, практикт хамаарах дүрэм нь Захиргааны журмын тухай хуульд мэдэгдэл, тайлбарын заалтыг дагаж мөрдөх шаардлагагүй. Эдгээрийг зүгээр л олон нийтэд мэдээлэх замаар баталж болно. Гэсэн хэдий ч, хэрэв процедурын дүрэм эсвэл бодлогын мэдэгдэл нь хууль ёсны бодит эрхэд нөлөөлсөн бол чөлөөлөх нь хамаарахгүй бөгөөд агентлаг хэм хэмжээ тогтоох үйл явцыг (Rulemaking) дагаж мөрдөх шаардлагатай болно.¹⁸

14 Arkansas Power & Light Co. v. ICC, 725 F.2d 716(D.C. Cir. 1984).

15 5 U.S.Code § 706.

16 Sugar Cane Growers Co-Op. of Florida v. Veneman, 289 F.3d 89 (D.C. Cir. 2002).

17 Vermont Yankee Nuclear Power Corp. v. Natural Resources Defense Council, Inc., 435 U.S. 519, 98 S. Ct. 1197, 55 L. Ed. 2d 460(1978).

18 United States Dept. of Labor v. Kast Metals Corp., 744 F.2d 1145(5th Cir. 1984).



Жишээлбэл, Хоол хүнс эмийн удирдлага (FDA) шинэ бодлого зарласан бөгөөд үүний дагуу үйлдвэрлэгчдийн ургуулсан эрдэнэ шиш дэх хортой бодисын хэмжээ тодорхой тоон хэмжээнээс доогуур байвал хүнсний үйлдвэрлэгчдийн эсрэг арга хэмжээ авахгүй байх тухай юм. Хоол хүнс эмийн удирдлага (FDA) үүнийг өөрийн үзэмжээр хэрэгжүүлэхтэй холбоотой бодлогын мэдэгдэл гэж үзсэн тул дүрмийг батлахаас өмнө тайлбар өгөх хугацаа өгөөгүй. Гэсэн хэдий ч DC-ын тойрох шүүх практикт шинэ бодлого нь FDA-ийн үзэмжийг зөвшөөрөхгүй хэрэгжүүлэх стандартыг тогтооно гэж үзсэн. Ийнхүү үнэн хэрэгтээ энэ нь мэдэгдэл, тайлбар хийх процессыг шаарддаг шинэ бодит дүрэм болсон юм.¹⁹

Захиргааны журмын тухай хууль нь сайн шалтгааны үл хамаарах зүйлийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд үүний дагуу агентлаг ийм үйл явц нь ашиггүй, шаардлагагүй эсвэл олон нийтийн ашиг сонирхолд харшлах гэж үзвэл мэдэгдэл, тайлбаргүйгээр бодлого гаргаж болно. Агентлаг тайлбар өгөх хугацаагүйгээр үргэлжлүүлэхээр шийдвэр гаргахдаа ямагт давуу байдлын шалтгааныг талаар тайлбарласан байх ёстой.²⁰ Хүндэтгэх шалтгаанаас үл хамаарах шалгуурыг хангаж чадах нэг төрлийн хэм хэмжээ нь онцгой байдлын үед эрүүл мэнд, олон нийтийн аюулгүй байдлын асуудлыг зохицуулах хэм хэмжээ байх бөгөөд энэ нь албан бус дүрэм тогтоох бүрэн шаардлагыг ашиглахгүйгээр үргэлжилж болно.²¹

Засгийн газар хууль тогтоомжийн заалтыг хэрэглэхгүйгээр үргэлжлүүлж болох хэд хэдэн онцгой тохиолдлуудыг Захиргааны журмын тухай хуульд мөн тусгасан. Үүнд цэргийн болон гадаад харилцаа засгийн газрын үйл ажиллагаанд оролцох нөхцөл байдал орно. Үүний нэгэн адил агентлагийн удирдлага, боловсон хүчин, төрийн зээл, тусламж, тэтгэмжтэй холбоотой асуудлууд Захиргааны журмын тухай хуулийн дүрэм тогтоох журмаас чөлөөлөгддөг.²² Сүүлчийн категорийн жишээ болгон, засгийн газар эмнэлгийн тусламжийн үйлчилгээний ангилалд хамаарах тул албан бусаар хэм хэмжээг тогтоох үйл ажиллагаа явуулахгүйгээр эмнэлгийн өвчтөнөөс авах төлбөрийг хязгаарлаж болно.²³

Г. Нэг талын төлөөх холбоо харилцаа (Ex Parte contacts)

Шүүхийн хэлэлцүүлэг нь шийдвэр гаргагчдын нэгдмэл бус байдлын талаарх хэм хэмжээг багтаасан шүүхийн төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа боловч хууль тогтоох үйл явц нь хэм хэмжээг тогтоох ажиллагаатай илүү төстэй бөгөөд шийдвэр гаргагчийн зан үйлийг хязгаарладаггүй.

19 Community Nutrition Institute v. Young, 818 F.2d 943(D.C. Cir. 1987).

20 APA §553(b)(3)(B)

21 Jifry v. FAA, 370 F.3d 1174 (D.C. Cir. 2004).

22 APA §553(a).

23 Humana of South Carolina, Inc. v. Califano, 590 F.2d 1070(D.C. Cir. 1978).



Үүний нэг жишээ бол хэм хэмжээг тогтоох үйл явцад оролцож буй гаднын талууд болон агентлагийн албан тушаалтнууд хоорондын харилцаа холбоог зөвшөөрөх явдал юм. Агентлагууд шүүн таслах ажиллагаа явуулж байх үед ийм *ex parte* холбоо барихыг хориглодог ч хэм хэмжээг батлах үед *ex parte* холбоо барихыг хориглодоггүй. Иймд, өөрөөр хориглоогүй бол сонирхогч талууд олон нийтийн бүртгэлд тайлбар өгөх хүрээнээс гадуур санал болгож буй хэм хэмжээний талаар агентлагийн албан тушаалтныг татан оролцуулж болно.

Гэсэн хэдий ч, хэм хэмжээг тогтооход *ex parte* холбоо барихыг зөвшөөрөх хязгаарлалт байдаг. Хэлэлцүүлгийн үр дүн нь хоёр талын маргааныг шийдвэрлэхтэй нягт холбоотой бол шүүх үүнийг шийдвэрлэхэд ойлтсон гэж үзэж болно. Ийм нөхцөлд нэг тал болон агентлаг хоорондын *ex parte* холбоо нь шүүхээс гарсан дүрмийг хүчингүй болгоход хүргэж болзошгүй²⁴.

Үүний нэгэн адил, хэрэв агентлагийн баталсан хэм хэмжээ нь олон нийтэд үр дүнд нөлөөлөх бодит боломж хомс байсан нам болон холбооны агентлаг хоорондын хэлэлцээрийн үр дүн гэж үзвэл уг хэм хэмжээг шүүхээр эсэргүүцэж болно²⁵. *Ex parte* харилцах харилцааны шударга бус үр дагаврыг арилгахын тулд зарим агентлаг дүрэм боловсруулах явцад ямар нэгэн холбоо барих мэдээллийг олон нийтэд ил болгохыг шаарддаг.

Д. Бусад хэм хэмжээг тогтоох үйл ажиллагаа (Other rulemaking procedures)

Хуульд санал болгож буй хэм хэмжээний дагуу тэмдэглэлийг сонсох шаардлагатай гэж заасан бол албан ёсны хэм хэмжээ тогтооход зориулсан Захиргааны журмын тухай хуулийн заалтууд хэрэгжинэ. Албан бус хэм хэмжээ тогтоохын нэгэн адил албан ёсны хэм хэмжээ тогтоох үйл ажиллагаа нь санал болгож буй дүрмийг Холбооны бүртгэлд нийтлэхээс эхэлдэг бөгөөд уг дүрмийн мөн чанарыг тайлбарлаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэзээ, хаана явагдах талаар дэлгэрэнгүй бичсэн байдаг.²⁶

Санал өгөх хугацааны оронд албан ёсны хэм хэмжээг тогтоох үйл явц нь хэм хэмжээг батлах эсэхийг тодорхойлохын тулд шүүх хэлбэрийн сонсголыг шаарддаг. Ийм шүүх хуралдаанд Захиргааны хэргийн шүүгч эсвэл бусад даргалагч байгууллагын төлөөлөгч нь шүүх хуралдааныг хөнгөвчлөх, тухайлбал шүүх хуралдаанд дуудах хуудас өгөх, нотлох баримтын асуудлаар шийдвэр гаргах, аливаа маргааныг маргааныг өөр аргаар шийдвэрлэхийг оролдохыг талуудаас шаардах эрхтэй.²⁷

24 Sangamon Valley Television Corp. v. United States, 269 F.2d 221(D.C. Cir. 1959).

25 Home Box Office, Inc. v. FCC, 567 F.2d 9(D.C. Cir. 1977).

26 APA §553(b).

27 APA §556(c).



Хэргийн оролцогчид хэргээ бататгах, эсхүл нотлох баримтыг үгүйсгэх, гэрчээс байцаалт авах зорилгоор аман болон баримтат нотлох баримт гаргаж өгөх эрхтэй.²⁸ Бүх нотлох баримт, мэдүүлэг, мэдүүлэг нь албан ёсны тэмдэглэлийн нэг хэсэг болж, тэргүүлэгч нь хэм хэмжээг батлах эсэх талаар шийдвэр гаргах үндэслэл болдог. Шийдвэр нь дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийн хамт тус агентлагийн шийдвэрийг шүүхээр хянуулах боломжтой тэмдэглэлийн нэг хэсэг юм.²⁹ Эцэст нь, албан бусаар хэм хэмжээг тогтоохоос ялгаатай нь албан ёсны хэм хэмжээ тогтоох явцад *ex parte* холбоо барихыг зөвшөөрдөггүй.³⁰

Конгресс мөн агентлагийн хэм хэмжээ тогтооход зориулж тохиролцсон хэм хэмжээ гаргах гэж нэрлэгддэг өөр нэг аргыг өгсөн. Энэ үйл явцад агентлаг сонирхогч талуудыг агентлагийн төлөөлөгчидтэй хамтран шинэ хэм хэмжээ боловсруулахад урьж болно. Жишээлбэл, агентлагууд хэм хэмжээнд нөлөөлөх хязгаарлагдмал тооны ашиг сонирхол байгаа тохиолдолд хэлэлцээрийн дагуу хэм хэмжээг тогтоох ажлыг явуулж болох бөгөөд агентлаг нь эдгээр ашиг сонирхлыг зохих ёсоор төлөөлж чадах хүмүүсээс бүрдсэн хороог хуралдуулж чадна гэж үзэж байна.³¹ Тиймээс олон нийтийг хамарсан хэм хэмжээг хэлэлцэхээс өмнө хэлэлцээ хийх нь шинэ хэм хэмжээг хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлж, эцсийн үр дүнд хүрэх хугацааг богиносгодог.

Хэрэв агентлаг ийм замаар явах юм бол Холбооны бүртгэлд тохиролцсон хэм хэмжээг батлах тухай мэдэгдлийг нийтлэх ёстой, үүнд санал болгож буй хорооны дэлгэрэнгүй мэдээлэл, түүнчлэн хэлэлцээрийн үйл явцын хэлэлцэх асуудал, цагийн хуваарь багтана. Дараа нь санал болгож буй зөвшилцсон хэм хэмжээг боловсруулах болон хорооны бүрэлдэхүүний нарийн ширийнийг авч үзсэн 30 хоногийн олон нийтийн санал хүсэлтийн процесс явагдана.³²

Хэрэв хороо санал болгож буй хэм хэмжээний нөхцөлийн талаар тохиролцоонд хүрвэл түүнийг Холбооны Бүртгэлд санал болгож буй хэм хэмжээний дагуу нийтлэх ба ердийн мэдэгдэл, тайлбар хийх процесс үргэлжилнэ. Хорооноос зөвшөөрсөн хэм хэмжээний саналыг агентлагууд санал болгож, батлах үүрэг хүлээхгүй гэдгийг анхаарна уу. Агентлаг нь хэлэлцээ хийсэн хэм хэмжээг батлах үйл явцыг хэрэгсэхгүйгээр, хэлэлцээний үйл явц дууссаны дараа өөр хэм хэмжээг санал болгох эрхтэй бөгөөд дараа нь бусад хэм хэмжээг тогтоох журмаар санал болгож болно.³³

Холбооны хэм хэмжээ тогтоох үйл ажиллагааны үе шат

28 APA §556(d).

29 APA §556(e), APA §557(c).

30 APA §557(d).

31 5 U.S.C. §§ 561-570.

32 5 U.S.C. §§ 561-570.

33 USA Group Loan Services, Inc. v. Riley, 82 F.3d 708(7th Cir. 1996).



Конгресс хэм хэмжээг баталлаа.

Нэгдүгээр алхам: Агентлаг санал болгож буй хэм хэмжээний төслийг боловсруулдаг.

Хоёрдугаар алхам: Санал болгож буй хэм хэмжээний төслийг агентлаг хянадаг/баталдаг.

Гуравдугаар алхам: Удирдлага, төсвийн газрын Мэдээлэл, зохицуулалтын газар (OIRA) санал болгож буй хэм хэмжээний төслийг хянан үзэж байна.

Дөрөвдүгээр алхам: Захиргааны журмын тухай хуулийн (APA) шаардлагын дагуу санал болгож буй хэм хэмжээг батлах тухай мэдэгдлийг Холбооны бүртгэлд нийтэлдэг.

Тавдугаар алхам: Олон нийтийн санал хүсэлтийг дор хаяж 30 хоногийн хугацаатай нээнэ.

Зургаадугаар алхам: Агентлаг санал хүсэлтийг хянана/ эцсийн хэм хэмжээний төслийг боловсруулна.

Долдугаар алхам: Агентлаг нь агентлаг дотроо хэм хэмжээний эцсийн төслийг батална.

Наймдугаар алхам: Эцсийн хэм хэмжээний төслийг Удирдлага, төсвийн газрын Мэдээлэл, зохицуулалтын газар (OIRA) хянаж баталдаг.

Есдүгээр алхам: Эцсийн хэм хэмжээг Холбооны бүртгэлд нийтэлсэн.

Аравдугаар алхам: Хэм хэмжээ хэрэгжиж байна.³⁴

E-rulemaking- Цахим захиргааны хэм хэмжээ тогтоох үйл ажиллагаа

Цахим захиргааны хэм хэмжээ тогтоох үйл ажиллагаа (мөн eRulemaking болон e-rulemaking гэгддэг) нь АНУ-ын хууль тогтоох, шийдвэр гаргах үйл явцад төрийн байгууллагууд дижитал технологийг ашиглах явдал юм. Дижитал засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд Үндэсний Шинжлэх Ухааны Сангийн санхүүжилтийн үр дүнд салбар дундын цахим хэм хэмжээ тогтоох судалгааны нийгэмлэг байгуулагдав. Корнеллийн цахим хэм хэмжээ тогтоох санаачилга (CeRI) зэрэг бүлгүүд Веб 2.0 зэрэг технологи нь улс төрийн үйл явцад, ялангуяа Холбооны агентлагуудын хэм хэмжээ боловсруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд хэрхэн тусалж болохыг судлахад анхаарлаа хандуулсан.

Агентлагуудыг хэм хэмжээг тогтоохдоо илүү болгоомжтой, нарийн ширийн болгох нэг арга зам бол цахим хэм хэмжээ тогтоох буюу «ERulemaking»-ыг бий болгоход ашиглагдаж байгаа интернэт буюу магадгүй урьд өмнө нь хөгжсөн

34 Maeve Carey *2013), "The Federal Rulemaking Process: An Overview," Congressional Research Service.



хамгийн нөлөө бүхий хэрэглүүр байж болох юм. Цахим хэм хэмжээ тогтоох хувьсгал нь үр дүнд хүргэнэ гэж тэд өөдрөгөөр харж байна

Энэ нь илүү сайн мэдээлэлтэй олон нийт төдийгүй бид бүгдэд илүү ээлтэй үйл явц юм. Цахим хэм хэмжээ гаргах нь АНУ-ын хотын жирийн иргэн хууль батлахтай холбоотой бүх чухал баримт бичгүүдэд хулганы товшилтоор хандах боломжтой болгосноор энэ үйл явцыг аль хэдийн ардчилсан болгосон. Арван жилийн өмнө бол Вашингтоны хуулийн фирмийг хөлсөлж, агентлагийн тасалгаанд очиж, цаасан дээрх бичиг баримтуудыг унших шаардлагатай байв. Энэ нь Вашингтоны хуульчдын хувьд хамгийн үр өгөөжтэй хөгжил биш байж болох ч олон нийтийн байр сууринаас харахад энэ нь маш том ашигтай тал байж магадгүй юм. Холбооны засгийн газрын төвлөрсөн дүрэм тогтоох портал (www.regulations.gov) сайжирснаар сэтгэгдэл үлдээгчид санал бодлоо илэрхийлэх нь илүү үр дүнтэй болох ёстой. 10 жилийн дараа хууль тогтоох байгууллагуудад цаасан тайлбар өгөх нь бидний шуудангийн хайрцагт байдаг нэгдүгээр зэрэглэлийн захидал шиг ховор байх болно. Гэхдээ эдгээр хөгжил нь тодорхой ашиг тусын зэрэгцээ зарим эрсдэлийг авчрах болно. Агентлагууд «мэдэгдэл, спам»-д автах уу? Тайлбарыг төрөл, сэдвээр нь ангилах технологи нь нэг талаас сайн санхүүждэг компьютероор бий болгосон тайлбарын машинууд, нөгөө талаас агентлагууд дахь компьютерын тусламжтай тайлбар ангилагчдын хооронд технологийн уралдаанд хүргэх үү?³⁵ Конгрессын оффисууд урьдчилан сэргийлэх арга техникийг аль хэдийн ашиглаж байна

дүүргийн гаднах хүсээгүй цахим шуудан. Энэ нь агентлагуудад ч тархаж болох уу?³⁶

Түүнчлэн цахим хэм хэмжээ гаргах нь хууль эрх зүйн болон техникийн олон сорилтуудыг дагуулдаг бөгөөд Техникийн тал дээр би дараах сорилтуудыг дурдах болно.

Хандалтын асуудал: Хэм хэмжээг бий болгоход чухал ач холбогдолтой алхам бүрийг олон нийтэд хүртээмжтэй болгох арга замыг хайж олох - Конгрессоос баталсан хэм хэмжээг эхлээд агентлагийн хамгийн анхны арга хэмжээ (магадгүй «санал болгож буй хэм хэмжээг батлах тухай урьдчилсан мэдэгдэл») хүртэл. үйл явцын сүүлчийн алхам - энэ нь эцсийн хэм хэмжээ, шүүхийн давж заалдах шатны шийдвэр, эсвэл дараа нь агентлагийн нэмэлт өөрчлөлт, тайлбар, удирдамж, хэрэгжүүлэх арга хэмжээ байх эсэх.³⁷

35 For a technical paper describing promising techniques for sorting comments, see Hui Yang, Jamie Callen & Stuart Shulman, Next Steps in Near Duplicate Detection for eRulemaking, Proceedings of the Fifth National Conference on Digital Government Research (2005), available at <http://erulemaking.ucsur.pitt.edu/doc/papersdgo05-huiyang.pdf>.

36 The Transformation of the U.S. Rulemaking Process - For Better or Worse Jeffrey Lubbers American University Washington College of Law, jlubbers@wcl.american.edu

37 The Transformation of the U.S. Rulemaking Process - For Better or Worse Jeffrey Lubbers American University Washington College of Law, jlubbers@wcl.american.edu



Хууль эрх зүйн асуудал: Нэгдүгээрт, архивын шаардлагад асуудал гарч болзошгүй.

Холбооны архивын улмаас цаасан хуулбарыг хадгалах шаардлагатай.³⁸ Хоёрдугаарт, хавсралтуудыг бас авч үзэх хэрэгтэй. Үзэсгэлэн, маягт, гэрэл зурагтай хэрхэн харьцах ёстой вэ? Хавсралтууд нь вирус болон системийг хэт ачаалах эрсдэлтэй. Цахим технологи нь сэтгэгдэл бичигчдэд цахим сэтгэгдэл доторх асар том файл эсвэл холбоосыг «хаягдах» боломжийг нэмэгдүүлдэг. Гуравдугаарт, зохиогчийн эрхийн асуудал их байна.³⁹

Олон нийтийн санал хүсэлтийг Вашингтон ДС-д амархан хянагддаг биет файлаас интернэтэд нэвтрэх боломжтой дижитал баримт бичиг болгон хувиргаснаар зохиогчийн эрхийн асуудал гэнэт илүү чухал болж байна - илгээгч нь сэтгэгдлийн зохиогчийн эрхийг эзэмшигч мөн хэн нэгний зохиогчийн эрхээр хамгаалагдсан бүтээлийг ашигласан тохиолдолд аль аль нь зөвшөөрөлгүйгээр. Засгийн газар «Өөрийнхөө зохиогчийн эрхээр хамгаалагдсан материалыг ирүүлэх нь эдгээр материалыг дотоод хэлэлцүүлэгтээ ашиглаж болно гэсэн далд итгэлтэй» гэсэн байр суурийг баримталж болох тул өмнөх нөхцөл байдал харьцангуй асуудалгүй мэт санагдаж байна. Хэм хэмжээг тогтоох, боловсруулах үйл явц нь өөрөө хууль тогтоох үйл явцад үзүүлэх нөлөөллийн олон нийтийн оролцоо нэмэгдэж байгаагийн нөгөө тал нь мэдээжийн хэрэг, илүү их сэтгэгдлийг хүлээн авах, хариу үйлдэл үзүүлэх агентлагуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх явдал юм. Маргаантай хэм хэмжээ боловсруулахад санал шүүмжлэл улам бүр түгээмэл болж байгаа бөгөөд цахим хэм хэмжээ гаргах нь энэ чиг хандлагыг улам бүр нэмэгдүүлнэ. Энэ нь «мэдээллийн хэт ачаалал»-д хүргэж болзошгүй юм. Энэ нь хууль тогтоох үйл явцыг ерөнхийд нь улстөржүүлэхэд хүргэж болзошгүй юм.⁴⁰

Дүгнэлт, зөвлөмж

Эрдэм шинжилгээний өгүүлэл нь үндэсний болон олон улсын эрх зүйн түвшний онол, практикийн хувьд тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны онол, арга зүй үүднээс шийдвэрлэх арга замыг тодорхойлон шийдвэрлэх, түүний ололтыг амьдралд нэвтрүүлэх зорилготой байдаг.

АНУ-ын захиргааны эрх зүйн захиргааны хэм хэмжээг тогтоох үйл ажиллагааг судалснаар олон улсын түвшний онолын ойлголт болон практикийн тулгамдсан асуудлыг судалж Монголын захиргааны харьцуулсан

38 See National Archives & Records Administration, Implementation of the E-Government Act of 2002 (Dec. 6, 2004), available at <http://www.archives.gov/about/plans-reports/e-gov>.

39 The Transformation of the U.S. Rulemaking Process - For Better or Worse Jeffrey Lubbers American University Washington College of Law, jlubbers@wcl.american.edu

40 The Transformation of the U.S. Rulemaking Process - For Better or Worse Jeffrey Lubbers American University Washington College of Law, jlubbers@wcl.american.edu



эрх зүйн хүрээнд өөрийн хувь нэмрийг оруулахыг зорьсон билээ.

Захиргааны агентлагийн бүх үйл ажиллагааг гүйцэтгэх эрх мэдлийн, шүүх маягийн (quasi-judicial), хууль тогтоох маягийн (quasi-legislative) гэж ангилж болно. Шүүх маягийнх нь шүүхийн хүрээнд шүүгч (adjudicatory) -д хамаарах зан үйл бүхийн агентлагийн актууд юм. Хууль тогтоох маягийнх нь хууль тогтоох үүргийн хүрээнд захиргааны хэм хэмжээ бүтээхэд хамаарах зан үйл бүхий үүрэг гүйцэтгэж буй байдал юм. Аль чиг үүргийг гүйцэтгэж байгаагаас хамааран Захиргааны процессийн хуулиар хүлээлгэх үүрэг хариуцлага ялгаатай тул хэрэг хянан шийдвэрлэх ба эрх зүйн хэм хэмжээ бүтээх ажиллагааны алин болохыг ялгаж зааглах нь чухал. Агентлагт хэм хэмжээний акт гаргах эрхийг шилжүүлдэг. Америкийн Нэгдсэн Улсад захиргааны хэм хэмжээний акт нь хуулийн хүчин чадалтай үйлчилдэг тул Rulemaking-г хууль тогтоох үйл ажиллагаатай адил авч үзэж болно. Захиргааны хэм хэмжээг тогтооход Монгол улсад цахим хэмжээг тогтоох зохицуулалт буюу цахим портал сайт байхгүй харин хуулийн төслийн санааг lawforum.parliament.mn сайтаар авдаг байна. Уг сайтыг илүү боловсронгуй болгож олон нийтийн санал авахад дөхөм болгох сайтын хөгжүүлэлт хийх шаардлагатай байна. Олон улсын түвшинд хууль, журам, актын төслийг цахим хэлбэрээр боловсруулж санал асуулга авч илүү боловсронгуй болоод нэлээдгүй олон жилийг өнгөрөөж байна.

Гэсэн хэдий ч цахим санал, асуулга болон eulemaking нь сайн тал болон ойлгомжгүй асуудал болон техник, хууль эрх зүйн хүрээнд зохицуулагдаагүй асуудлууд ч өнөөг хүртэл байгаа юм. Сайн төрийг бүтээхийн төлөө буй хуульчдын хувьд бид дараах хоёр үндсэн зорилгыг анхаарч үзэхийг санал болгож байна: (1) хууль тогтоох үйл ажиллагаанд хуучинсаг байдлыг багасгах, (2) Зөвлөлдөх ардчилал⁴¹ буюу олон нийтийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд цахим хэм хэмжээ боловсруулах боломжийг оновчтой болгох.

III. НОМ ЗҮЙ

I. Монгол эх сурвалж

1. Өрнөдийн улс орнуудын захиргааны эрх зүйн ерөнхий тойм-Ж.Сүхбаатар 2001 он, 60-р тал

II. Гадаад эх сурвалж

1. APA §553(c); 15 U.S.C. §553(c)
2. United States v. Florida East Coast R. Co., 410 U.S. 224, 93 S. Ct. 810, 35 L. Ed.

⁴¹ See David Schlosberg, Stephen Zavestoski, & Stuart W. Shulman, Democracy and eRulemaking: Web-Based Technologies, Participation, and the Potential for Deliberation, 4 J. INFO. TECH. & POLITICS 37 (2007).



- 2d 223 (1973).
3. See *Chamber of Commerce v. SEC. AND EXCHANGE COM'N*, 412 F.3d 133(D.C. Cir. 2005).
 4. *Idaho Farm Bureau Federation v. Babbitt*, 58 F.3d 1392(9th Cir. 1995).
 5. *Florida Power & Light Co. v. US*, 846 F.2d 765(D.C. Cir. 1988).
 6. *Long Island Care at Home, Ltd. v. Coke*, 551 U.S. 158,127 S. Ct. 2339, 168 L. Ed. 2d 54 (2007).
 7. *United States v. Nova Scotia Food Products Corp.*, 568 F.2d 240(2d Cir. 1977)
 8. *Arkansas Power & Light Co. v. ICC*, 725 F.2d 716(D.C. Cir. 1984).
 9. 5 U.S.Code § 706.
 10. *Sugar Cane Growers Co-Op. of Florida v. Veneman*, 289 F.3d 89 (D.C. Cir. 2002).
 11. *Vermont Yankee Nuclear Power Corp. v. Natural Resources Defense Council, Inc.*, 435 U.S. 519, 98 S. Ct. 1197, 55 L. Ed. 2d 460(1978).
 12. *United States Dept. of Labor v. Kast Metals Corp.*, 744 F.2d 1145(5th Cir. 1984).
 13. *Community Nutrition Institute v. Young*, 818 F.2d 943(D.C. Cir. 1987).
 14. *Jifry v. FAA*, 370 F.3d 1174 (D.C. Cir. 2004).
 15. *Humana of South Carolina, Inc. v. Califano*, 590 F.2d 1070(D.C. Cir. 1978).
 16. *Sangamon Valley Television Corp. v. United States*, 269 F.2d 221(D.C. Cir. 1959).
 17. *Home Box Office, Inc. v. FCC*, 567 F.2d 9(D.C. Cir. 1977).
 18. *USA Group Loan Services, Inc. v. Riley*, 82 F.3d 708(7th Cir. 1996).
 19. Maeve Carey *2013), "The Federal Rulemaking Process: An Overview," Congressional Research Service.
 20. For a technical paper describing promising techniques for sorting comments, see Hui Yang, Jamie Callen & Stuart Shulman, *Next Steps in Near Duplicate Detection for eRulemaking*, Proceedings of the Fifth National Conference on Digital Government Research (2005), available at <http://erulemaking.ucsur.pitt.eduldoc/papersdgo05-huiyang.pdf>.
 21. *The Transformation of the U.S. Rulemaking Process - For Better or Worse* Jeffrey Lubbers American University Washington College of Law, jlubbers@wcl.american.edu



22. National Archives & Records Administration, Implementation of the E-Government Act of 2002 (Dec. 6, 2004), available at <http://www.archives.gov/about/plans-reports/e-gov>.
23. See David Schlosberg, Stephen Zavestoski, & Stuart W. Shulman, Democracy and ERulemaking: Web-Based Technologies, Participation, and the Potential for Deliberation, 4 J. INFO. TECH. & POLITICS 37 (2007).

III. ХАВСРАЛТ

[ТОВЧ УТГА]

АНУ-ын захиргааны эрх зүйд захиргааны хэм хэмжээ тогтоох гэдэг нь захиргааны байгууллагуудын хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгон нийтээр дагаж мөрдөх заавал дагаж мөрдөх хэм хэмжээг батлах үйл явцыг хэлдэг байна. Захиргааны хэм хэмжээ тогтоох үйл ажиллагаа нь шинэ үзэгдэл биш гэдгийг хамгийн түрүүнд онцлон тэмдэглэхийг хүсэж байна. Уг судалгааны ажлаар дэд сэдвүүдийг дэлгэрүүлэн АНУ-ын захиргааны эрх зүйн хэм хэмжээ тогтоох үйл ажиллагааг үйл явц, шат тус бүрд нь дэлгэрүүлэн авч үзэн судалж, дүгнэхийг зорьсон билээ. Захиргааны хэм хэмжээг заримдаа дүрэм, журамтай хамтад нь тайлбарладаг. Шүүхийн шийдвэрээс ялгаатай нь буцаан хэрэглэж болох бөгөөд хамрах хүрээ нь хязгаартай байдаг ба захиргааны хэм хэмжээ тогтоох нь (Rulemaking) хууль тогтоох чиг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь хэтийн төлөвтэй бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагддаг өргөн хүрээний ойлголт юм. Мөн түүнчлэн цахим захиргааны хэм хэмжээ тогтоох үйл ажиллагаа (мөн eRulemaking болон e-rulemaking гэгддэг) нь АНУ-ын хууль тогтоох, шийдвэр гаргах үйл явцад төрийн байгууллагууд дижитал технологийг ашиглах явдал юм. Тус сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй судалгаа бичлэг ховор тул уг сэдвийн хүрээнд судалгаа хийх шаардлагатай байна.

[ТҮЛХҮҮР ҮГС]

Албан хэм хэмжээг тогтоох, албан бусаар хэм хэмжээг тогтоох, мэдэгдэл болон тайлбар, цахим хэм хэмжээ тогтоох, олон нийтийн оролцоо

**[ABSTRACT]**

In US administrative law, administrative rulemaking refers to the process of adopting generally binding rules as a means for administrative agencies to exercise their statutory authorities. First of all, I would like to emphasize that administrative norm-setting is not a new phenomenon. In this research work, it was intended to study and evaluate the activities of setting the norms of administrative law in the United States by expanding the sub-topics in each process and stage. Administrative norms are sometimes interpreted together with rules and regulations. Unlike judicial decisions, which can be applied retroactively and are limited in scope, administrative rulemaking (Rulemaking) performs a legislative function, a broad concept used to implement prospective policies. Also, e-government rulemaking (also known as eRulemaking and e-rulemaking) is the use of digital technology by government agencies in the US lawmaking and decision-making process. Detailed research on this topic is rare, so it is necessary to conduct research on this topic.

[KEYWORDS]

Rulemaking, Informal rulemaking, ERulemaking, Notice and comment, Public participation



ГУРАВДУГААР ХЭСЭГ

ИЛТГЭЛ |



“Шүүхийн шинэтгэл ба олон нийтийн шүүхэд итгэх итгэл”



*Д.Зүмбэрэлхам
Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн,
Хүндэт доктор, профессор*

Олон Улсын Бага Хурлыг хамтран зохион байгуулж байгаа болон тус бага хуралд хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт зочид төлөөлөгчид та бүхний энэ өглөөний амгаланг эрье.

Өнөөдөр бид шүүх эрх мэдлийн алсын харааг тодорхойлсон маш чухал сэдвээр энэ бага хурлыг зохион байгуулж байна. Үндсэндээ энэ сэдвийн дор Ази, Европ, Америк тивийн улс орнуудын туршлага солилцох өргөн боломж олгож байгаад маш таатай байна. Бид нар Европын Холбоотой, Канад улстай шүүх эрх мэдлийн шинэтгэлийн талаар цаашид ч хамтран ажиллах сонирхолтой байгаа. Энэ хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ гэж найдаж байна. Бидий хамтын ажиллагаа Монгол Улсын шүүх ямар замнал туулж ирсэн бэ гэдэг бодит дүр зураг дээр тулгуурлаж яривал илүү ач холбогдолтой болно гэж үзээд энэхүү замналыг товчхон харуулсан илтгэл тавих гэж байгаа юм.

Монгол Улсад орчин үеийн хэв шинжтэй шүүх хэдийнээс эхэлж бүрдсэн талаар:

НЭГ. ШҮҮХ БҮРЭЛДЭН ТОГТСОН ҮЕ ШАТ

Монгол Улсад орчин үеийн төрхтэй шүүх байгуулагдсаныг хоёр зууныг дамжин үргэлжилсэн манжийн ноёрхлыг монголчууд түлхэн унагаж тусгаар тогтносон хаант улс болсноо зарлан тунхагласан 1911 оноос тооцох үндэстэй гэдгийг ихэнх судлаач, эрдэмтэд одоо хүлээн зөвшөөрдөг болсон байна. Энэ онд байгуулсан Засгийн газрын анхны таван яамны нэг нь “Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх яам” байжээ. Хожим 1918 онд баталсан “Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичиг”-т уг яамыг “Шүүх таслах яам” хэмээн нэрлээд бүтцийн хувьд “шүүх”, “ариутгах” гэсэн хоёр хэлтэстэй байхаар засан бөгөөд шүүх хэлтэс нь аливаа зарга, хэргийг мөрдөн шалгаж ариутгах хэлтэст шилжүүлэх ба ариутгах хэлтэс нь хэргийг шүүж эцэслэн шийдвэрлэх чиг үүрэгтэйгээр тодорхойлон энэ дагуу хэрэгжүүлж байжээ.¹

1 Хууль зүй дотоод хэргийн яам, Монгол Улсын хууль зүйн алба, тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 2011



Энд дурдагдаж байгаа “Хууль зүйлийн бичиг” бол тухайн үедээ Богд хаант Монгол Улсын үндсэн хуулийн дайны ач холбогдолтой эрх зүйн гол баримт бичиг байсан гэдгийг зарим эрдэмтэд тэмдэглэсэн байдаг. Агуулгаас нь үзэхэд энэ хуулийг батлан гаргахдаа Манж Чин Улсын эрх зүйн тогтолцоог халах, хууль цаазын монгол уламжлалаа сэргээх, эх газрын эрх зүйн ололт, европ маягийн төрийн зохион байгуулалтын дэвшлийг авч нутагшуулах ерөнхий том зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн нь тодорхой байдаг.

1921 онд Монгол оронд ардын хувьсгал өрнөж засгийн дээд эрхийг Ардын засгийн газарт шилжүүлэн таван яам байгуулсны нэг нь “Шүүх яам” байв. Улмаар 1924 онд хаант засаглалыг халж, төрийн бүх эрх мэдлийг ардын засагт шилжүүлэн авсны дараа нийтийн засаглалын тогтолцоог баталгаажуулсан анхны Үндсэн хуулиа баталсан юм. Энэхүү үндсэн хуульд Засгийн газрын бүтцэд Шүүх яам байх тухай дурдагдсан бөгөөд энэ дагуу шүүн таслах ажиллагааг Ардын засгийн газрын Шүүх яам хариуцан эрхэлж байжээ.²

Дараа нь батлан гаргасан 1940³, 1960⁴ оны үндсэн хуулиудад БНМАУ-д шүүн таслах ажлыг зөвхөн шүүх хэрэгжүүлэхээр заасан нь дэвшилттэй, чухал ач холбогдолтой болсон боловч 1992 оныг хүртэл засаглалын эрх мэдлийг хуваарилж хэрэгжүүлэх тогтолцоо бүрдээгүй байсан учраас төрийн эрх мэдлийн хэмжээнд шүүхийг тавьж байгаагүй гэдгийг тодотгож тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ энэ үе шатанд төр, засгийн бодлогын хүрээнд шүүхийн хөгжлийг чухалчилж, шүүхийг харьцангуй бие даалгах, тогтолцооны хувьд бэхжүүлэх, шүүгчдийг сурган бэлтгэх, шүүн таслах үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх чиглэлээр шат дараатай тасралтгүй арга хэмжээ авч байсныг үйл явдлын түүхэн товчооноос харж болно.

Ерөнхий агуулгаар нь 1911-1992 оныг хүртэл манай улсад төрийн бие даасан эрх мэдлийн хэмжээнд шүүхийн тогтолцоог нь авч үзэх эрх зүйн орчин бүрдээгүй байсан учир үндсэндээ гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд багтан, харьцангуй бие даасан хэлбэртэйгээр үл ажиллагаа нь явагдаж байсан гэж дүгнэх боломжтой. Иймд шүүхийн хөгжлийн түүхийн энэ хэсгийг бүхэлд нь бие даасан шүүх эрх мэдлийн өмнөх буюу орчин үеийн хэв шинжтэй шүүх үүсэж, бүрэлдэн тогтсон үе шат гэж тодорхойлж болох юм.

Орчин үеийн шүүх үүсэж хөгжсөн эхний үе шатанд шүүх, шүүхийн захиргааны хувьд зааг багатай, шат шатны шүүхүүд удирдлагын босоо тогтолцоотой байсан боловч, анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхүүд байгуулагдаж, шүүх байгууллагын хувьд төрөлжин, зөвхөн хуулиар байгуулагдсан шүүх шүүн таслах ажиллагаа явуулж хэрэг маргааныг шийдвэрлэх зарчим төрийн тогтолцоонд бүрэлдсэн нь гол үр дүн байв.

2 <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1924.html>

3 <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1940.html>

4 <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1960.html>



ХОЁР. ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ БҮРЭЛДЭН ТОГТОХ ШИЛЖИЛТИЙН ҮЕ ШАТ

Монгол оронд 1990 оноос өрнөсөн ардчилсан хувьсгалын үр дүнд хөгжлийн коммунист үзэл баримтлал, тоталитар дэглэмээс татгалзаж ардчилсан хөгжлийн замналыг сонгох түүхэн үйл явдал болсон бөгөөд үүний үр дүнд хүний эрх, үндсэн эрх чөлөө, түүний баталгааг хангахад суурилсан шинэ үндсэн хуулийг 1992 онд баталсан. Энэхүү үндсэн хуульд анх удаа төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг тусгаснаар шүүхийн хөгжлийн түүхийн нэн шинэ үеийг эхлүүлсэн юм.

Үндсэн хуулийн “Монгол Улсын бүрэн эрхт байдал” гэсэн хамгийн эхний бүлэг нь “2.Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж эхэлдэг.⁵ Ардчиллыг шударга ёсноос, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангахаас, хууль дээдлэх зарчмаас ангид хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг гүн ухааны сэтгэгчид, мэргэд сургадаг. Энэ нь бодитой үнэн гэдгийг хүн төрөлхтний түүх бидэнд бэлээхэн харуулж байна.

Одоогоор хүмүүний нийгэмд хамгийн ээлтэй буюу хүмүүнлэг нь гэж дэлхийн олон орон сонгон замнаж байгаа ардчилсан ёсны нэгээхэн гол баталгаа бол бие даасан, шударга шүүхтэй байх явдал юм. Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн Хоёрдугаар бүлэг “1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж эхэлдэг нь чухамдаа шүүх болон шударга ёсонд итгэх олон нийтийн итгэлтэй холбоотой. Энэ бүлэгт цааш нь “14/...шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах,.. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.”⁶ гэх зэргээр хүний эрхийн баталгааг шууд шүүхтэй холбож заасныг шүүх бие даасан эрх мэдлийн хэмжээнд байх гол үндэслэл гэж үзэх боломжтой.

Дараа нь шүүхтэй холбоотой Үндсэн хуулийн хамгийн чухал нь “Шүүх эрх мэдэл” гэсэн хэсэг юм. Энэ талаар Дөчин долоодугаар зүйлд “1.Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. 2.Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно. 3.Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.” гэж заасан. Шүүхийг төрийн эрх мэдлийн бие даасан салаа болгож Үндсэн хуулиар баталгаажуулсан анхны тохиолдол нь энэ бөгөөд чухамдаа шүүхийн хөгжлийн хоёр дахь үе шатыг 1992 онд баталсан Үндсэн хуулиас эхтэй гэж үчилж байгаа үндэслэл нь үүнтэй холбоотой.

Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлд “1.Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. 2.Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан

5 <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1992.html>

6 <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1992.html>



тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.” гэсэн байдлаар шүүгчийн хараат бус байдлын үндсэн баталгаа туссан байдаг.

Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлд “3.Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана. 4.Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.” хэмээн шүүхийн захиргаа шүүн таслах ажиллагаанаас зарчмын хувьд заагтай байхыг тодорхойлсон.

Шүүх, шүүгч, шүүхийн захиргааны талаар Үндсэн хуульд анхлан тусгасан эдгээр хэм хэмжээ нь 1993⁷, 2002⁸, 2012⁹, 2021¹⁰ онд батлагдсан Шүүхийн тухай хууль тогтоомжуудад дэлгэрэнгүй тусгагдаж одоог хүртэл замналыг туулж ирсэн. Шинэчлэгдэж батлагдах болгондоо шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг улам бүр баталгаатай болгох чиглэлээр ахиц гаргаж ирснийг хууль тогтоомжийн шинэтгэлийн агуулгаас харж болно.

Гэхдээ 2012 онд шүүхийн тухай хууль тогтоомжийг шинэчлэн батлах хүртэлх хугацаанд шүүхийн захиргаа нь шүүхээс салаагүй, Үндсэн хуульд заасан шүүхийн ерөнхий зөвлөл тодорхой албан тушаал эрхэлдэг орон тооны бус гишүүдээс бүрдэж, түүнийг зарим үед Улсын дээд шүүхийн дарга, ерөнхий шүүгч, зарим үед Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд даргалж ирсэн нь Шүүхийн ерөнхий зөвлөл хэрхэн бүрдэж ажиллах тухай Үндсэн хуульд тодорхой бус заасантай холбоотой байснаар тайлбарлаж болмоор байдаг.

2012 онд Шүүхийн хууль тогтоомжийг шинэчлэн батлахад Шүүхийн захиргааны тухай хуульд¹¹ Шүүхийн ерөнхий зөвлөлийг Улсын дээд шүүх, Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын аль алианаас нь тусгаарлаж бие даасан байгууллага байхаар тусгасан бөгөөд бүрэлдэхүүнийг орон тооны гишүүдээс бүрдэхээр заасан нь одоогийн Шүүхийн захиргааны бие даасан тогтолцооны эхлэл болжээ. Үндсэн хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн тухай заасныг өмнөхөөс өөрөөр тайлбарлаж хэрэглэснээр ийм боломж бүрдүүлснийг тэмдэглэх хэрэгтэй.

Энэ хуулийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийг 2013 онд орон тооны дарга болон гишүүдтэйгээр байгуулсан боловч Үндсэн хуулийн заалтыг дахиад өөрөөр тайлбарлаж хэрэглэх боломж нээлттэй үлдсэн нь асуудал дагуулж мэдэхээр байв. Шүүхийн захиргааны бүтэц зохион байгуулалтын энэ мэт тогтворгүй байдал нь тухайн байгууллагын үйл ажиллагааны чанар,

7 <https://legalinfo.mn/mn/detail?lawid=7167>

8 <https://legalinfo.mn/mn/detail/90>

9 Монгол Улсын шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиудыг баталж 2013 оноос дагаж мөрдсөн

10 <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16106892006021>

11 <https://legalinfo.mn/mn/detail/8687>



үр дүн төдийгүй шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүхийн нэр хүнд, шүүхэд итгэх олон нийтийн итгэлд хүртэл таагүй нөлөө үзүүлж байлаа.

2019 онд Үндсэн хуулийн шүүхийн тухай хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулсан. Тэр дагуу 2021 онд Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж мөрдүүлэх хүртэл үргэлжилсэн энэ үеийг Шүүх эрх мэдэл бүрэлдэн тогтох шилжилтийн үе гэж үзэж болохоор байгаа юм.

ГУРАВ. ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙГ ТОГТВОРЖУУЛАН БЭХЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Өмнө нь шүүхийн бүтэц зохион байгуулалтыг илүү үр нөлөөтэй байдлаар өөрчлөхөөр баталсан Шүүх байгуулах тухай хэд хэдэн хуулийг Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж хүчингүй болгосон нь мөн л шүүхийн бүтэц зохион байгуулалтын талаарх Үндсэн хуулийн холбогдох зохицуулалт эргэлзээ дагуулсантай холбоотой байв.

2019 онд Үндсэн хуулийн шүүхийн тухай хэсэгт шүүхийн бүтэц зохион байгуулалтыг илүү оновчтой болгох, шүүхийн захиргааны болон шүүхийн сахилгын хорооны бие даасан байдал, бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлох талаар нэмэлт өөрчлөлт оруулсан нь шилжилтийн үед тулгамдсан асуудлуудыг Үндсэн хуулийн хэмжээнд нэг мөр шийдвэрлэхэд чиглэгдсэн чухал алхам болсон.

Үүнтэй холбогдуулж шүүхийн тухай хууль тогтоомжийг нэгтгэн Шүүхийн тухай хуулийг шинэчлэн найруулж 2021 онд батлахдаа Үндсэн хуулийн энэхүү үзэл баримтлалыг баталгаажуулахын хамт ардчилсан Монгол Улсад цаашид шүүхийн салбар эрх мэдлийн хэмжээнд чухам ямар байдлаар төлөвших тухай алсын хараанд тулгуурласныг хуулийн агуулгаас харж болно.

2021 оны сүүлээс бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүн нь шүүхийн шинэтгэлийн “Шүүх эрх мэдлийн тогтворжин бэхжих” гурав дахь үе шатыг эхлүүлж байгаагаараа онцлог гэж үзэж байна. Энэ үе шатны эхэнд шүүхийн зохион байгуулалтыг илүү оновчтой болгох хуулийн төслийг Улсын Их Хуралд хэлэлцүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд энэ нь шүүхийн хөгжилд чухал өөрчлөлт авчирна гэж тооцож байгаа.

Шүүхийн шинэтгэлийн энэ үе шатны онцлог нь 2020 онд баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой салшгүй холбоотой. Энэ бол манай улсын 2050 он хүртэлх хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлсон баримт бичиг юм.

Энэхүү баримт бичгийн “Засаглал” гэсэн Тав дахь хэсгийн зорилгыг “... хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” гэж тодорхойлоод хүрэх үр дүнг үе шатаар заасан.

Хөгжлийн I үе шат буюу (2021-2030): Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлэх үе шатанд



“Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө.” II үе шатанд буюу (2031-2040): Хариуцлагатай, үр нөлөөтэй засаглалыг бэхжүүлэх үе шатанд “3.Иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн шүүхтэй болно.” III үе шат буюу (2041-2050): Урт хугацааны, тогтвортой бодлогыг дэмжсэн түншлэгч засаглалыг бий болгох үе шатанд “Хариуцлагатай, иргэн төвтэй шүүх төлөвшсөн байна.”¹² гэж тусгасан.

Энэ хөгжлийн бодлогын дагуу шүүхийн шинэтгэлийн эцсийн үр дүн нь иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн, иргэн төвтэй шүүхийг хөгжүүлэн төлөвшүүлэх явдал юм. Энэхүү алсын харааг хангах одоогийн үе шатанд бид шүүхийн бие даасан, хараат бус байдлыг бүх талаар хангах, шүүгчийн ёс зүй хариуцлагыг дээшлүүлэн зохих түвшинд хүргэх, шүүхийн үйлчилгээг иргэн төвтэй хандлагад нийцүүлэх гол зорилтуудыг өмнөө тавин холбогдох арга хэмжээнүүдийг шат дараатай авч ажиллаж байна.

Дөрөв. Шүүхээс олон нийтийн итгэлийг хүлээх байдал

Шүүхийн хөгжлийг 3 үе шат болгож авч үзсэний эхний хэсгийн ихэнх хугацаа нь манай улс коммунист намын үзэл сурталд захирагддаг, нэг намын бодлогыг үг дуугүй дагаж биелүүлэх зорилгоор нийгмийн амьдралыг бүхэлд нь хянаж, тулган хүлээлгэх аргаар зохицуулдаг тоталитар дэглэм бүхий төрийн тогтолцоо, удирдлагатай байсан үед хамаарна. Энэ үед шүүх олон нийтийн итгэлийг хүлээх асуудал тийм ч чухалд тооцогдож байгаагүй бөгөөд үзэл суртлын хувьд эсрэгээр нийгмийн шударга ёсны баталгаа нь шүүх мөн гэдэгт итгэдэг байх ёстой гэсэн шаардлагыг иргэний үүрэг гэж үзэх тал нь давамгайлж байлаа.

Шүүхийн хөгжлийн 2 дахь үе шатнаас, өөрөөр хэлбэл 1990-ээд оны эхнээс манай улс ардчилсан хөгжлийн замналыг сонгосонтой холбоотойгоор шүүх төрийн эрх мэдлийн хэмжээнд бие дааж ажиллах, шийдвэрээ хараат бусаар гаргах, бүх үйл явц олон нийтийн хяналтад байж нийгмийн шударга ёсны үнэлэмж иргэдийн сэтгэл ханамжаас хамаарах тухай ойлголт, хандлага бий болсон нь бидний хувьд шинэ зүйл байв. Шүүхээр шийдвэрлэгдэх хэрэг маргааны шинж, шүүхийн талаарх олон нийтийн хандлага өмнөх нийгмийнхээс ийнхүү огцом өөрчлөгдсөн нь шинэтгэлийг аль болох хурдтай хийж нийгмийн шударга ёсны эрэлт хэрэгцээг энэхүү шинэ нөхцөлд байдалд нийцүүлэн хангах асуудал шүүхийн салбарын өмнө тавигдсан. Үүнтэй холбоотой урьдчилан тооцох боломжтой, боломжгүй олон сорилтуудтай тулгарч, тэдгээрийг даван туулах ёстой болсон нь одоо хүртэл үргэлжилж байна.

Олон нийтийн итгэлийг хүлээхийн тулд шүүх хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ зөвхөн хуульд захирагдаж, шударга ёсонд нийцсэн шийдвэр

12 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол



гаргах, шийдвэр нь ил тод байх, тийнхүү шийдвэрлэснийхээ учир холбогдлыг олон нийтэд ойлгогдох хэлбэрээр мэдээлэх, шүүгч ёс зүй, сахилга хариуцлагын талаар эргэлзээ төрөхгүй хэмжээнд ажлаа зохион байгуулж, зан үйлээрээ манлайлах, шүүхийн мөн чанар, үйл ажиллагаа, нийгмийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлах ажлыг өнгөрсөн хугацаанд шүүх, шүүхийн захиргааны зүгээс чамгүй явуулж ирсэн. Гэвч үүний үр дүн төдийлөн сайнгүй байгаа нь эдгээр арга хэмжээг явуулж байгаа арга хэлбэр нь үр нөлөө багатай байгаатай холбоотой. Нөгөө талаар шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг сулруулах, шүүхэд нөлөөлөх гэсэн оролдлого, халдлагыг олон нийтэд сөрөг ойлголт түгээх хэлбэрээр явуулдаг зүй бус үйл ажиллагаа нийгэмд түгээмэл байгаатай ч холбоотой. Бас шүүх эрх мэдэл олон нийтийн итгэлийг өндөр түвшинд олж төлөвшсөн улсуудынхтай харьцуулбал манай шүүхийн хөгжил харьцангуй саяхнаас тодорхой үе шатуудыг дамжин урагшилж байгаа гэдгийг тооцохгүй байж болохгүй.

Ямар ч байсан олон улсын болон үндэсний судалгааны эх сурвалжуудаас гаргаж байгаа шүүхэд итгэх олон нийтийн итгэл одоогийн түвшинд тааруу байгаа тухай үнэлгээний шалтгаан, үндэслэлийн талаар бид бодитой дүгнэлт хийх нь цаашид хөгжиж дэвших арга замаа тодорхойлоход маш чухал. Шүүх шударга гэдгээ харуулах, энэ талаарх бодит мэдээллийг нийгэмд хангалттай хэмжээнд түгээж, шүүхийн үйлчилгээг олон нийтэд хүргэх ажлыг аливаа зүй бус нөлөөлөлд орон зай үлдэхгүй хэмжээнд зохион байгуулах нь шүүх болон шүүхийн захиргааны үүрэг юм. Энэ талаар бид үндсэн эргэлт гаргах ёстой.

Тав. Нэн тэргүүнд авах арга хэмжээ

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “5.1.9. Шүүх үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгоно. 5.1.10. Ёс зүй, цогц чадамжтай шүүхийн хүний нөөц бэлтгэх суурь тогтолцоог бий болгож, төгөлдөржүүлнэ. 5.1.11. Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж, шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгон үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлнэ.”¹³ гэж заасантай энэ талаарх бодлого үйл ажиллагаагаа нягт уялдуулж хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг бодитой хангахад чиглэгдсэн цогц арга хэмжээг төлөвлөж шат дараатай авах.

Өмнөх үе шатанд байсан шүүхийн тогтолцоо, үйл ажиллагааны өнөөгийн байдал, туулж ирсэн ололттой, дутагдалтай асуудалд бодитой дүн шинжилгээ хийж, цаашид урт хугацаанд шүүхийн хөгжлийг тогтвортой хангаж чадахуйц байдлаар шүүхийн болон шүүхийн захиргааны одоогийн тогтолцоог өөрчлөн байгуулах.

Шүүхийн бие даасан байдлыг эдийн засгийн агуулгаар хангах, шүүхийн үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд төсөв санхүүгийн хувьд

13 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



хүрэлцээтэй байх тухай хууль тогтоомжийн заалтыг олон улсын жишиг¹⁴ хандлагад нийцүүлэн нэг мөр шийдвэрлэх.

Шүүхийн болон шүүхийн захиргааны хүний нөөцийн сонгон шалгаруулалт, сургалт хөгжлийн өөр хоорондоо нягт уялдсан нэгдмэл тогтолцоог буй болгож хүний нөөцийн ёс зүйтэй, цогц чадамжтай байх шаардлагыг хангахад чиглэгдсэн үр нөлөөтэй арга хэмжээг аль болох иж бүрэн хэмжээнд тооцож хэрэгжүүлэх.

Шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэрийн ил тод байдлыг хангаж, энэ тухай мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой байх, шүүхийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх талаар дээр дурдсан “Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах хөтөлбөр”-ийг шинээр боловсруулан баталж мөрдөх.

Шүүхийн салбарт мэдээллийн технологийн ололтуудыг өргөн нэвтрүүлж, шүүхийн болон шүүхийн захиргааны ажлын ил тод, шуурхай байдлыг хангах үүднээс Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 онд баталсан “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого”-ыг¹⁵ хэрэгжүүлэх ажлыг оролцогч талуудтай хамтран богино хугацаанд зохион байгуулж, үр дүнд хүргэх.

Шүүхийн шинэтгэлийн одоогийн үе шатны зорилтуудыг хангахад гадаадын улс орнуудын туршлага, хамтын ажиллагаа, дотоодын бусад оролцогч нарын дэмжлэг, туслалцаа, нөөц боломжид тулгуурлан, шүүхийн болон шүүхийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайтар хангаж ажиллах.

Шүүхийн шинэтгэлийн нэн чухал үе шатанд шийдвэрлэхээр төлөвлөн хүчин чармайлт гаргаж байгаа эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд “Хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх ба шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх нь” гэсэн сэдвээр зохион байгуулагдаж байгаа энэхүү Олон улсын бага хурал онол, арга зүйн хувьд, цаашдын хамтын ажиллагаанд чухал хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна.

14 НҮБ-ын Конгресс 1985 оны 9 дүгээр сарын 6-нд баталсан “Шүүхийн бие даасан байдлын суурь зарчмууд”

15 “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах тухай” Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 332 дугаар тогтоол

